

Парламентчдад зориулсан гарын авлага №9 2005

Хүүхэд худалдах гэмт хэрэгтэй тэмцэх нь

Парламентуудын Холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан

Өмнөх үг

Хүүхдийг худалдаж авах, худалдах, гэрээс нь хол тээвэрлэх явдал өдөр болгон тохиолдож байна. Хүн худалдах гэмт хэрэг нь олон тэрбум доллараар хэмжигдэх бизнес бөгөөд улам газар авсаар.

Хүүхэд худалдах нь хууль бус. Түүгээр ч үл барам худалдагдсан хүүхдүүд бие махбодийн болон бэлгийн хувьд мөлжүүлдэг тул маш их хор уршигтай. Хүүхэд худалдах явдал нь гэмт хэрэг бөгөөд хууль тогтоогчид болон төрийн байгууллагын ажилтнууд уг асуудлыг хүлээн зөвшөөрч хор уршгийг нь ухамсарлахад бэрхтэй байдаг учир энэ талаар бодитой мэдээлэл олоход хэцүү байдаг.

Та бүгд парламентчдийн хувьд өөрийн улс орон болон дэлхий дахин дахь хүүхэд худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлж хариу арга хэмжээ авахад ихээхэн нөлөөтэй байж чадна.

Хүүхэд худалдах гэмт хэргийг дуусгавар болгох дэлхий дахины тэмцэлд онцгой ахиц гарч байна. Үүнд олон улсын конвенциор хүн худалдах гэмт хэргийг тодорхойлж, уг гэмт явдлыг дуусгавар болгох хууль зүйн арга хэмжээг бий болгож, хөгжингүй буюу хөгжиж буй орнуудад холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг хийж, улс хоорондын болон олон улсын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор олон талт гэрээнүүдийг байгуулсан явдлууд хамаарна. Түүнчлэн, хүүхдүүд өөрдсөө хүн худалдах гэмт хэргээс үүдсэн хор уршиг болон аюулгүй орчны шаардлагын талаар дуу хоолойгоо хүргэсэн билээ.

Гэсэн хэдий ч хүүхэд худалдах гэмт хэргийг үгүй хийх явдлыг бодитой хэрэгжүүлэхэд маш олон ажлууд хүлээгдэж байна.

Парламентуудын Холбоо болон НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтын хөдөлмөрөөр бүтсэн энэхүү гарын авлага нь хүүхэд худалдах гэмт хэргийг дуусгавар болгоход парламентчдийн зүгээс авч болох гол арга хэмжээнүүдийг багтаасан юм. Хууль, бодлого, бусад дэмжлэг багтаасан тодорхой алхмуудыг парламентчдад энэ жигшүүрт явдлаас хүүхдүүдийг аюулгүй байлгах үйлсэд нь санал болгож байгаа билээ.

Бидний хүүхдүүд бидний чин хүчин чармайлт хэрэгтэй байна. Парламентчдийн хувьд хүүхдүүдэд байхгүй эрх мэдэл та бүхэнд байна. Дэлхий даяар хүн худалдах гэмт хэрэг гэгч хар дарсан зүүдэнд ороогдсон олон хүүхдийн амьдралд насан туршид нь гэрэлтэх өөрчлөлтийг та бүгд л хийж чадна.

Андерс Б.Жонсон

Ерөнхий нарийн бичгийн дарга

Парламентуудын холбоо

Карол Беллами

Гүйцэтгэх захирал

НҮБ-ын Хүүхдийн Сан

Агуулга

Өмнөтгөл.....7

Нэгдүгээр Хэсэг Асуудлыг тодорхойлох нь

Нэгдүгээр бүлэг Хүн худалдах гэмт хэрэг гэж юу вэ?.....11

Хоёрдугаар бүлэг Ямар хүмүүсийг ямар зорилгоор худалдаж байна вэ.....13

Гуравдугаар бүлэг Хүн худалдах явдлын хүүхдэд үзүүлэх нөлөө.....16

Дөрөвдүгээр бүлэг Хүүхдийг эрсдэлд оруулдаг хүчин зүйлс.....17

Хоёрдугаар Хэсэг Хүүхдийн аюулгүй орчин: Үйл ажиллагааны төлөвлөгөө

Тавдугаар бүлэг Хүүхдийн аюулгүй орчин: Ерөнхий дүр зураг.....23

Зургаадугаар бүлэг Аюулгүй байх эрхийг хангах төрийн үүрэг.....26

Долоодугаар бүлэг Хууль тогтоомж, түүний хэрэгжилт.....33

Наймдугаар бүлэг Хандлага, уламжлал, хэвшил.....40

Есдүгээр бүлэг Асуудлыг хөндөж, ойлголтыг нэмэгдүүлэх нь.....42

Аравдугаар бүлэг Хамт олон, өрхийн чадавхийг сайжруулах нь.....45

Арван нэгдүгээр бүлэг Хүүхдийн оролцоо.....49

Арван хоёрдугаар бүлэг Хяналт хэрэгжүүлэх ба тайлагнах.....51

Арван гуравдугаар бүлэг Эдгээх, нөхөн сэргээх үйлчилгээ.....53

Гуравдугаар Хэсэг Үндсэн зөвлөмжүүд болон зохих эрх зүйн зохицуулалтын загвар

Арван дөрөвдүгээр бүлэг Үндсэн зөвлөмжүүд.....63

Арван тавдугаар бүлэг Зохих эрх зүйн зохицуулалтын загвар.....65

Хавсралт

Хавсралт А Хоёр талт гэрээний загвар /Мали, Зааны ясан эрэг/.....71

Хавсралт Б Харилцан ойлголцлын Санамж бичиг/Их Меконг бичиг дүүрэг/.....73

“Хүүхдүүдээ тавих анхаарлаас илүү бидний засаглалын чанарыг хэмжих хэмжүүр байхгүй бөгөөд хүүхдүүдээ хүчирхийлэл, доромжлолд өртүүлэхээс гутамшигтай зүйл бидэнд үгүй...Парламентчдад дэлхий дахины сая сая хүүхдүүдийн зовлон зүдгүүрийг арилгах эрх мэдэл бий, түүнийгээ л хэрэгжүүлэх л шаардлагатай.”

2004 оны 4-р сарын 20-ны өдөр Мехико хотод болсон Парламентын Холбооны 110 дахь Чуулганд НҮБ-ын Хүүхдийн Сангийн Элчин сайд Жессика Ланжийн хэлсэн үгнээс.

Хүүхэд худалдах гэмт хэрэг нь бүх улс орон, бүс нутгуудыг олон улсын гэмт хэргийн нэгэн сүлжээнд хамруулдаг. Жил бүр хүүхдүүдийг бараа, бүтээгдэхүүн мэт хууль бусаар хил давуулж байна. Зарим хүүхдүүдийг өөрийнх нь улс орон дотор нь ихэнхдээ хөдөөнөөс хот руу худалдаж байна. Хүн худалдах гэмт хэрэг нь олон улсын эрх зүйгээр, тэр дундаа НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенциор хүүхдэд олгогдсон хүний эрхүүдийг зөрчдөг. Энэ нь хүүхдийн амьд явах, хөгжих боломжид заналхийлж, боловсрох, эрүүл байх, аюулгүй орчинд байх эрхүүдийг нь үгүйсгэдэг.

Үндэстэн дамнасан гэмт хэргүүдээс хамгийн их хурдацтай өргөжин тэлж, хөлжиж буй хүн худалдах гэмт хэрэг нь жилд ойролцоогоор 10 тэрбум ам.долларын ашигтай байдаг¹. Хар тамхи наймаалах явдалтай тэмцэх хууль зүйн, улстөрийн оролдлогуудын хариуд хар тамхины наймаанд оролцдог гэмт хэргийн сүлжээнүүд нь өөрсдийн хүний нөөцөө хүн худалдах явдалд төвлөрүүлэх болсон. Энгийнээр хэлэхэд хүнийг худалдаж авч, зарах “зардал” нь төдийлөн өндөр биш бөгөөд хар тамхи, галт зэвсгийн наймаанаас бага эрсдэл хүлээдэг байна². Хүн худалдах явдал ямар нэгэн байдлаар явагдаж байгаа бүх улс орнууд энэ аюултай явдлыг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээ авах ёстой.

Хүн худалдах санаачилга, алхмуудыг цаашид хөгжүүлж, хэрэгжүүлэхэд шаардлагатай улстөрийн болоод хууль, эрх зүйн орчинг бий болгоход Парламентчид онцгой байр суурь эзэлнэ. Тэдэнд хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай нөөц бололцоог хуваарилах эрх мэдэл бий бөгөөд төр засгийн түвшинд энэ асуудалд ач холбогдол өгөхөд нь түлхэц болж чадна.

Хүн худалдах гэмт хэргийг арилгах явдалд уг гэмт явдлын эх үүсвэр болсон, түүнчлэн, дамжин өнгөрөх болон эцсийн цэг болох улс орнууд хоорондын хамтын ажиллагаа чухал ач холбогдолтой юм. Цуглуулагчид, зуучлагчид, хүүхдийг мөлжигдийн аль нь ч бай бүх гэмт этгээдүүдтэй улс орнууд хариуцлага тооцох

¹, НҮБ дахь Байнгын Ажиглагч Далл Оглио Лукагийн 2004 оны 10-р сарын 12-ны өдөр Нью Йорк хотноо НҮБ-ын Ерөнхий Ассамблейд хэлсэн үгнээс.

² НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Арлаччи Пиногийн 2000 оны 11-р сарын 28-29-ны өдрүүдэд болсон Хүн худалдах гэм хэргийн талаарх Олон улсын Семинарын Нээлтэд хэлсэн үгнээс. [http://www.unodc.org/unodc/speech_2000-11-28_1.html, February 2005].

ёстой. Улс орон дотор явагдаж буй хүн худалдах гэмт хэргийг дэлхийн дахины хэмжээний уг гэмт явдлаас багад тооцож болохгүй. Хохирогчдыг хамгаалах, тэдэнд тусламж үзүүлэх нь хүн худалдах гэмт хэргийн эсрэг аливаа арга хэмжээнээс илүү чухал юм. Хүн худалдах гэмт хэргийн эсрэг аливаа үйл ажиллагаа, тэр дундаа хуулийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа нь хохирогчдийг цаашид ч хохироох байдал, заримдаа бүр эрүүгийн хэрэгт ч холбогдох нөхцлийг бий болгодог. Хуулиудыг хэрэгжүүлэх, хянах аливаа механизмгүйгээр хүн худалдах гэмт явдлын эсрэг авагдах хууль зүйн арга хэмжээ үр дүнтэй байж үл чадна.

Энэ удирдамж нь парламентчдад дараахь асуудлаар зөвлөмж дэвшүүлсэн болно:

- Хүүхдийг худалдах явдлаас урьдчилан сэргийлэх
- Хүүхэд худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд тусламж үзүүлэх
- Хүний худалдаа хийдэг этгээд, тэдгээрийн хамсаатнуудыг үйлдсэн гэмт хэргийнх нь төлөө хариуцлага хүлээлгэх.

Түүнчлэн хүн худалдах явдлын “нийлүүлэлт”-ийг зогсоож, “эрэлт”-ийг нь багасгахад чиглэсэн парламентчдийн авах арга хэмжээг тусгасан болно. Хүн худалдах гэмт явдалтай тэмцэх хууль тогтоомж, бодлого боловсруулсан орнуудын туршлагааар дэвшүүлсэн зөвлөмжүүдээ баталгаажуулсан болно. Улам бүр газар авч буй энэ үзэгдэлтэй улс орнууд хэрхэн харилцан адилгүй аргаар тэмцсэнийг эдгээр туршлага, жишээнээс харж болно. Энэ нь зөвхөн амжилтанд хүрсэн туршлагуудыг жагсаасан бус харин дэлхий дахинд авагдсан арга хэмжээнүүдийн түүвэр юм. Аль нэг улс орны хууль, бодлогыг энд дурьдсан нь тэрхүү арга хэмжээг нь илүүтэй дэмжиж байгаа гэсэн үг биш юм.

Гарын авлага нь үндсэн гурван хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр хэсэгт хүүхэд худалдах үзэгдлийг тайлбарлана. Хоёрдугаар хэсэг нь хүүхэд худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлж, тэмцэхэд шаардлагатай аюулгүй орчны асуудал дээр төвлөрөх бөгөөд харин гуравдугаар хэсэг нь хүүхэд худалдах гэмт хэрэгтэй парламентчид тэмцэхдээ авч болоох арга хэмжээг нэгтгэн дурьдсан болно.

Нэгдүгээр хэсэг

Асуудлыг тодорхойлох нь

Нэгдүгээр бүлэг

Хүн худалдах гэмт хэрэг гэж юу вэ?

Хүн худалдах явдлыг анх 2000 оны Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын Конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа Эмэгтэйчүүд, Хүүхдүүдийг худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай НҮБ-ын Протоколд зааснаар олон улсын эрх зүйд тодорхойлсон. Үүнийг өөрөөр “Палермогийн Протокол” буюу “Хүн худалдах явдлын протокол” гэдэг бөгөөд хүн худалдах явдлын хамгийн өргөн хэрэглэгддэг тодорхойлолтыг бий болгосон төдийгүй үндэсний эрх зүйн шинэтгэлийн суурь болж өгдөг гэж үздэг.

Палермогийн протоколд Хүн худалдах явдлыг дараахь байдлаар тодорхойлсон:

Гуравдугаар зүйл

а/ Хүн худалдах гэдэг нь мөлжлөгийн зорилгоор хүч, албадлагаар хэрэглэж буюу хэрэглэхээр, хулгайлах, хууран мэхлэх, албан тушаал байдлаа буюу давамгай байдлаа урвуулах, төлбөр тооцөө, өр авлагын байдлыг ашиглан давамгай байдал тогтоон хүнийг олох, тээвэрлэх, шилжүүлэх, хүлээн авахыг хэлнэ. Мөлжлөгт ядаж бусдыг биеэ үнэлүүлэх буюу бэлгийн мөлжлөгийн бусад хэлбэр, хүчээр хөдөлмөрлүүлэх, боочлол буюу түүнтэй адилтгах үйл ажиллагаа, зарцлал болон эд эрхтнийг авах зэрэг хамаарна.

б/ энэ зүйлийн а хэсэгт заасан арга хэрэгслийг хэрэглэсэн тохиолдолд а хэсэгт заасан мөлжлөгийг хүн худалдах гэмт хэргийн хохирогч хүлээн зөвшөөрсөн эсэх нь үл хамаарна.

в/ Хүүхдийг олох, тээвэрлэх, шилжүүлэх, хүлээн авч хорих үйлдлийг “хүн худалдсан” гэж үзэх ба ннэ зүйлийн а хэсэгт заасан аргыг хэрэглээгүй нь нөлөөлөхгүй.

г/ “Хүүхэд” гэдэг нь 18-аас доош насны хүнийг хэлнэ.

“Хүч, албадлагаар хэрэглэж буюу хэрэглэхээр, хулгайлах, хууран мэхлэх, албан тушаал байдлаа буюу давамгай байдлаа урвуулах, төлбөр тооцөө, өр авлагын байдлыг ашиглан давамгай байдал тогтоох” нь хүүхэд худалдах гэмт хэргийн бүрэлдэхүүн байх албагүй гэдгийг тодорхойлолтод тодорхой тусгасан байна.

Хүн худалдах гэмт хэргийн эсрэг үндэсний хууль тогтоомж нь зөвхөн үндэстэн дамнасан хүн худалдах гэмт хэргээр хязгаарлагдахгүй байх нь чухал. Хүүхдийг нэг улс орон дотор, ихэнхдээ хөдөөний бөглүү газраас хот суурин газар руу худалддаг. Төр засгаас хүн худалдах гэмт хэргийг тодорхойлохдоо зөвхөн үндэстэн дамнасан тохиолдлыг хамруулсан жишээ олон байдаг бөгөөд ингэснээрээ улс орны дотоодод худалдсан сая сая хохирогчдыг ямар ч эрх зүйн хамгаалалтгүй орхидог. Энэ нь тухайн улсад тулгараад буй хүн худалдах гэмт хэргийн хэр хэмжээг нь бууруулж харагдуулдаг. Аливаа улсын хилийн дотор явагдаж буй хүн худалдах гэмт хэрэгтэй холбоотой маш олон ажил хүлээгдэж байна.

Протоколыг Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн ерөнхий агуулгын хүрээнд тайлбарлан ойлговол зохино. Конвенцийн 35 дугаар зүйлд багтаасан аливаа зорилго хэлбэрээр хүүхдийг худалдах явдлыг хамруулахгүйгээр тодорхойлолт учир дутагдалтай болно³.

Хоёрдугаар бүлэг

³ НҮБ-аас баталсан Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн 35 дугаар зүйлийн а, б, в хэсгүүд.

Ямар хүмүүсийг ямар зорилгоор худалдаж байна вэ?

Хэдийгээр эмэгтэйчүүд болон зарим тохиолдолд эрэгтэйчүүдийг худалддаг ч, энэхүү гарын авлагад нь хүүхдийн асуудалд хамааралтай урьдчилсан арга хэмжээ, хууль тогтоомжийн зөвлөмжүүдийг тусгасан юм.

Чухамдаа орчин үед худалдагдаж буй хүүхдийн тоон багцаа байхгүй байгаа юм⁴. Гэсэн хэдий ч, нэгэн тоо баримтын дагуу дэлхийн хэмжээнд худалддаг хүмүүсийн 50 хувь нь хүүхдүүд байдаг байна⁵. Хүүхэд худалдах явдлын талаарх мэдээлэл дутуу, дульмаг байдаг олон шалтгаан бий. Хүн худалдах гэмт хэрэг нь хууль бус үйл ажиллагаа бөгөөд нууцаар явагддаг. Хохирогчид өөрсдийгөө илчлэхээсээ айж эмээдэг тул тодорхой тоо баримт цуглуулахад хүндрэлтэй байдаг. Түүнчлэн, хүн худалдах явдлын хохирогчдыг тоолох нэгдсэн арга зүй байдаггүй. Олон улсын эрх зүйн тодорхойлолтын дагуу худалдаалагдсан хүнийг тогтоох нийтлэг шалгуурыг ч түгээмэл хэрэглэдэггүй. Статистик тоо баримтад улсын дотоодод худалдаалагдсан хүмүүсийг хамааруулахгүй байх, нийт хохирогчдыг нас хүйсээр нь ялгахгүй байх нь элбэг.

Худалдагдсан хүүхдүүдийг нарийвчлан тогтоогоогүй ч, маш ихээр худалдагдаж байгаа нь тодорхой бөгөөд уг явдал цаашид дэлгэрэх хандлагатай байна. Парламентчид энэ талаар яаралтай арга хэмжээ авснаар энэ эмгэнэлт явдлыг эргүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна.

Хүүхдүүдийг дараахь мөлжлөгийн шинжтэй үйл ажиллагаанд худалдаж байна:

Хөдөлмөрийн мөлжлөг: Тариалангийн талбай, уурхай зэрэг химийн бодис, хорт бодис, аюултай машин механизм ажиллуулах бусад аюултай нөхцөлд ажиллуулахаар хүүхдүүдийг худалддаг. Эцсийн цэг болох улсад тэднийг хорионд байлгадаг ба тэд уг мөлжлөгийн талаар эрх бүхий байгууллагад хандахаасаа айж эмээдэг.

Зарим тохиолдолд хүүхдүүдийг барьцааны хэлбэрээр хөдөлмөр хийлгэх зорилгоор худалддаг. Ихэнхи тохиолдолд гэр бүл нь урьдчилгаа төлбөр авдаг ба дийлэнхдээ “зардал”, “хүү”-г хүүхдийн олсон мөнгөнөөс нь их хэмжээгээр суутгах маягаар авдаг тул өрийг барагдуулах буюу уг хүүхдийг “эргүүлж худалдаж авах” боломжгүй болдог байна.

⁴ Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас 2002 онд 1.2 сая хүүхэд дэлхийн хэмжээнд худалдаалагдсан байна гэж тооцоолсон байна. Үүнийг Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан ILO/IPEC: Every child counts, New Global Estimates on Child Labour /Хүүхэд бүр үнэтэй: Хүүхдийн хөдөлмөрийн талаарх дэлхий дахины тоо баримт/, Женев хот, 2002 он, 27 дугаар хуудас гэсэн тайланд тусгажээ.

⁵ АНУ-ын Төрийн департамент, Trafficking in Persons Report /Хүн худалдах явдлын талаарх судалгааны тайлан/ 15 дугаар хуудас, 2004 оны 6 дугаар сар.

Гэрийн хөдөлмөр: Олон улсын Хөдөлмөрийн байгууллага нь гэр ахуйн хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь охид байдаг хэмээн тооцоолжээ⁶. Эцэг эх, хүүхдүүдийг боловсрол, сайн ажилтай болгоно гэсэн амлалтаар татдаг байна. Нэгэнт худалдагдсан тохиолдолд тэдний баримт бичгийг нь хурааж, ямар ч тусламж авах боломжгүй болгох нь элбэг байдаг. Аюулгүй байдал, хоол хүнс, орон байр савны хувьд тэд зөвхөн мөлжүүлж байгаа этгээдүүддээ найдахаас өөр арга байдаггүй бөгөөд хөдөлмөрийн хүнд нөхцөлд байдаг.

Бэлгийн мөлжлөг: Хүүхдүүд, тэр дундаа охидыг янхны газар, массаж иллэгний газар, янхны сүлжээ болон тайчих цэнгээний газар ажиллуулахаар буюу садар самуун материал хийхэд ашиглахын тулд худалдаалдаг байна. Чухамдаа тодорхойлон хэлэх боломжгүй ч, Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас 2000 оны хувьд 1.8 сая хүүхдийг сексийн салбарт мөлжихөөр худалдаалсан гэж үзэж буй⁷ бөгөөд худалдаалагчид, худалдагч эзэд болон “үйлчлүүэгчид”-ийн зүгээс тэдгээр хүүхдүүдийг биеийн, бэлгийн болон сэтгэл зүйн хувьд балмадаар хүчирхийлдэг ажээ.

Цэргийн алба: Дэлхийн бүс бүрт өрнөж буй буюу ойрын үед болсон 30 гаруй зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг ашигласан гэсэн тооцоо байдаг⁸. Зарим хүүхдүүд ядуурал, доромжлолоос болж өөрсдөө цэрэгт элсдэг байхад заримыг нь хүчээр элсүүлэх буюу булааж авдаг. Мөргөлдөөн дэх хүүхдийн оролцоо харилцан адилгүй байдаг. Мэдээ дамжуулагч, ачаа зөөгч, тогооч, бэлгийн үйлчилгээ үзүүлэгч “эхнэр” болон тулалдагчаар оролцуулдаг. Ядуу, гэр бүлээсээ тусгаарлагдсан, гэрээсээ дайжсан, дайн тулааны бүсэд амьдардаг, боловсрол хүртэх боломж хязгаарлагдмал болон өнчин хүүхдүүд цэргийн албанд орох нь элбэг байдаг⁹.

Гэрлэлт: Охидыг эхнэр болгохоор худалдаалдаг нь олон шалтгаантай байдаг. Ядуурал дээд цэгтээ тулахаар охидыг гэр бүл нь эдийн засаг хувьд хүндрэл учруулж буй хэмээн үзэж, ахмад хүнтэй гэрлүүлэх нь гэр бүлийг тэжээх гарц гэж тооцдог нь бий. Зарим тохиолдолд эрэгтэй шилжин суурьшигч нар нутгаасаа эхнэр авахыг хүсдэг нь хүүхдийг гэрлүүлэх зорилгоор худалдахад хүргэдэг. Ялангуяа ХДХВ/ДОХ-ын халдварын эрсдэл өндөр газрын ахмад эрэгтэйчүүдийн дунд залуу, онгон эхнэр хүсэх нь түгээмэл болж байна. Зарим тохиолдолд гэр бүлийн зүгээс охидыг эрт гэрлэхийг дэмждэг нь ингэснээр охид нь ХДХВ-ээс ангид байна гэж ташаа

⁶ Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтгүй ирээдүй хэмээн 2002 оны тайлангийн 29 дүгээр хуудас.

⁷ Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага, Хүүхдийн Хөдөлмөрийн устгах Олон улсын Хөтөлбөрөөс хамтран гаргасан Facts on Commercial sexual exploitation of children /Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаарх бодит байдал/ хэмээнх тайлан. [www.ilo.org/childlabour, February 2005]

⁸ НҮБ-ын Хүүхдийн Сангаас гаргасан Fact Sheet: Protection and Conflict, Бодит байдал: Аюулаас хамгаалах болон Зөрчилдөөн хэмээх тайлан. [www.unicef.org, February 2005]

⁹ Дээрхитэй ижил.

ойлгодогтой холбоотой¹⁰. Төв болон баруун Африкт эрт гэрлэлт нь түгээмэл байдаг ба тус бүр 19 нас хүртэлх охидынх нь 40, 49 нь эрт гэрлэсэн байдаг байна¹¹.

Хууль бус үрчлэлт: Хүмүүсийн дунд хүүхэд үрчлэх хүсэл нэмэгдсэн нь нярай болон бага насны хүүхдүүдийг хууль бусаар худалдах явдлыг нэмэгдэхэд нөлөөлж байна. Зарим тохиолдолд хөгжиж буй орнуудын эхчүүд нярай болон бага насны хүүхдээ худалддаг бөгөөд бусад тохиолдолд нярай хүүхдийг хулгайлж эхэд нь амьгүй нярай төрсөн гэж хэлдэг байна.

Спорт: Хүүхдийг, тэр дундаа бага насны эрэгтэй хүүхдийг уралдааны тэмээ унуулахаар худалдсан явдал бий. Уг спорт нь газар авч байгаа бөгөөд хүүхдүүд жижиг биетэй байдаг учраас үүнд ихээхэн тохиромжтой байдаг байна. Тэмээний уралдаанд бага насны хүүхдийг оролцуулах нь нэн аюултай бөгөөд уг спорт нь хүнд гэмтэл төдийгүй үхэлд хүргэж болзошгүй юм. Уралдаанд хожигдсон эрэгтэй хүүхдүүдийг мөлжигчид болох эзэд нь дарамталж, цалин, хоол хүнсийг өгөлгүй бие махбодийн болон сэтгэл зүйн хувьд доромжилдог байна.

Гуйлга: Гуйлга гуйх, гудамжинд юм худалдах зэргээр бусдад мөнгө олуулахын тулд хүүхдүүдийг олж худалдаалдаг. Зарим тохиолдолд гуйлга гуйж буй хүүхдүүдийг өрөвдүүлж илүү их мөнгө олуулахын тулд зэрэмдэг болгодог.

Эд эрхтэний зорилго: Эд эрхтэний худалдааг Палермогийн Протоколд тусгайлан заасан тусгасан байдаг. Энэхүү аймшигт үйл ажиллагааг илрүүлэх, хянах боломж бараг байдаггүй ч энэ тухай мэдээлэл ирдэг байна. Энэхүү нууцлагдмал үзэгдлийн талаар парламентчид мэдэж байх нь зүйтэй.

Гуравдугаар бүлэг

Хүн худалдах гэмт хэргийн хүүхдэд үзүүлэх нөлөө

Хүн худалдах гэмт хэрэг нь хүүхдийн эрүүл өсөн торних, үр өгөөжтэй, урамтай, эрхэмсэг амьдрах эрхүүдийг нь зөрчдөг. Хүүхэд худалдах явдлын хохирогчдийг гэмт этгээдүүд болох худалдаалагчид, ажил олгогчид, худалддаг эзэд, дарангуйлж, янхын газрын эзэд болон “үйлчлүүлэгчид” дарангуйлж, биеийг нь доромжилдог. Худалдагдсан хүүхдүүд ихэнхдээ зодуулж, доромжлуулсан байдаг ба худалдах үйл явцлын бүхий л үед хүчирхийлэл явагддаг.

¹⁰ ЮНАЙДС/НҮБ-ын Хүн амын Сан, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн Сангаас хамтран гаргасан Women and HIV/AIDS: Confronting the Crisis буюу Эмэгтэйчүүд ба ХДХВ/ДОХ: Хямралтай тэмцэх нь хэмээх 2004 оны тайлангийн 51 дүгээр хуудас.

¹¹ НҮБ-ын Хүүхдийн сан, Innocenti судалгааны төвийн хамтарсан Trafficking in Human Beings, Especially Women and Children, in Africa буюу Африк дахь Хүн худалдах гэмт хэрэг, тэр дундаа Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах явдал хэмээх 2003 оны тайлан судалгааны 6 дугаар хуудас.

Сэтгэл зүйд үзүүлэх нөлөө

Худалдагдсан хүүхдүүд ичиж, гэмшиж, өөртөө итгэлгүй болсоноо хуваалцсан бөгөөд ихэнхдээ гутдаг байна. Түүнчлэн гэмт этгээд нь өөрийнх нь итгэл хүлээлгэсэн хүн байсан тохиолдолд хууртаж доромжлуулсанаа ойгож гутардаг байна. Эдгээр хүчин зүйлс болоод худалдагдсан үедээ амссан зовлон нь хар дарах, нойргүйдэх, итгэл найдваргүй болох, сэтгэл санаагаар унахад хүргэдэг. Худалдагдсан хүүхдүүдийн зарим нь сэтгэл зүйн зовлонгоо мэдрэхгүйн тулд хар тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг бөгөөд мөн зарим нь амиа хорлохыг оролддог байна¹².

Бие махбодид үзүүлэх нөлөө

Сексийн зорилгоор худалдагдсан хүүхдүүд бэлгийн замын халдварт өвчин, ХДХВ/ДОХ тусах магадлал өндөр байдаг. Зарим орнуудад онгон охинтой хавьтсанаар ХДХВ/ДОХ-ыг эдгээдэг гэх аюултай бөгөөд ташаа ойлголт байдаг нь бага залуу охидын эрэлтийг нэмэгдэхэд хүргэсэн байна. Олон эмэгтэйчүүд, охид “үйлчлүүлэгчид” бэлгэвчгүйгээр хавьтахын тулд илүү мөнгө төлдөг болон тэд өөрсдөө, ялангуяа охид ихэнхдээ бэлгэвч хэрэглэхийг шаардах боломжгүй байдаг тухай ярьсан байдаг. Гэрийн үйлчлэгчид, гудамжны хүүхдүүд, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд болон хоригдож буй хүүхдүүд бэлгийн мөлжлөг болон хүчингийн гэмт хэрэгт өртөх, ХДХВ/ДОХ тусах эрсдэл өндөр байдаг.

Нийгэм-сэтгэл зүйд үзүүлэх нөлөө

Худалдагдсан хүүхдүүд нийгмийн харилцаа болон боловсролын хөгжилдөө сөрөг үр дагаварыг амсдаг. Тэдгээрийн олон нь гэр бүлийн амьдралгүй байдаг бөгөөд бага наснаасаа хөдөлмөрлөж ирсэн байдаг. Сургууль, гэр бүлийн дэмжлэггүй, ердийн нийгмээс тусгаарлагдсан тэд өөрсдийн нөөц, чадвараа хөгжүүлж чаддаггүй. Түүнчлэн, байнгын хяналт ажиглалтын дор байсаар тэд гадаад ертөнцтэй харьцсан нь бага байдаг бөгөөд ихэнхдээ тусламж эрэх боломжгүй байдаг. Биеийн махбодийн болон сэтгэл зүйн хүчирхийлэл, доромжлолын хохирогчид болсон тохиолдолд үр дагавар нь амь насанд аюултай болоод урт хугацааны байдаг.

Хүүхэд худалдах явдлыг зогсоох, урьдчилан сэргийлэхэд зохион байгуулалттай арга хэмжээ авах шаардлагатай байна. Улс төрийн, төрийн болон иргэдийн анхаарлыг нэгтгэж, нэгэн зорилгод олны хүчийг төвлөрүүлэх гол гүүр нь парламентчид юм. Нийгмийн бодлого, ойлголт болон саналыг нэмэгдүүлэх тодорхой алхмууд хийснээр хүүхэд худалдах явдлыг зогсоож, уг явдлын гэмт этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх болон хүүхдүүдийг аюулаас хамгаалах орчинг бүрдүүлэх боломжтой болно.

Дөрөвдүгээр бүлэг

¹² Хүүхдийн биеэ үнэлэх явдал, садар самуун болон бэлгийн зорилгоор хүүхдийг худалдах явдлыг зогсоо Олон улсын байгууллагын /End Child Prostitution, Child Pornography and Trafficking of Children for Sexual Purposes International /вэбсайт. [ecpat.net]

Хүүхдийг эмзэг болгодог хүчин зүйлс

Хүн худалдах гэмт хэргийн хохирогчид ихэнхдээ ядуу зүдүү гэр бүлээс гаралтай, эдийн засгийн боломж багатай байдаг. Мэргэжил, боловсрол дутмаг, ажил олдох магадлал багатай хүүхдүүд хамгийн их эрсдэлд байдаг. Эдгээр хүчин зүйлс нь хүйсийн, арьс өнгө, угсаа гарвалын ялгаварлан гадуурхал, зэвсэгт мөргөлдөөн, иргэний зөрчлөөс үүдсэн өөртөө итгэлгүй байдалтай нийлэхээр хүн худалдах сүлжээний хөгжиж цэцэглэхэд хамгийн зохимжтой орчинг бүрдүүлдэг. Асуудлын эх үүсвэр болсон эдгээр байдлуудыг шийдвэрлэхээс нааш хүн худалдах явдлыг шууд зогсооход чиглэсэн арга хэмжээнүүд төдийлөн амжилтанд хүрэхгүй юм. Парламентын гишүүд арга хэмжээ авч болох дараахь гол чиглэлүүд байна:

Ядуурал

Ядуурал нь хүн худалдах гэмт хэрэгт хүүхэд өртөх магадлалыг нэмэгдүүлдэг. Материаллаг хомсдол, ядуурал нь мөлжлөг, доромжлолд хүргэдэгийн хамгийн тод жишээ бол хүүхдийн хөдөлмөр юм. Ядуурал нь эмзэг бүлгийн хүүхдүүдийг аюултай хөдөлмөр рүү түлхдэг. “Боолчлол, бэлгийн мөлжлөгөд хүүхдийг худалдахыг зоригчид тав тухтай хот, суурин газраас ангуучилдаггүй, харин ядуурал нь хүүхдийн эмзэг байдлыг туйлд нь хүргэсэн хамгийн ядуу зүдүү суурин газрууд, ямар ч нөөц бололцоогүй хөдөөний нөхцлөөс хайж олдог”¹³. Гадаадад ажиллуулах амлалтаар туйлын ядуу айлууд хүүхдүүдээ ажиллуулахаар явуулах нь элбэг байдаг.

Ядуу хүүхэд бүрийг ч худалддаггүй байна. Тэд үүнд өртөмтгий байдаг ч бөгөөд хүйсийн болон үндэс угсаа гарвалын ялгаварлан гадуурхал зэрэг хүчин зүйсийн нөлөөнд энэ байдал нь нэмэгддэг. Хамгийн их эрсдэлтэй нь хүн худалдах гэмт хэрэг дэлгэрсэн газарт ойрхон байдаг хүүхдүүд байдаг.

Эмэгтэйчүүд, охидод тулгардаг тэгш бус байдал

Эмэгтэйчүүд, охидын хууль зүй, нийгмийн тэгш бус байдал нь хүн худалдах гэмт хэрэг хөгжих хөрс болж байдаг. Эмэгтэйчүүд, охидыг эд бараа мэт үздэг газар охидыг худалдаж, худалдан авч болно гэсэн уур амьсгал бий болдог. Маш олон тохиолдолд охидыг сургуульд явуулалгүй, гэр сахиулж гэрийн ажил хийлгэдэг. Улмаар охид ямарваа ур чадваргүй, боловсролгүй хоцордог. Охидыг өөрийнх нь гэрт нь доромжлох тохиолдол цөөнгүй байдаг ба ийм үед хүн худалдаалагчид гэр бүлийн мөлжлөг, хүчирхийллээс зугтах арга мэт тэдэнд санагддаг байна. Өөрийн ахуй орчин, гэр бүлээсээ гадуур ажил хайх нь зөвхөн эдийн засгийн хувьд гаргасан шийдвэр төдийгүй хувийн эрх чөлөө, амьдралын сайн сайхан нөхцөл болоод гэр бүлээ тэжээх арга замын эрэл байдаг.

Сургуульд хамрагдалт

¹³ НҮБ-ын Хүүхдийн Сангаас гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдийн байдал 2005 оны судалгаа-тайлангийн 17 дугаар хуудас, Нью Йорк хот.

Хүн худалдаалагчдад сургуульд сурдаггүй хүүхдүүд амархан олзлогддог. Дэлхийд 121 сая хүүхдүүд сургуульд явахгүй байна гэсэн багцаа байдаг ба тэдгээрийн дийлэнх нь охид байдаг¹⁴. Сургуульд хамрагдах явдал нь хүн худалдах гэмт хэрэгтэй хийх тэмцэлд чухал хүчин зүйл юм. Боловсролгүй хүүхдүүдэд ирээдүйн сонголт тун цөөн байдаг учир мөнгө, “сайхан амьдрал”-ын амлалтад татагдахдаа амархан байдаг. Түүнчлэн урьдчилан сэргийлэх анхааруулгуудын дийлэнхи нь бичиг үсэгт тайлагдсан хүүхдүүдэд чиглэсэн байдаг тул бичиг үсэг мэдэхгүй хүүхдүүдийг орхигдуулдаг. Түүнчлэн сургууль нь хүүхдүүдийг гудамжинд гаргахгүй байлгах оромж байр ч гаргаж болох талтай.

Хараа хяналтгүй хүүхдүүд

Хараа хяналтгүй хүүхдүүд нь худалдагдах, мөлжлөгөнд өртөх маш их эрсдэлд байдаг. Эцэг эх нь үр хүүхдэдээ аюулгүй байх гол нөхцөл болдог. Эцэг эхийн хамгаалалгүй, эсвэл асрамж, халамжийн байгууллагуудад байдаг хүүхдүүд нь хүн худалдагчдын бай болдог. Асрамж, халамжийн байгууллагуудад өссөн хүүхдүүд нийгэм, аливаа боломжоос тусгаарлагдмал байдаг ба улмаар эрсдэлд байдаг. Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан судалгааны дүнд өнчин хүүхдүүд бусад хүүхдүүдээс илүү нь гэр ахуйн үйлчилгээ, сексийн худалдаа, хөдөө аж ахуйн ажил, гудамжны худалдааны салбарт ажиллах магадлалтай байдгийг тогтоожээ¹⁵.

Ядуурал, зэвсэгт мөргөлдөөн, хүчирхийлэл буюу шилжилтээс болж эцэг эхээсээ тусгаарлагдсан хүүхдүүд холын төрөл садангийнхан болон үрчилж авсан айлд амьдрах нь элбэг. Аливаа чиглэл, зөвлөгөө, тав тухтай байдал, нөөц бололцоогүйгээр тэдний худалдаанд өртөх магадлал өндөр болдог.

ХДХВ/ДОХ-оос болж Африкт сая сая хүүхдүүд өнчирдөг ба Ази, зүүн Европ дахь ХДХВ/ДОХ-ын аюул заналхийлэл өсч байна. Асрамж халамж үзүүлэгчид өвдөх болон нас барахад том хүүхдүүдээр нь дүү нарыг нь асруулахын тулд сургуулиас нь гаргадаг. Хөдөлмөр эрхлэх чадваргүй, үнэтэй эм бэлдмэл шаардлагатай гэр бүлийн гишүүд нь гэр бүлдээ санхүүгийн хүндрэл учруулдаг. Хүүхдүүд өрхийн орлогод нэмэр болох шаардлагатай болж улмаар хүн худалдагчдад олзлогддог. ХДХВ/ДОХ-той тэмцэх нь хүүхэд худалдах явдлыг багасгахад үр нөлөөтэй байх болно.

Төрсний бүртгэл

Бүртгэлгүй хүүхдүүд мөн хүн худалдах гэмт хэрэгт өртөх магадлалтай байдаг. 2000 онд төрсөн хүүхдүүдийн 41 хувь нь төрөхдөө бүртгүүлээгүй гэсэн багцаа байдаг¹⁶. Албан ёсны бүртгэлгүй хүүхдийг “нуун далдлах”-ад хялбар байдаг ба нөгөө талаар алга болоход нь эрж хайх, тогтооход хүндрэлтэй байдаг. Түүнчлэн төрсний

¹⁴ НҮБ-ын Хүүхдийн Сангаас гаргасан State of the World's Children 2004 буюу Дэлхийн хүүхдийн байдал 2004 оны судалгаа-тайлангийн 31 дугаар хуудас, Нью Йорк хот.

¹⁵ НҮБ-ын Хүүхдийн Сангаас гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдийн байдал 2005 оны судалгаа-тайлангийн 74 дугаар хуудас, Нью Йорк хот.

¹⁶ НҮБ-ын Хүүхдийн Сангаас гаргасан “Birth Registration: right from the start” буюу “Төрсний бүртгэл: Эхнээс нь” хэмээх сэтгүүл, Innocenti Digest 9 сэтгүүл, 2002 он. 7 дугаар хуудас.

гэрчилгээгүй хүүхдийн насыг тогтоож холбогдох гэмт этгээдүүдэд хариуцлага тооцоход хүндрэл учруулдаг. Бичиг баримтгүй байна гэдэг нь улс хооронд худалдагдсан хүүхдийн эх орныг тогтоох боломжгүй болгож улмаар өөрийнх нь нийгэм, гэр бүл, хамт олонд нь эргүүлж хүргэхэд амаргүй байдал үүсдэг.

Хүмүүнлэгийн гамшигт үйл явдлууд ба зэвсэгт мөргөлдөөн

Мөргөлдөөний үеэр бүлэглэлүүд хүүхдийг булаан авч аливаа зөрчил, мөргөлдөөнд оролцуулах явдал байдаг. Тэднийг мөн бэлгийн хүчирхийлэлд оруулж, хүчиндэх нь элбэг. Мөргөлдөөний улмаас хилийн хяналт суларч, хүн худалдаалагчдад хилээр хууль бусаар хүн худалдах, тээвэрлэхэд хялбар болдог. Түүнчлэн олон улсын ажилчдын шилжих хөдөлгөөний их урсгал нь бэлгийн мөлжлөг, хүн худалдах явдлыг нэмэгдүүлэх нөлөөтэй байж болох юм. Хүмүүнлэгийн ажилчдын үйлдэж буй бэлгийн мөлжлөгийг нотлох баримт олширч¹⁷ байгаагаас гадна энхийг сахиулах хүчнүүд нэмэгдсэнтэй хүүхэд биеэ үнэлэх явдал нэмэгдсэн нь шууд холбоотой байна¹⁸. Үргэлжилсэн зэвсэгт мөргөлдөөн болон 2004 оны эцэст зүүн өмнөд Азийг ниргэсэн цүнами зэрэг гамшигт явдлууд нь хүүхдүүдийг хараа хяналтгүй болгосоор. Амьжиргааг бусниулдаг, эсвэл эцэг эхийнх нь аль нэгний, заримдаа хоёулангийн нь үхлээр төгсдөг гамшигт үйл явдлууд нь хүүхдийг хүн худалдах гэмт хэрэгт өртөмтгий болгодог. Энэхүү хямралууд нь замбараагүй байдал үүсгэж хуулийн хэрэгжилт, хяналтыг эвдэж, хүний наймаа эрхлэгчдэд хууль зүйн үр дагавар, хариуцлагаа амсах магадлалыг бууруулдаг.

Бэлгийн мөлжлөг, хямд хөдөлмөрийн хүчний эрэлт

Хүн худалдах гэмт хэрэг болон бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгийн байнга өсөн нэмэгдэж буй эрэлт хоёр нь хоорондоо шууд холбоотой юм. Нэмэгдэж буй орлогын төлөөх шунал ёс зүйг уландаа гишгэхэд хүргэж, улмаар хүүхдүүдийг үйлдвэр, оёдлын цехүүдэд мөлжиж байна.

Эрэгтэйчүүдийн эрхийн талаарх далд ташаа ойлголтууд нь хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн хувьд хүчирхийлэх нь зөвшөөрөгдсөн зүйл гэж үзэхэд хүргэдэг. Эрэгтэйчүүд нь үйлдсэн бэлгийн мөлжлөгийнхөө төлөө хариуцлага хүлээхгүй байгаа явдал нь энэ хандлага баталгаажихад хүргэж байна.

Уламжлал, соёлын үнэт зүйлс

Хүүхэд худалдах явдал нь холын хамаатнууд нь асран хамгаалалагч байж хүүхдүүдийг бага наснаас нь хөдөлмөрийн хүчин болгох уламжлалт чиг үүрэгтэй холбоотой. Хүүхдийн холын хамаатан, найз нөхдийнхөө гэрт эзлэх “уламжлалт байр суурь” нь эдийн засгийн зорилготой холбоотой өөр тогтолцоо болон гажсан байна.

¹⁷ Sexual Violence and Exploitation: The Experience of Refugee Children in Liberia, Guinea and Sierra Leone буюу Бэлгийн хүчирхийлэл буюу мөлжлөг: Либери, Гвиней болон Сиерра Леон дахь дүрвэгч хүүхдүүдийн байдал, 2002 оны 1 дүгээр сар.

¹⁸ Макел Грача, The Impact of War on Children буюу Дайн хүүхдэд нөлөөлөх нь, Palgrave/НҮБ-ын Хүүхдийн Сан, 2001 он, 58 дугаар хуудас.

Хоёрдугаар Хэсэг

Хүүхдийн аюулгүй орчин: Үйл ажиллагааны төлөвлөгөө

Тавдугаар бүлэг

Хүүхдийн аюулгүй орчин: Ерөнхий дүр зураг

Хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлэх нь хүүхэд худалдах явдлыг зогсооход нэн ач холбогдолтой юм. Аюулгүй орчин гэдэг нь хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөг, доромжлолоос хамгаалахад зориулагдсан харилцан хамааралтай элементүүдийн сүлжээ бөгөөд хүүхдийн амьдрал, эрүүл мэнд, сайн сайханд нь чухал нөлөөтэй юм.

Аюулгүй орчин нь гэр орноос эхэлдэг бөгөөд хамгаалалтын эхний шугам нь гэр бүл байдаг. Гэсэн хэдий ч хүүхдийн аюулгүй амьдрахад төр засаг, багш нар, шашны удирдагчид, цагдаа болон хүүхдүүд өөрсдийн нь үүрэг оролцоо шаардлагатай. Хэдийгээр парламентын оролцоо чухал ч, хүүхдийн аюулгүй байдлыг хангахад дангаараа хүрэлцэхгүй юм. Нийгмийн бүхий л салбарын оролцоо үүнд шаардлагатай.

Хүүхэд худалдах явдал нь хүүхдийн аюулгүй байх эрхийг зөрчиж буй ганцхан жишээ. Аюулгүй орчныг бүрдүүлснээр хүүхдийг доромжлол, аюул, мөлжлөгөөс ангид байлгах боломжтой. Хүүхдийн аюулгүй байдлыг хангах хүчин чармайлт гаргаснаар парламентчид энэ тал дээр нийгмийн бүхий л салбарт үлгэр жишээ байж болно.

Хүүхдийг хүн худалдах гэмт хэрэг болон бусад зөрчлөөс хамгаалахын тулд дараах салбаруудад ажиллах хэрэгтэй байна¹⁹ /илүү дэлгэрэнгүй тайлбарыг 1 дүгээр схемээс харна уу/:

Аюулгүй байх эрхийг хангах төрийн үүрэг

Аюулгүй орчныг бүрдүүлэхэд төр засгаас хүүхдийн хамгааллыг хүлээн зөвшөөрч, дээдэлдэг, хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргадаг байх шаардлагатай. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх хөтөлбөр зэрэг хүүхэд хамгааллын санаачилга, үйл ажиллагаанд зориулж зохих нөөцийг хангалттай гаргаж өгөх шаардлагатай. Хууль тогтоомжийн түвшинд хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх явдалд улс төрчид манлайлах шаардлагатай байна.

Хууль тогтоомж, түүний хэрэгжилт

Зохих хууль тогтоомжийн зохицуулалт, түүний бүрэн хэрэгжилт, хариуцлагын тогтолцоо зэрэг нь аюулгүй орчныг бүрдүүлэхэд тулгуур элементүүд болно.

Хандлага, уламжлал, тогтсон хэвшил

¹⁹ Парламентын Холбоо НҮБ-ын Хүүхдийн Сангийн хамтарсан Child Protection: A handbook for Parliamentarians буюу Хүүхэд хамгаалал: Парламентчдад зориулсан гарын авлаганаас, Швецарь улс, 2004 он.

Бага насны хүүхэдтэй хавьтах, зодож шийтгэх, аюултай уламжлалт заншил, охид хөвгүүдийг хариилцан адилгүй үнэлэх үнэлгээ зэрэг доромжлол, хүчирхийллийг хангадаг нийгэмд хүүхдийн амьдрах орчин нь аюулгүй байж чадахгүй. Хүүхдийн хүчирхийллийн аливаа хэлбэрийг хориглодог, зан заншил уламжлалаараа хүүхдийн бүхий л эрхийг хүндэлдэг нийгэмд хүүхдийг хамгаалах боломжтой юм.

Асуудлыг хөндөж ойлголтыг дэлгэрүүлэх

Хамгийн анхан шатандаа хүүхдүүд өөрсдөд нь болон бусдад хамааралтай хүүхэд хамгааллын асуудлуудын талаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй байх шаардлагатай. Үндэсний түвшинд энэхүү асуудалд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон иргэний нийгмийн оролцоо нь хүүхэд хамгаалалд хувь нэмрээ оруулна. Үр дүнтэй, зохион байгуулалттай хариу өгөхийн тулд бүх шатны хамтын ажиллагаа шаардагдаж байна.

Хамт олон, өрхүүдийн чадавхийг дээшлүүлэх

Эцэг эхчүүд, эрүүл мэндийн ажилтнууд, багш нар, цагдаа, нийгмийн ажилтнууд болон хүүхэдтэй ажиллаж, хүүхдийг асран хамгаалдаг бусад хүмүүс хүүхэд хамгааллын асуудлуудыг мэдэж, түүнд хариу өгөх ур чадвар, мэдлэг, эрх мэдэл болон хүсэл эрмэлзэлтэй байх шаардлагатай. Хүүхдийн тоглоомын аюулгүй талбай, боловсролыг хангах зэрэг илүү өргөн хүрээний санаачилга бодлогууд нь аюулгүй орчны чадавхийг өргөжүүлдэг.

Хүүхдийн оролцоо

Аливаа доромжлолоос ангид байх эрхтэйгээ, түүнчлэн хүн худалдах явдал зэргийн талаар хүүхдүүд мэдэхгүй байх нь тэднийг мөлжлөгөд амархан өртөх боломжтой болгодог. Хүүхдүүд өөрсдийгөө хамгаалахад шаардлагатай мэдлэг, мэдээллээр хангагдсан байх учиртай. Түүнчлэн тэд оролцооны болон өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх аюулгүй нөхцлөөр хангагдах шаардлагатай. Хүүхдийн оролцоог хангах боломж хомс байвал тэд илүү гэмт хэрэг болон бусад аюултай арга хэмжээнд оролцох хандлагатай байдаг.

Хяналт хэрэгжүүлэх тайлагнах

Хүүхдэд аюулгүй орчин нь мөлжлөг, зөрчлүүдийн тохиолдлууд, тэдгээрийн шинж чанарыг бүртгэдэг, тэдгээр зөрчлүүдэд өгөх үндэслэлтэй хариу үйлдэл хийх боломж олгодог системтэй хяналтын тогтолцоотой байх шаардлагатай. Уг тогтолцоо нь оролцооны арга, хамт олны үйл ажиллагаанд үндэслэсэн үед үр дүнтэй байдаг. Төр засгууд хүүхдийн хүчирхийлэл, доромжлол, мөлжлөгийн талаар мэдэж байх шаардлагатай.

Эдгээх, нөхөн сэргээх үйлчилгээ

Хаягдсан, доромжлол, мөлжлөгт өртсөн хүүхдүүд халамж, нийгмийн суурь, цогц үйлчилгээг үл ялгаварлалгүйгээр хүртэх эрхтэй. Эрүүл мэнд, өөртөө итгэх итгэл, эрхэмсэг оршихуйг дээдэлдэг орчинд эдгээр үйлчилгээг хамгийн сайн үзүүлдэг.

Схем 1: Аюулгүй орчин

[гол хэсгээс нар зөв бичигдсэн нь: Хууль тогтоомж, Хандах хандлага, Нээлттэй хэлэлцүүлэг, Хүүхдийн амьдрах ухаан, Хамт олон, гэр бүлийн чадавхи, Үндсэн үйлчилгээ, нөхөн сэргээлт, хяналт тавих тайлагнах, төр засгийн хүчин чармайлт]

[тойргийн голд: аюулгүй орчин]

[тойргийн гадна сумнуудад бичигдсэн нь: хүн худалдах явдал, хүчирхийлэл, анхдагч халамжлагчгүй хүүхдүүд, бэлгийн мөлжлөг, хөдөлмөр, зөрчил мөргөлдөөн]

Аюулгүй орчинг бүрдүүлэхэд нийгмийн бүх гишүүдийн хүчин чармайлт шаардлагатай. Гэхдээ парламентчид үүнд тусгай үүрэг гүйцэтгэнэ. Энэхүү гарын авлагад мөлжлөг, хүн худалдах явдлаас хүүхдүүдийг хамгаалахын тулд парламентчидийн авч болох арга хэмжээг тодорхойлсон ба ингэхдээ аюулгүй орчны ойлголтон дээр үндэслэсэн болно.

Парламентчид хүүхэд худалдах явдлаас урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл өгөх тодорхой арга хэмжээ авдаг аюулгүй орчинг бүрдүүлэх чадвартай. Тэд үүнийг хууль баталж, төсөвт тусгаж, засгийн газрын үйл ажиллагааг хянаж, үндэсний болон олон улсын түвшинд энэ талаар ойлголтыг дээшлүүлэх боломжтой. Аюулгүй орчны элемент тус бүр, түүнчлэн парламентчдад зориулсан санал зөвлөмжүүдийг дараахь бүлгүүдэд нарийвчлан тусгасан болно.

Зургаадугаар бүлэг

Аюулгүй байх эрхийг хангах төрийн хүчин чармайлт

Аюулгүй орчныг бүрдүүлэхэд төр засгаас хүүхдийн хамгааллыг хүлээн зөвшөөрч, дээдэлдэг, хүүхэд хамгааллыг хэрэгжүүлэхэд хүчин чармайлт гаргадаг байх шаардлагатай. Хүүхдийн хөдөлмөртэй тэмцэх хөтөлбөр зэрэг хүүхэд хамгааллын санаачилга, үйл ажиллагаанд зориулж зохих нөөцийг хангалттай гаргаж өгөх шаардлагатай. Хууль тогтоомжийн түвшинд хүүхэд хамгааллын асуудлыг шийдвэрлэх явдалд улс төрчид манлайлах шаардлагатай байна.

Хүүхэд худалдах явдтай тэмцэх төрийн хүчин чармайл нь өргөн хүрээний төрийн оролцоо, зохицуулалтыг шаардана. Эдгээрийн зарим нь хүүхэд хамгааллын асуудлаас халих хэмжээний ч өргөн хүрээний зохицуулалт байна. Зарим нь хүүхэд худалдах явдалтай зэрэг зөвхөн хүүхэд хамгаалахтай холбоотой асуудалд төвлөрөх арга хэмжээ байна. Эдгээр нь бүгд хүүхэд худалдах явдлыг устгахад чухал үүрэгтэй.

Энэ хүрээнд парламентчид хууль тогтоогч, засгийн газрын үйл ажиллагааг хянагч, үзэл суртлын удирдагчид болохын хувьд гол үүрэг гүйцэтгэнэ.

“Уг Бага хурал нь бүх Улсуудыг дараахьт уриалж байна:

б/ Хүн, хүүхдийг аливаа зорилго, хэлбэрээр худалдах явдлаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд чиглэсэн хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын хэмжээний бүх баримт бичгийн хэрэгжилтийг хангахын тулд хууль, бодлого, хөтөлбөр, практикийг бий болгох үүднээс шаардлагатай бүхий л үндэсний, хоёр талт, болон олон улсын арга хэмжээ авах”.

- 106 дугаар IPU бага хурал /Буркина Фасо, Угадугу, 2001 оны 9-р сар/

А.Олон улсын эрх зүйн баримт бичгийг батлах

Юун түрүүнд, хууль тогтоогчид нь аливаа хязгаарлалгүйгээр хүүхэд худалдах явдлыг хориглосон бүхий л олон улсын гэрээ, конвенциудад гарын үсэг зурж, батлах явдлыг уриалах, дэмжих шаардлагатай байна. Хэрэв тухайн улс тухайн баримт бичгийн хууль зүйн хүчин чадлыг хязгаарлахаар мэдэгдэл хийсэн болон тайлбар хийж нэгдсэн бол тэдгээр хязгаарлалт, тайлбарыг хөндөж, асуудал үүсгэх боломж парламентчдад байдаг.

Холбогдох хамгийн чухал олон улсын гэрээ, конвенцид дараахь хамаарна:

Хүүхдийн эрхийн тухай Конвенци /1989 он/

Хамгийн өргөн хүрээгээр батлагдсан хүний эрхийн акт болох Хүүхдийн эрхийн тухай Конвенци нь хүүхдийг хүн худалдах явдлаас хамгаалах үүргийг төрд тусгайлан олгосон байдаг. 34, 35 дугаар зүйлүүд нь хүүхдийг аливаа бэлгийн мөлжлөг, доромжлолын аливаа хэлбэрээс хамгаалж хүүхдийг аливаа хэлбэр, зорилгоор хулгайлах, худалдах, хил давуулан худалдахаас урьдчилан сэргийлэхийг төр засгуудад үүрэг болгосон байдаг.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн Хүүхэд худалдах, биеийг нь үнэлүүлэх болон садар самуунд оролцох талаар Нэмэлт Протокол(2000)

Энэхүү Протоколыг 2000 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей баталж, 2002 оны 1 дүгээр сарын 18-нд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд бэлгийн мөлжлөг, хүүхдийн хөдөлмөр, үрчлэлтийн зорилгоор хүүхэд худалдах явдалд хамаарах бөгөөд урьдчилан сэргийлэх, хориглох болон хохирогчдод туслалцаа үзүүлэх асуудлуудыг тусгажээ. Хүүхдийн эрхийн тухай Конвенци нь бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэхэд төвлөрсөн байдаг бол энэхүү Протокол нь хүүхэд биеэ үнэлэх, садар самуун явдлыг эрүүгийн гэмт хэрэгт тооцоход чиглэсэн зохицуулалттай байдаг.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн тухай НҮБ-ын Конвенцийн нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухайн Протокол (Палермогийн Протокол) болон Цагаачдыг газар, ус, агаараар хууль бусаар тээвэрлэх тухай Протокол (2000)

Эдгээр Протоколуудыг НҮБ-ын Ерөнхий Ассамблей 11 дүгээр сарын 15-нд баталсан бөгөөд тэдгээр нь 2003 он 12 дугаар сард хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн байна. “Палермогийн Протокол” нь олон улсын эрх зүйд анх удаа “хүн худалдах” явдлын тодорхойлолтыг гаргаж ирсэн. Хүнийг, нэн ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг худалдах явдлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн системтэй бодлого, хөтөлбөр батлахыг шаардахаас гадна уг Протокол нь хүн худалдах гэмт хэргийн эсрэг хууль батлах, түүнийг хэрэгжүүлэх болон хохирогчидтой харьцах асуудлаар хууль тогтоох байгууллагын үүргийг тодорхой тусгасан байдаг. Авах арга хэмжээнд хүн худалдах явдлыг эрүүгийн гэмт хэрэгт тооцох, зохих ял шийтгэлийг тогтоож өгөх, хүлээн авагч орнуудад хохирогчдыг хамгаалах, улс хоорондын мэдээлэл солилцоог хангах зэрэг хамаарна.

Улс хоорондын үрчлэлттэй холбоот хүүхэд хамгаалал, хамтын ажиллагааны тухай Гаагын Конвенци (1993)

Энэхүү Конвенци нь хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хүнд хэлбэрийг хориглох, нэн даруй устгахыг уриалсан байдаг. “Хүүхдийн хөдөлмөрийн хамгийн хүнд хэлбэр” гэдгийг 3 дугаар зүйлд нь дараахь байдлаар тодорхойлсон байна: боолчлолын бүхий л хэлбэр, түүнтэй адилтгах бүх зан үйл, үүнд хүүхэд худалдах, өр авлагаар барьцаалах, зарцлах; заавал буюу хүчээр хөдөлмөр эрхлүүлэх, үүнд зэсвэгт мөргөлдөөн хүүхдийг хүчээр оролцуулах, элсүүлэх; хүүхдийг янханчлал, садар самуун материал бүтээх, садаг самуун үзвэр болон хар тамхи мансууруулах бодис үйлдвэрлэх, худалдах зэрэг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, оруулах, санал болгох; өөрийн мөн чанар, нөхцлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд харшлах ажил хөдөлмөр зэрэг орно.

Хүүхдийн хөдөлмөрийн хүнд хэлбэрийг хориглох, арга хэмжээ авах тухай Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын Конвенци 182(1999)

1995 онд хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн энэхүү Конвенци нь улс хоорондын хүүхэд үрчлэлтэнд оролцсон хүүхэд, төрсөн эцэг, эх, үрчилж авсан эцэг, эхийг хамгаалах хууль зүйн үндэслэлийг тогтоож өгдөг. Энэхүү Конвенци нь тухайн үрчлэлт хүүхдийн ашиг сонирхолд бүрнээ нийцсэн байх явдлыг хангахын тулд хүүхдийг хулгайлах, худалдах явдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, үрчлэлтийн үндсэн хэм хэмжээнд захирагдаж байх шаардлагыг улс орнуудад тавьдаг.

Эдгээр олон улсын баримт бичгүүдийн талаархи дэлгэрэнгүй мэдээллийг НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын Албаны вэб сайт болох www.unhchr.ch болон Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага болох www.ilo.org-ооc үзэж болно.

Хууль зүйн зохицолдоо, хэрэгжилтийг хангах үүднээс эдгээр олон улсын баримт бичигт тусгасан хэм хэмжээ, зохицуулалтыг дотоодын хууль тогтоомжид суулгаж өгөх шаардлагатай. Тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журмуудыг мөн бий болгох, гэрээ, конвенциудыг зохих ёсоор нь хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Б.Ядуурлыг бууруулах явдлыг чухалчлах нь

Ядуурлыг бууруулах нь хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдлаас илүү өргөн хүрээтэй ашиг тусыг нийгэмд өгнө. Хэдий ийм ч, ядуурал нь хүүхэд болоод гэр бүлийг хүн худалдаалдагчдын амлалтад өртөмтгий болгодог нь бодит байдал юм. Хүн худалдах явдлын эсрэг чиглэсэн бодлого, стратегийн нэгэн хэсэг болохын хувьд үндэсний болон олон улсын хэмжээний ядуурлыг бууруулах чиг, бодлогууд нь маш чухал байр суурь эзэлдэг. Тухайлбал, эцэг эхчүүдэд хөдөлмөр эрхлэх боломж олгосноор хүүхдийг сургуулиа хаяж хөдөлмөр эрхлэх дарамт багасна. Парламентчдийн авч болох тодорхой арга хэмжээнд дараахь орно²⁰:

- Хүүхдэд тусч буй байдал дээр нь үндэслэж хүүхдийн ядуурлыг тодорхойлж хэмжих
- Нийгмийн суурь болон боловсролын үйлчилгээнд бүх нийтийн хүртээмжийг хангаж, өргөжүүлэх
- Зорилт дэвшүүлж, холбогдох хүмүүсийг оролцуулах. Холбогдох бүх этгээдүүд хүүхдийн ядууралд холбоотой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд оролцох нь чухал юм.
- Хүүхдээ өсгөхөд нь гэр бүлд туслалцаа үзүүлэх. Гэр бүл гэдэг нь хүүхэд хамгааллын эхний шугам юм. Хүүхэд гэр бүлээсээ хол байх тусам доромжлол, мөлжлөгт өртөх магадлал нь өндөр болдог.

Того дахь Боловсролын Зээлийн Хөтөлбөр нь эмэгтэйчүүдэд орлогын эх үүсвэрээ олоход нь зориулж зээл олгодог ба ингэснээр хүүхдийг орлого олуулахаар хол явуулах шаардлагыг багасган улмаар хүүхдийн сургуульдаа суралцах боломжийг нь нэмэгдүүлдэг. Хүн худалдах гэмт хэрэгт өртсөн хүүхдүүд болон өртөх магадлалтай гэр бүлүүдэд зээл өгсөн байна. Тэдгээр хүүхдүүд одоо Тогод болон бусад орнуудад гэрийн ажил хийлгүйгээр сургуульд сурч эсвэл наймаа эрхэлж байна²¹.

Мексикийн Засгийн газраас хэрэгжүүлж буй томоохон хэмжээний хөтөлбөр болох Oportunidades нь ядууралд автсан хүүхдүүдэд сургууль болон эрүүл мэндийн хяналтанд хамрагдахад нь туслалцаа үзүүлж байна. Уг хөтөлбөр нь эхчүүдэд хүүхдийнхээ сургуулийн төлбөр, хэрэгсэл болон гэр бүлийнхээ хоол хүнс, эрүүл мэндийн хяналт зэрэгт хүрэлцэхүйц хэмжээний бэлэн мөнгө шилжүүлдэг байна²².

²⁰ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал 2005 хэмээн тайлангаас, 15 дугаар хуудас, Нью Йорк хот.

²¹ НҮБ-ын Хүүхдийн Сангаас Innocenti судалгааны төвөөс хамтран эрхлэн гаргасан Child Trafficking in West Africa: Policy Responses 2002 буюу Өрнөд Африк дахь Хүүхэд худалдах явдал: Бодлогын арга хэмжээ 2002 хэмээн тайлангаас, 16 дугаар хуудас.

²² НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал 2005 хэмээн тайлангаас, 32 дугаар хуудас, Нью Йорк хот.

В.Улс хоорондын хамтын ажиллагаа

Улс дамнасан хүн худалдах гэмт хэргийг устгахад улс хоорондын хамтын ажиллагаа ихээхэн ач холбогдолтой юм.

Парламентчид эрүүгийн асуудлаар харилцан туслалцаа үзүүлэх хоёр талын болон олон талын гэрээ, хэлэлцээрийг боловсруулж, батлах боломжтой. Ингэснээр гэмт явдлыг мөрдөн шалгах, гэмт этгээдүүдийг яллах, гэрчүүдийг олох, нотлох баримтыг хадгалах, хууль зүйн шийдвэр гаргах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх гэрээг хэрэгжүүлэх болон хөрөнгө хураах ажиллагаанд хамтран оролцох үндэслэл болж өгнө.

Эдгээр гэрээнүүд нь хүн худалдах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалахад ач холбогдолтой. Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны дүнд худалдаалагдсан хүүхдүүдийг нутагт эргүүлэн авчирч, нийгэмшүүлэх, холбогдох арга хэмжээ нь зохистой, үр дүнтэй байх болно. Судалгаанаас үзэхэд эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй улс хоорондын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрүүдийн үр дүн нь улс орнуудын хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх хүчин чармайлтаас хамаарч байгаагаас шалтгаалдаг байна.

Улс-хоорондын хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийг загвар жишээг А болон Б Хавсралтанд үзүүлсэн болно.

1997 онд Фижи улс нь Эрүүгийн асуудлаарх Харилцан Туслалцаа үзүүлэх тухай хууль баталж, улмаар Австрали болон Шинэ Зеланд улсуудтай эрүүгийн асуудлаарх харилцан туслалцаа үзүүлэх хоёр талын гэрээ, хэлэлцээр байгуулжээ. Уг хуулийн дагуу, Фижи улс нь хүн худалдах явдалтайтай холбоотой ноцтой гэмт хэргүүдийг мөрдөн байцаах явдалд хамтран ажиллах үүрэг хүлээжээ.²³

Өрнөд Африкийн Эдийн засгийн хамтын ажиллагааны орнуудын (ECOWAS) Эрүүгийн асуудлаархи Харилцан Туслалцаа үзүүлэх тухай Конвенцийг 1992 оны 7 дугаар сарын 29-ны өдөр Дакар хотноо баталжээ. Уг Конвенциор хүн худалддаг этгээдийг илрүүлэхэд шууд болон шууд бусаар холбоотой хоёр талын болон олон талт арга хэмжээг дэмжсэн байдаг. Уг хамтын ажиллагааны орнуудын гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэх тухай Конвенцийг 1994 оны 8 дугаар 6-ны өдөр Абужад баталсан ба, уг Конвенциор нэг улсын нутаг дэвсгэрээс гарч өөр улсын нутаг дэвсгэрт орогнол хүсч буй гэмт этгээдүүдийг баривчилж, яллах, ял эдлүүлэх чухал үндэслэлийг шүүхүүдэд олгосон билээ. 2001 он 12 сард Дакар хотноо болсон Өрнөд Африкийн Эдийн засгийн хамтын ажиллагааны орнуудын Дээд хэмжээний уулзалтын үеэр хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх Тунхаглал болон Үйл ажиллагаан Хөтөлбөрийг баталсан ба үүнд: хүн худалдах явдлыг гэмт хэрэгт тооцох, үндэсний ажлын хэсгүүдтэй хамтран ажиллах Өрнөд Африкийн Эдийн засгийн хамтын ажиллагааны орнуудын Зохицуулалтын Хэсэг байгуулах, хохирогчдын хамгаалж туслалцаа үзүүлэх, энэ талаар нийгмийн ойлголтыг

²³ Хамгаалалтын төсөл, Улс орнуудын тайлангаас, [www.protectionproject.org, 2005 оны 2 дугаар сар].

дээшлүүлэх, хил хамгаалалт, зохицуулалтын байгууллагуудын хамтын ажиллагаа, Хамтын ажиллагааны орнууд болон НҮБ-аас цуглуулах мэдээлэл зэргийг тусгажээ.²⁴

Марокоос буюу Марокоор дамжиж Испани руу нууцаар шилжин суурьших хараа хяналтгүй насанд хүрээгүй хүмүүсийн тоо нэмэгдэж буй явдалд хариу арга хэмжээ авахад чиглэгдсэн Испани, Марок орнуудын хоорондын гэрээ хэлэлцээр боловсруулагдах шатандаа явж байна.²⁵

Г. Байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх

Хүн худалдах явдалд тогтвортой, зохион байгуулалттай хариу арга хэмжээ авахад хууль тогтоочдод дараахь арга хэмжээг санаачилж төрийн дэд бүтцийг хөгжүүлэхийг санал болгож байна:

Үндэсний алба

Хүн худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх түүнчлэн тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хянах Үндэсний албад чухал ач холбогдолтой. Эдгээр албад нь цагдаагийн, хэвлэл мэдээллийн, хуулийн мэргэжилтнүүд, мэргэжлийн бус болон шүүхийн байгууллагуудад тогтмол сургалт явуулж, мэдээллээр хангах чиг үүрэгтэй байна.

Үндэсний Үйл ажиллагааны хөтөлбөр

Хүн худалдах сүлжээг таслан зогсооход “Үндэсний Үйл ажиллагааны хөтөлбөр” батлах явдал нь чухал алхам болно.²⁶ Үндэсний Хөтөлбөр нь зорилт тодорхойлох, гарч буй ахиц дэвшлийг хэмжих болон Засгийн газруудад амлалтаа биелүүлэхэд нь нөлөөлөх, лобби хийх, шахалт туслалцаа үзүүлэхэд шаардлагатай.

Үндэсний Хөтөлбөрт жижиг хамт олноос эхлээд олон улсын түвшин хүртэлх нийгмийн бүхий л хэсгүүдийн оролцоог хангасан, тодорхой, асуудалд төвлөрсөн, хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэхэд авах арга хэмжээний суурь болох ёстой. Үндэсний Хөтөлбөрийг боловсруулах явцад бусад орнуудын Засгийн газрууд, олон улсын байгууллагууд болон төрийн бус байгууллагууд хоорондын хамтын ажиллагааны холбоо бий болгоход ач холбогдолтой байж болох юм.

²⁴ НҮБ-ын Хүүхдийн сан, Innocenti судалгааны төвийн хамтарсан Trafficking in Human Beings, Especially Women and Children, in Africa буюу Африк дахь Хүн худалдах гэмт хэрэг, тэр дундаа Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах явдал хэмээх 2003 оны тайлан судалгааны 28 дугаар хуудас.

²⁵ НҮБ-ын Хүүхдийн Сангийн Олон улс дахь Шилжилт хөдөлгөөний талаарх Зохицуулалтын 3 дахь Уулзалт, Олон улс дахь Шилжилт хөдөлгөөн болон Хүүхэд худалдах явдлын Хүүхдийн эрхийн талаас: НҮБ-ын Хүүхдийн Сангийн судалгаа, 2004 оны 10 дугаар сарын 18-ны өдөр, 4 дүгээр хуудас.

²⁶ Үндэсний Үйл ажиллагааны хөтөлбөрийн талаарх зөвлөмж, загвар жишээг ECPAT International-ийн 2003 оны Report on the Implementation of the Agenda for Action Against Commercial Sexual Exploitation of Children, 2001-2002 буюу Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг Үйл ажиллагааны хөтөлбөрийн Хэрэгжилт 2001-2002 тайлангийн 4 дүгээр хуудаснаас үзнэ.

Түүнчлэн, Засгийн газрууд хүүхдийн хөдөлмөртэй холбоотой бодлого, хөтөлбөр болон үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлж болох юм.

Stability Pact Task Force against Trafficking in Human Beings буюу Хүн худалдах явдалтай тэмцэх Тогтвортой Гэрээний Ажлын Хэсгээс санаачлан эхлүүлж, дэмжсэн үйл явц болох Хүүхэд худалдах явдалтай тэмцэх Үндэсний Үйл ажиллагааны Хөтөлбөрүүдийг Зүүн-өмнөд Европын олон орнууд боловсруулсан байна²⁷.

Гана улсын Загсийн газар нь биеэ үнэлэгч хүүхдүүд, гудамжны хүүхдүүд, гэр ахуйн ажил эрхэлдэг хүүхдүүд, ачаа зөөгч болон жижиг хэмжээний уурхайд ажилладаг хүүхдүүдэд чиглэсэн Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг Үндэсний Хөтөлбөр боловсруулсан байдаг бөгөөд охид, хүнд нөхцөлд хөдөлмөр эрхэлдэг болон 12-оос доош насны хүүхдүүдийг чухалчлан авч үзсэн байдаг²⁸.

Парламентын механизм

Парламентын механизм нь хүүхэд хамгаллын асуудлаарх хууль зүйн баримт бичгийг батлах, нэгдэн ороход төдийгүй холбогдох үндэсний хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд мөн ач холбогдолтой.

Эдгээр зорилтуудыг дэмжих тусгай механизмуудыг дараахь нөөц бололцоогоор боловсруулж, хангах нь зүйтэй:

1) Парламентийн нэг буюу хэд хэдэн байнгын буюу түр хороог байгуулах (хэрэв нэгээс илүү байдаг бол хүүхэд худалдах явдлыг парламентын бүхий л үйл ажиллагаанд харгалздэг байхаар эдгээр хороодын үйл ажиллагааг нь зохицуулж уялдуулах)

А) Хүүхэд хамгааллын асуудал хариуцсан парламентын хороо байгаа тохиолдолд тухайн хороонд хүн худалдах явдал хариуцсан дэд хороо байгуулах нь ач холбогдолтой байж болох юм.

Б) Хүүхэд худалдах асуудлыг хариуцсан хороонд бүх улс төрийн намын төлөөлө байж, тухайн асуудлаар өргөн хүрээтэй дэмжлэг үзүүлэх, парламентын тогтмол хэлэлцүүлэг явуулж байхыг хангах

2) Хүүхэд хамгааллын асуудлаар нэн ялангуяа Засгийн газраас хүүхэд худалдах явдалтай тэмцэхэд авч буй арга хэмжээг нь нарийн хянадаг, иргэний нийгэмтэй хамтран ажилладаг албан бус бүлэг байгуулах

Д. Хүн худалдах явдлын эсрэг хөтөлбөрт санхүүжилт олгох, төсөв баталж гаргаж өгөх

²⁷ Stability Pact Task Force against Trafficking in Human Beings буюу Хүн худалдах явдалтай тэмцэх Тогтвортой Гэрээний Ажлын Хэсгийн вэбсайт. [<http://www.osce.org>, February 2005]

²⁸ Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага, Хүүхдийн Хөдөмөргүй Ирээдүй, 2002 он, 80 дугаар хуудас.

Хүн худалдах явдлын эсрэг үйл ажиллагаанд санхүүгийн туслалцаа үзүүлэх чухал байр сууринд парламентчид байдаг. Үүнд урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хөрөнгө төсөвлөж өгөх, чадавхи дээшлүүлэх үйл ажиллагаанд санхүүгийн туслалцаа үзүүлэх, хохирогчдийг хамгаалах болон тэдэнд туслахад хангалттай хөрөнгө гаргах зэрэг хамаарна.

Парламентчид улсын төсвийг уншиж, хэлэлцэж, баталж улмаар түүний зүй зохистой зарцуулалтыг хянадаг. Улсын төсвийг хэлэлцэх үед бүх асуудлыг хамруулах арга барил хэрэгжлэж буйг, түүнчлэн, иргэний нийгэм болон болон улсын байгууллагууд зэрэг бүх талын түншүүд тухайн асуудлын дүр төрхийг бодитойгоор бий болгоход оролцож, хувь нэмрээ өгөх явдлыг хангах нь чухал юм.

Цаашилбал, хүүхэд худалдах явдалтай холбоотойгоор Засгийн газрын хүлээсэн үүрэг, хариуцлага, амлалтыг нь эрсдэлд буй хүүхдүүдийг хэрэгцээнд тохируулах, хангалттай хөрөнгө улсын төсөвт тусгагдсан зэргийг хянах чухал үүрэг парламентчдад ногдоно.

Е. Хүмүүнлэгийн хямралын үед хүн худалдах явдалтай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх

Байгалийн гамшиг, зэвсэгт мөргөлдөөн зэрэг хүмүүнлэгийн хямрал нь хүүхдийг хүн худалдах явдалд өртөх эрсдэлд оруулдаг. Хүмүүнлэгийн онц байдлын үеийн хүн худалдах явдлын эрсдэл хэрхэн нэмэгддэгийг парламентчид ухамсарлах шаардлагатай байна. Гамшиг болоход, хүүхэд худалдах явдлын магадлалыг багасгахад нэн даруй, яаралтай арга хэмжээ авах шаардлагатай болно.

Цунамийн хямралын үеэр НҮБ-ын Хүүхдийн Сан нь хүүхэд худалдах явдалд хүүхдүүдийн өртөх боломжийг багасгахад чиглэсэн дараахь 5 алхмыг санал болгосон байна²⁹:

- Шилжсэн бүх хүүхдүүдийг бүртгэх. Хараа хяналтгүй, эцэг эх, асран хамгаалагчдаасаа салсан, өнчирсөн байж болзошгүй бүх хүүхдүүдийг олж, тэдгээрийн байршлыг тогтоох.
- Нэн даруй аюулгүй байдлыг хангах. Хараа хяналтгүй буюу асран хамгаалчдаасаа тусгаарлагдсан хүүхдүүд тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцах насанд хүрэгчдийн түр асран хамгаалалтанд байх ёстой. Тэдгээрийн асрамж, хамгааллыг нарийн хянаж, цаашид эрсдэлд орохооргүй байлгах.
- Хамаатан садныг олж тогтоох. Үймээнд салсан, тусгаарлагдсан гэр бүлийн гишүүдийг нийлүүлэх:
- Цагдаа болон бусад холбогдох байгууллагуудад мэдэгдэх. Хүүхдийн мөлжлөгийн талаар цагдаа, хил хамгаалалт, багш, эрүүл мэндийн ажилчид

²⁹ НҮБ-ын Хүүхдийн Сан, Хэвлэл мэдээллийн мэдэгдэл, 2005 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр.

болон бусдад мэдэгдэж, хүүхдийг хамгаалахад тэдний туслалцааг авах нь чухал.

- Үндэсний тусгай арга хэмжээ авах. Хүүхдүүдийн шилжих хөдөлгөөнд түр хязгаарлалт хийх нь хүн худалдах явдал явагдахаас сэргийлэхэд шаардлагатай байж болох юм.

Цунамийн бүсд хүүхэд худалдах явдал гарч болзошгүй хэмээн болгоомжилж Индонезийн Засгийн газар Ачехээс олон улс хүүхэд үрчлэх явдалд түр хязгаарлалт хийсэн байна. 16-аас доош насны хүүхдүүдийг эцэг, эхгүйгээр тус улсаас явахыг хориглосон байна. Бүх хүүхдүүд болон гэр бүлийг нь зохих ёсоор тогтоох хүртэл Умард Суматра болон Ачехийн бүх нисэх буудал, далайн боомтуудын нарийн хяналтанд авсан байна.³⁰

Мөргөлдөөний үед парламентчид дараахь арга хэмжээг авч болно³¹:

- Хүүхдийн хэрэгцээ, шаардлага, нөхцөл байдлыг, нэн ялангуяа аюулгүй байдлыг хангаж буй явдлыг хянах хамт олонд үндэслэсэн арга хэмжээг дэмжих.
- Хариуцлагаас мултардаг заншлыг халж, төрлөөр устгах гэмт хэрэг, дайны гэмт хэрэг /үүнд 15-аас доош насны хүүхдийг цэргийн албанд татах/, болон хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэгч гэмт этгээдүүдийг хуулийн өмнө хариуцлага хүлээлгэх.
- Хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох, бэлгийн үйлчилгээ худалдаж авахыг хориглодог Цэргийн, Энхийг сахиулах болон Хүмүүнлэгийн боловсон хүчний дүрмийг баталж бэлгийн доромжлол, мөлжлөгийг үл тэвчих бодлого хэрэгжүүлэх.³²

Долоодугаар бүлэг

Хууль тогтоомж, түүний хэрэгжилт

Зохистой хууль тогтоомж, түүний чанд хэрэгжилт болон хариуцлагын тогтолцоо нар нь аюулгүй орчныг цогцлоох үндсэн элементүүд юм.

Хууль тогтоогчдоос үндэсний хууль тогтоомжоо баталгаажуулж хүн худалдах гэмт хэрэг болон мөлжлөгөөс хүүхдүүдийг хамгаалах чадвартай хууль зүйн орчин бүрдүүлэхийг уриалж байна. Үүнд хүн худалдах гэмт хэрэгтэй холбоотой Эрүүгийн хуулийг чангатгах, цагаачлал, хөдөлмөр болон хүүхдийн хүчирхийлэл/ гэр бүлийн хүчирхийллийн хуулиуд зэрэг хүн худалдах гэмт хэрэгт шууд нөлөөлөхүйц хууль, бодлого хэрэгжүүлэх явдал хамаарна.

³⁰ НҮБ-ын Хүүхдийн Сан, Хэвлэл мэдээллийн мэдэгдэл, 2005 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр.

³¹ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал 2005 хэмээн тайлангаас, Нью Йорк хот.

³² НҮБ, Ерөнхий Нарийн Бичгийн даргын мэдээлэл, “Бэлгийн мөлжлөг, бэлгийн доромжлолоос хамгаалахад авах тусгай арга хэмжээ”, 2003 оны 10 дугаар сарын 9-ны өдөр.

Өөрийн онцлог бүхий тогтолцоотой механизмаар хууль тогтоомжийг эргэн хянах нь тодорхой үндэсний хууль тогтоомжийн тогтолцоог сайжруулахад чухал ач холбогдолтой. Үүнд хүн худалдах гэмт хэргийн атлаархи хангалттай мэдээлэл байгаа эсэх, шаардлагатай тохиолдолд хуулийн зохицуулалтын хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн үндэсний мэдээлэгч/хянагчийг томилох, олон салбарыг хамарсан бүлгийн тогтмол уулзалт хийх зэрэг орно. Үндэсний механизмууд, бүсийн хууль хяналтын болон шүүхийн байгууллагуудын харилцаа, хамтын ажиллагаа энд чухал үүрэгтэй юм.

“Бид хүүхдийн асуудалтай холбоотой хууль тогтоомжийг эргэн хянах, дүгнэх, шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг боловсруулах зорилгоор өөрсдийн улс орны хүүхдүүдэд тулгараад буй асуудлыг хариуцсан парламентын хороод, комиссууд, ажлын хэсгүүдийн үйл ажиллагааг хүчирхэгжүүлэх болно”

-IPU –ийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн Сан, Түркменистанаас хамтран зохион байгуулсан “Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг Төв Ази болон Казахстанд хэрэгжүүлэх нь” сэдэвт Парламент хоорондын Зөвлөгөөнөөс гарсан Ашгабатын Тунхаглалаас

А.Эрүүгийн хуулийг сайжруулах

- Хүүхдийг тодорхойлох нь

Хүүхдийн эрхийн тухай Конвенциор тодорхойлсноор хүүхэд гэдэг нь “Хүүхэдтэй холбоотой хуулиар түүнээс өмнө насанд хүрэхээр заагаагүй бол 18 хүртэлх насны хүн³³”-ийг хэлэх ажээ.

- Хүн худалдах явдлыг тодорхойлох нь

Палермогийн Протоколд тусгасан хүн худалдах явдлын нарийвчлан тодорхойлсон тодорхойлолтыг тухайн улсын Эрүүгийн хуульд тусгаж болох юм. Бүх хуулиар хүүхдийг аливаа хэлбэр, зорилгоор тээвэрлэх, худалдах явдлыг хориглох ёстой. Ийн хориглох зүйлст дор хаяж бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх, боочлол, түүнтэй адилтгах үйл ажиллагаагаа, зарцлалт зэргийг хамруулах шаардлагатай. Хэрэв хууль тогтоогчид өөрсдийн бие даасан тодорхойлолтыг бий болгохыг хүсвэл уг тодорхойлолтын хүрээ нь Палермогийн Протоколын тодорхойлолтоос багагүй байх нь зүйтэй. Ямар ч тодорхойлолт нь хүн худалдах гэмт хэрэг нь хохирогчийн зөвшөөрсөн эсэхээс үл хамааран үйлдэгддэгийг онцгойлон заах ёстой.

- Хүн худалдах гэмт хэргийг тодорхойлох нь

³³ Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын Конвенци, 1 дүгээр зүйл.

Бий л хэлбэр, хохирогчдыг хамруулсан Хүн худалдах явдлын зөрчлийг хуульчид тодорхойлох шаардлагатай байна. Ингэхдээ дараахь зүйслийг анхаарах нь зүйтэй:

-Палермогийн Протоколтой нийцүүлж, хүүхэд худалдах гэмт хэрэг үйлдэхэд албадлага, хүч хэрэглэсэн, хуурч мэхэлсэн, эрх мэдлээ урвуулан ашигласан, эмвэл эмзэг, эрсдэлд байсан нөхцөл байдал шаардахгүй байх ёстой. Хүүхдийг хэрхэн мөлжсөнөөс үл хамааран гэмт этгээдийг хариуцлагад татах ёстой.

-Ямар ч нөхцөлд хуулиар хүүхдийг гэм буруутайд тооцож эрүү үүсгэх ёстой. Худалдагдсан, бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийг хууль зөрчигч бус хохирогч хэмээн үзэх ёстой. Биеэ үнэлэх зэрэг хууль бус ажиллагаанд худалдагдсанаасаа болж хүүхдүүд эрүүгийн ял шийтгэл хүлээхгүй гэдгийг хуулиар тусгайлан зааж өгөх шаардлагатай. Хохирогчдыг хорих, цагдан хорих болон бусад байдлаар шийтгэхгүй.

-Хүн худалдах гэмт хэрэгт заавал хүнийг олон улсын хил давуулан тээвэрлэсэн байх шаардлага тавигдах ёсгүй. Олон хүүхдийг улс орон дотроо, ихэвчлэн хөдөөнөөс хот, суурин газар руу тээвэрлэж худалддаг. Аялал, жуулчлалтай холбоотойгоор хүн худалдах явдал нь хот, суурин газрууд, амралт цэнгээний дүүрэгт төвлөрдөг. Хөдөө аж ахуйн зорилгоор улирлын шинж чанартай шилжих хөдөлгөөн нь хүүхдийн хөдөлмөрийг нэмэгдүүлдэг. Зарим тохиолдолд хүүхдийг хамаатан, садан, гэр бүлийн болон найз нөхдийнх рүү явуулж тэдгээр нь ахуйн ажилчин болж үлддэг. Дотоодын болон олон улсын хэмжээний хүүхэд худалдах явдал нь аюултай бөгөөд эрүүгийн хуулиар хориглосон гэмт хэрэг байх учиртай.

Филиппиний Хүн худалдах явдлын эсрэг 2003 оны хууль нь уг гэмт хэргийн хохирогчдыг хамгаалж, тэдний зөвшөөрсөн явдлыг үл хамааруулан, хүн худалдах гэмт хэргийн хохирогчдийг аливаа хэлбэрээр шийтгэхгүй гэдгийг тогтоожээ. Хүн худалдах гэмт хэргийн бүх хэлбэрийг уг хуулиар 20 жилийн хорих ял дээр нэмэгдэл ял болгож торгууль оногдуулж шийтгэдэг байна. Хохирогч нь хүүхэд байсан болоод худалдагдсанаас болж сэтгэл зүйн өөрчлөлтөнд орсон, эсхүл ХДХВ/ ДОХ-оор өвчилсөн тохиолдолд гэмт этгээдийг насаар нь хорих ял байдаг байна³⁴.

- Ял шийтгэл

Хатгах, хамжих, завдах, зогсоох үйлдэл хийгээгүй буюу эс үйлдэхүй, урьдчилан үгсэн тохиролцох зэрэг хүн худалдах гэмт хэрэгтэй холбоотой бүхий л үйлдлийг эрүүгийн хуулийн дагуу шийтгэх ёстой.

Түүнчлэн, хүн худалдах явдалтай холбоотой бүх гэмт этгээдийг, үүнд ажил олгогч, зохион байгуулагч, биеэ үнэлэгчдийн зуучлагчид, янхны газрын эзэд, эзэгтэй нар,

³⁴ Филиппиний Бүгд Найрамдах Улс, Хүн худалдах гэмт хэргийн эсрэг 2003 оны хууль, Бүгд найрамдах улсын 9208 дугаар хууль, Филиппиний Бүгд Найрамдах Улсын 12 дугаар Конгресс.

биеэ үнэлэгч худалдагч болон “үйлчлүүлэгч”-дийг яллах ёстой. Хүн худалдах явдалд оролцсон хамжигч болох хилийн ажилтнууд, цагдаа, баримт бичиг үйлдвэрлэгч, сургуулийн багш, хүмүүнлэгийн ажилтан, тосгоны ахлагч болон тээврийн ажилтнууд ч мөн хариуцлагаас мултрах ёсгүй. Тэдэнд захиргааны сахилгын болоод эрүүгийн ял шийтгэл оногдуулах ёстой.

Цэнгээний, аялал жуулчлал, болон хууль бус үйл ажиллагаа эрхэлдэг, дэмждэг байгууллагууд зэрэг хүн худалдах гэмт хэрэгт холбогдолтой байгууллагуудад ч мөн эрүүгийн болон иргэний хариулага, санкци ногдуулах ёстой.

АНУ-ын нэгэн сексд суурилсан аялал жуулчлалын компанид анх 2004 оны 2 дугаар сард эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр ялласан байна. Тус компаний эздийг биеэ үнэлэх явдлыг хөхүүлэн дэмжихийг хориглодог Нью Йоркийн Эрүүгийн хуулийн 230,25 дахь хэсгийг зөрчсөн хэмээн ялласан байна.³⁵

Боочлол, түүнтэй адилтгах үйл ажиллагаа, бэлгийн мөлжлөг, хууль бус үрчлэлт, сэксст суурилсан аялал жуулчлал, албадан зарцлах, албадан буюу хүчээр хөдөлмөрлүүлэх, зэвсэгт мөргөлдөөнд хүчээр элсүүлэх, өр зээлээр барьцаалах, хүчээр гэрлүүлэх, хүчээр үр хөндүүлэх, хүчээр жирэмслүүлэх, бие махбодийн гэмтэл учруулах, хүн хулгайлах, хууль бусаар хорих, хөдөлмөр мөлжих, баримт бичиг хураах, хээл хахууль зэрэг холбогдох бүхий л эрүүгийн хуулийн дагуу хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх ёстой.

Хүн худалдах гэмт хэрэгт холбогдох зохицуулалтыг олж тогтоохын тулд парламентчдыг хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулиудыг эргэн хянахыг уриалж байна. Хүн худалдах гэмт хэрэгтэй холбоотой зөрчлүүдэд тухайн зөрчлийн хэр хэмжээтэй нийцэхүйц санкци буюу ял шийтгэлийг тогтоож өгөх шаардлагатай байна. Хорих, торгох, эд хөрөнгө хураах, барилга байгууламжийг хаах, нийтийн тусламж, татварын хөнгөлөлт зэргээс хасах, худалдаа, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хасах зэрэг хэлбэрээр ял шийтгэл оногдуулах ёстой.

Хохирогч нь 18-аас доош насны байх тохиолдол оногдуулах ялыг хуулиар хүндрүүлж, холбогдох үндсэн хөнгөн ялд нь тусгаж өгөх ёстой. Насыг нь мэдсэн эсэхээс үл хамааран хүүхдийг мөлждөг, бэлгийн харьцаанд орохын тулд мөнгө төлдөг этгээдүүдэд эрүүгийн санкцийг хэрэгжүүлэх ёстой.

Швед улсын Бэлгийн үйлчилгээ худалдаж авах явдлыг хориглох тухай хууль 1998:408 нь биеэ үнэлэх, хүн худалдах болон бэлгийн үйлчилгээ худалдаж авахыг хориглодог ба худалдагчийг бус худалдан авагчийн шийтгэдэг. Энэхүү хуулийн

³⁵ Нью Йоркийн Эрүүгийн хуулийн 230.25 дахь хэсэг: Мэдсээр байж дараахь үйлдлийг хийсэн бол биеэ үнэлэх явдлыг дэмжин тэтгэсэн гэж үзнэ:

1.Хоёр буюу түүнээс дээш биеэ үнэлэгчийн биеэ үнэлэх явдалтай холбогдох биеэ үнэлэх байр буюу биеэ үнэлэх бизнес, үйлчилгээг ганцаар буюу бусадтай хамтран зохицуулах, зохион байгуулах, өмчлөх буюу удирдаж биеэ үнэлэх явдлаас орлого буюу ашиг хонжоо олвол, эсхүл

2.19-өөс доош насны хүний биеэ үнэлэх явдлаас орлого буюу ашиг хонжоо олвол. Биеэ үнэлэх явдлыг дэмжин тэтгэх нь 3 дугаар зэргий Д ангиллын зөрчил юм.

дагуу биеэ үнэлэгч этгээдүүд нь эрүүгийн болон эрх зүйн аливаа хариуцлага хүлээдэггүй ажээ. Уг хуульд: “Ердийн бэлгийн харьцаанд орохдоо төлбөр төлсөн этгээдийг нь 6 сар хүртэл хугацаагаар хорих ялыг шийтгэнэ. Шведийн Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлгийн дагуу уг гэмт хэргийг завдсан этгээдэд мөн ял шийтгэл оногдуулна.”³⁶

Ялыг хүндрүүлэх нөхцөл байдалд төрийн албан тушаалтан, байгууллага, зохион байгуулалттай гэмт бүлэглэл, хүүхдүүдийн хувьд эрх мэдэлтэй этгээд (тухайлбал сургуулийн ажилтан, хүүхдийг болон нийгмийн сайн сайхныг хамгаалах, аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий этгээд)-ийн оролцоо орсон, эхнэр, нөхөр, гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг худалдах, худалдахаар урьдчилан тохиролцон төлөвлөх зэргийг хамруулах нь зүйтэй.

Хятадын Эрүүгийн хуулийн 361 дүгээр зүйлийн дагуу биеэ үнэлэх явдалд оролцсон, зохион байгуулсан зочид буудал, цэнгээний бизнес буюу таксиний үйлчилгээний ажилтан ял шийтгэл хүлээдэг байна³⁷.

Бельги улсад Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулийн 382 дугаар зүйлийн дагуу насанд хүрээгүй хүнийг биеийг нь үнэлүүлэх, мөлжвөл гэмт этгээдэд уушийн газар, ажил олгох газар, тамхины дэлгүүр, тоглолт хийгддэг цайны газар, бүжгийн танхим, массаж, иллэгний газар, хумс янзлах газар зэргийг ажиллуулахыг хориглодог ажээ. Түүнчлэн, зөрчил болсон газрыг хаах, гэмт этгээдүүдийг насанд хүрээгүй хүмүүст багшлахыг хориглох арга хэмжээг шүүх хэрэгжүүлэх эрхтэй байдаг байна.³⁸

Мадагаскар улсад биеэ үнэлэх явдлыг зохион байгуулахыг хориглодог байна. Тус улсын Эрүүгийн хуулийн 334 дүгээр зүйлийн 1-5 дугаар хэсгүүдэд заасны дагуу хохирогч нь 18-аас доошны насны, эсхүл хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашигласан бол, эсхүл гэмт этгээд нь хохирогчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч буюу багш бол, эсхүл биеэ үнэлэх явдалтай тэмцэх, нийгмийн эрүүл мэнд, хэв журмыг хамгаалах, хангах үүрэгтэй бол хорих ял нь 2-5 жилээр нэмэгдэх ажээ.³⁹

Гамби улсын төрөөс өсөн нэмэгдэх хүүхдийн бэлгийн мөлжлөгт суурилсан аялал жуулчлалд хариу арга хэмжээ авах зорилгоор 2003 онд Аялал жуулчлалын зөрчлийн талаарх шинэ хууль батлан гаргасан байна. Уг хуулиар хүүхдийн бэлгийн мөлжлөгийг зөрчилд тооцож, уг зөрчил гаргагчид хатуу ял шийтгэл оногдуулдаг ажээ. Түүнчлэн Гамбийн Аялал жуулчлалын Газрын ивээл дор 2003 оны 3 дугаар сард олон байгууллагын төлөөллөөс бүрдсэн Аялал жуулчлал дахь Хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх Үндэсний Ажлын хэсэг байгуулагджээ. Уг ажлын хэсэг нь Засгийн газрын байгууллагууд, НҮБ-ын Хүүхдийн Сан, төрийн бус байгууллагууд,

³⁶ Бэлгийн үйлчилгээ худалдаж авах явдлыг хориглох тухай Шведийн хууль (1998:408)

³⁷ Хятадын Эрүүгийн хуулийн 361 дүгээр зүйл, 8 дугаар хэсэг. [www.protectionproject.org, February 2005].

³⁸ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

³⁹ Мадагаскар улсын Эрүүгийн хууль: 4 дүгээр хэсэг, Нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг, 334 дүгээр зүйлээс. [www.protectionproject.org, February 2005].

аялал жуулчлалын байгууллагууд, зочид буудал болон зоогийн газруудаас бүрддэг ба аялал жуулчлалын байгууллагууд, зуучлагчид болон зочид буудал, зоогийн газар болон бар, цэнгээний газрын эздэд зориулсан Аялал жуулчлалын Ёс зүйн дүрэм боловсруулж байгаа ажээ.⁴⁰

- Хууль үйлчлэх нутаг дэвсгэрийн хүрээ

Хүн худалддаг этгээдүүдийн эсрэг Эрүүгийн хуулийг хэрэглэхийн тулд улс орнууд нь уг хуулийн үйлчлэлийн хүрээг өөрсдийн нутаг дэвсгэрээс гадуур уг зөрчлийг үйлдэж буй иргэддээ хамааруулахаар өргөжүүлэх шаардлагатай. Хүн худалддаг этгээдүүдэд хууль үйлчилдэг байлгахын тулд хууль тогтоогчид уг зөрчлийн гэмт этгээдүүдийг шилжүүлэх зохицуулалтыг бий болгож ийм зохицуулалттай хоёр талт болон олон талт гэрээ, хэлэлцээр байгуулж, өөрийн дотоодын хууль тогтоомжийг гадаад улсад уг гэмт хэргийг үйлдсэн этгээдэд үйлчлэхээр тусгайлан зохицуулалт хийх шаардлагатай байна.

Иймээс хууль тогтоогчид хүүхдийн бэлгийн мөлжлөгт суурилсан аялал жуулчлалыг эрүүгийн гэмт хэрэг болгож, гадаад орны нутаг дэвсгэрт бэлгийн мөлжлөгт оролцдог иргэдэд хууль тогтоомж нь үйлчилдэг болгох шаардлагатай байна. Цаашилбал, улс орнууд гадаад орны нутаг дэвсгэр дээр бэлгийн мөлжлөгт оролцдог этгээдүүдийг бус хүүхдийг татан оролцуулдаг сексийн аялал жуулчлалын зохион байгуулдаг, дэмждэг хүмүүсийг ч мөн адил хариуцлагад татах ёстой.

Канад улс нь Эрүүгийн хуулиа өөрчилж (үүнд хүүхдийн биеэ үнэлэх явдал, хүүхдийн бэлгийн мөлжлөгт суурилсан аялал жуулчла, хүүхдийн садар самуун, хүүхдийн садар самуун ба интернэт, эмэгтэй хүний бэлэг эрхтнийг гэмтээх болон эрүүгийн бэлгийн дарамт, шахалт үзүүлэх) нутаг дэвсгэрээс гадна үйлдэгдсэн зөрчлийг хуулийн үйлчлэлд хамруулах буюу гадаад орны нутаг дэвсгэр дээр хүүхдийг бэлгийн мөлжсөн Канадын иргэдийг эрүүгийн хариуцлагад татаж яллах зохицуулалт бүхий C-27, C-15A хуулиудыг хамруулсан байна⁴¹.

Хүн худалдах явдлаас урьдчилан сэргийлэхийн тулд хүүхэд худалдах явдлын эрэлтийг тэтгэдэг хүчин зүйлсэд ч ижил хэмжээний ач холбогдол өгч тэмцэх шаардлагатай.

Б. Хуулийн хэрэгжилтийг сайжруулах

Цагдаа, прокурор, хилийн хяналт, цагаачлалын ажилтнууд болон шүүгчид зэрэг хүн худалдах явдалтай холбогдон ажиллах хууль хэрэгжүүлэх байгууллагын ажилтнуудаас бүрдсэн “хүн худалдах тусгай хэсэг” байгуулах нь өндөр ач холбогдолтой. Ийм хэсгүүдэд нийгмийн ажилтнууд, хүүхдийн эрхийн ажилтнууд болон хууль хяналтын эмэгтэй ажилтнууд байх нь зүйтэй. Гишүүдийг хүн худалдах

⁴⁰ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан Гамби улс дахь хүүхдийн бэлгийн мөлжлөгийн талаарх Судалгаа, 2003 оны 12 дугаар сар.

⁴¹ Canada Consular Affairs: Child Sex Tourism Fact Sheet. [www.voyage.gc.ca/main/pubs/child_fact-en.asp, February 2005]

явдлын хохирогчдыг таних, тэдгээрийн эрх, тодорхой шаардлагуудыг болон зохих үйлчилгээ, туслалцааг өгөх байгууллагуудад хандах журмыг мэддэг байх чадвартай болгох сургалтанд хамруулах шаардлагатай. Түүнчлэн авилга, хээл хахуульд автсан хууль хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтанд үйлчлэх хэм хэмжээ, ял шийтгэлийг боловсруулж батлах нь чухал. Дор хаяж, эрүүгийн гэмт явдалд сэжиглэгдэж буй хууль хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтанд хөндлөнгөөс хяналт, шалгалт явуулдаг байх нь зүйтэй.

Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх явдал нь олон салбарыг хамарсан, гэмт явдал, хохирогчдын хэрэгцээнд хариу арга хэмжээ авдаг байвал хамгийн их үр дүнд хүрнэ. Хүүхэд хамгаалал нь хууль хэрэгжүүлэлтийн нэгэн салшгүй хэсэг юм.

Этиоп дахь Гудамжны хүүхдийн Уулзалтаас цагдаагийн хэсгүүдэд хүүхдийн эрхийн сургалтанд хамрагдсан, хүүхэд, залуучуудад тулгардаг хүндрэл, бэрхшээлийг мэддэг ажилтнуудтай хүүхэд-хамгааллын хэсгүүдийг байгуулахад туслалцсан байна. Цагдаагийн ахлах ажилтнууд болон хууль зүйн удирдлагын зүгээс гаргасан хүчин чармайлтын дүнд гагцхүү хүүхдийн асуудалд төвлөрөн ажиллах мэргэшсэн ажилтнуудыг цалинжуулах энэхүү санхүүжилтын хөтөлбөр хэрэгжих боломжтой болсон юм. Түүнчлэн зарим ажилтнууд эдгээр хэсгүүдэд сайн дураараа орж, хүүхдүүд, тэдгээрт тулгамдсан асуудалд ихээхэн хүчин чармайлт гаргасан байна.⁴²

В.Холбогдох хуулиуд

Цагаачлалын болон хөдөлмөрийн хуулиуд нь хүүхэд худалдах явдалд шууд нөлөөлөх боломжтой. Хууль тогтоомжийн зохицуулалтын хянаж, хөдөлмөрийн болон цагаачлалын бодлого нь хүүхэд хамгааллын үзэл баримтлалтай байгаа эсэхийг шалгах нь чухал юм.

- Цагаачлалын бодлого

Хүн худалдах явдлыг сааруулах үүднээс шилжих хөдөлгөөний бодлоготой холбоотой алхмуудыг парламентчид хэрэгжүүлж болно. Тухайлбал, цагаачлах хүсэлтэй хувь хүмүүс, гэр бүлүүдэд туслалцаа үзүүлэх үндэсний алба байгуулж болно. Уг байгууллага нь утсаар болон бусад хэлбэрээр хууль ёсоор шилжих, цагаачлах, очих улс оронд мөнгө олох боломж, ажил хайхтай холбоотой эрсдэл зэрэг мэдээллийг өгч болох юм. Боомт, нисэх буудал, галт тэрэгний буудал, хилийн шалган нэвтрүүлэх зэрэгт олноор цагаачилдаг орны хэлээр мэдээлэл байх нь нэн чухал юм.

Хараа хяналтгүй дүрвэгч хүүхэд буюу баримт бичиггүй орогнол хүсэгч хүүхэд нь хүн худалдагч этгээдүүдэд олзлогдох магадлал өндөр буюу өөрсдөө ч олон улсын хилийг хууль бусаар нэвтрэхийг хүсч байж болно. Эдгээр хүүхдүүд нь ихэнхдээ

⁴² End Child Prostitution, Child Pornography and Trafficking of Children for Sexual Purposes (ECPAT) International-оос гаргасан Good Practices in Combating Commercial Sexual Exploitation in Children буюу Хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх нь. [www.ecpat.net, February 2005]

тухайн улсад байгаа гэр бүлийн хүн дээрээ эсвэл ажил, орогнол хайж байх нь түгээмэл.

Улс орнууд үндэсний аюулгүй байдлаа хангахад чиглэгдсэн арга хэмжээнүүд нь хил давж буй хүүхдүүдэд тулгарах эсрдлийг нэмэгдүүлсэн юм. Насыг нь тогтоох нотлох баримтгүй, бичиг баримтгүй хүүхдүүдийг тодорхой бус хугацаагаар саатуулж хорих магадлал өндөр байдаг.

Эдгээр бүх нөхцөл байдлуудад хүүхдэд хуулийн зөвлөгөө өгч, гэр бүлээ олоход нь, ингэх боломжгүй бол зохих тусламж хүрэхэд нь туслах хэрэгтэй. Ямагт хүүхдийн эрх ашгийн үүднээс хандвал хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдал зөрчигдөхгүй.

Органик хууль 4/2000-ийн 55 дугаар зүйлийн дагуу Испани улс руу хууль бус наймаа буюу бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдагдсан хүмүүсийн Испани улсад хууль бусаар зорчсон болоод зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн үйлдлийг нь захиргааны хариуцлагаас чөлөөлдөг байна.⁴³

- Хөдөлмөрийн хууль тогтоомж

Хүн худалдагчид ихэнх тохиолдолд хохирогчдыг хөдөлмөр эрхлүүлнэ хэмээн худал амлалтаар татдаг учир хөдөлмөрийн хууль тогтоомжийг энэ асуудалд хамааралтай юм. Сайн зохицуулалттай хөдөлмөрийн хуулиуд нь хөдөлмөрлүүлэх зорилгоор хүүхэд худалдах явдлыг сааруулах нөлөөтэй байдаг. Тухайлбал, парламентчид насанд хүрэгчдийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хатуу хэрэгжүүлснээр хүн худалдагчид хүүхдүүдийг олзлох явдлыг сааруулж хүүхдийн хөдөлмөрийг мөлжих хүн худалдах явдлаас урьдчилан сэргийлж болно.

Этиоп улсын төр Хувийн хөдөлмөрийн Агентлагийн Тунхаглал 104/1998-ийг баталж Булангийн орнууд руу худалдагдаж буй Этиоп эмэгтэйчүүдийн асуудлаарх Сайд нарын Үндэсний Хороог байгуулсан байна. Уг тунхаглалын зорилго нь хөдөлмөр, үйлчилгээний бүхий л байгууллагуудыг зохицуулж, ажилчдын хүний эрх, бие махбодийн зөрчилд хатуу чанга ял шийтгэх замаар гадаад орнууд руу явуулсан болон хөдөлмөр эрхэлж буй этиопчуудын эрх, аюулгүй байдал, эрхэмсэг оршихуйг хамгаалах явдал ажээ⁴⁴.

- Хүүхэд үрчлэлтийн хууль тогтоомж

Үрчлэлтээр хүүхэд худалдах явдлын зохицуулалт нь хүн худалдах явдлын эсрэг хууль тогтоомжийн нэг үндсэн хэсэг юм. Хүүхдийг үрчлэх зорилгоор худалдах явдлын үндэслэл болох хуулийн хийдлийг арилгах үүднээс үрчлэлтийн хууль тогтоомжийг хянаж сайжруулах нь чухал билээ.

⁴³ The Protection Project [www.protectionproject.org, February 2005].

⁴⁴ Кебеде, Емебетийн Ethiopia: An assessment of the international labour migration situation, the case of the female labour migrants буюу Этиоп улс: олон улсын хөдөлмөрийн шилжилтийн нөхцөл байдал, эмэгтэй хөдөлмөрийн хүчний нүүдэл, Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын Жендерийг дэмжих Хөтөлбөр, Эмэгтэйчүүд ба Шилжилтийн талаарх цуврал, Женев хот.

Парагуай улсын Эрүүгийн хуулийн 223 дугаар зүйлд хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн туршлагагүй байдал, хэрэгцээ шаардлага болон дорой байдлыг далимдуулан хүүхдийг тодорхой үнээр хуурамчаар үрчлүүлэхээр өгөхөд хүргэхийг хууль буст тооцдог байна.⁴⁵

Польш улсын Эрүүгийн хуулийн 253 дугаар зүйлийн дагуу хууль бус орлого олох зорилгоор хүүхдийн үрчлэлтийг зохион байгуулах явдлыг хүн худалдах гэмт хэрэгт хамааруулдаг бөгөөд хориглодог байна.⁴⁶

Колумб улсын Эрүүгийн хуулийн 232 дугаар зүйлийн дагуу “ердийн бус үрчлэлт” нь гэмт хэрэгт тооцогддог бөгөөд насанд хүрээгүй хүний үрчлэлтийг дэмжсэн, зохион байгуулсан боловч холбогдох хуулийн шаардлагыг биелүүлээгүй, Колумбын Гэр бүлийн хамгааллын Институцээс зөвшөөрөл аваагүй, буюу хүүхдэд хортой ердийн бус зан үйлтэй хүнийг 1-5 жил хорих ялаар шийтгэдэг. Хэрэв уг үйлдлүүдийг ашиг олох зорилгоор буюу өөрийн албан тушаалын байдлаа ашигласан бол ял шийтгэлийг хүндрүүлдэг байна.⁴⁷

- Хамгаалал, тусламжийн зохицуулалттай хууль тогтоомж

Хохирогчдын хамгаалал, тэдэнд тусламж үзүүлэх талаар зохицуулалт агуулсан хуулиуд нь хүн худалдах явдалтай хамааралтай хууль тогтоомжийн хүрээний нэгэн хэсэг болно. Хохирогчдод туслалцаа үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг заагаагүй бол хүн худалдах явдлыг гэмт хэрэгт тооцдог хуулиуд учир дутагдалтай байна гэсэн үг. Хохирогчдын хамгаалал, тэдэнд үзүүлэх тусламжийн талаарх хууль зүйн асуудлыг 13 дугаар бүлэгт тусгасан болно.

Наймдугаар бүлэг

Хандлага, уламжлал, хэвшил

Бага насны хүүхэдтэй хавьтах, зодож шийтгэх, аюултай уламжлалт заншил, охид хөвгүүдийг хариилцан адилгүй үнэлэх үнэлгээ зэрэг доромжлол, хүчирхийллийг хангадаг нийгэмд хүүхдийн амьдрах орчин нь аюулгүй байж чадахгүй. Хүүхдийн хүчирхийллийн аливаа хэлбэрийг хориглодог, зан заншил уламжлалаараа хүүхдийн бүхий л эрхийг хүндэлдэг нийгэмд хүүхдийг хамгаалах боломжтой юм.

А. Хүйсийн ялгаварлан гадуурхалттай тэмцэх нь

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн болоод охид, хөвгүүдийн хоорондын тэгш бус байдал нь хүүхэд худалдах явдлыг төрүүлдэг. Охид, эмэгтэйчүүдийг ялгаварлах явдал түгээмэл байдаг. Хууль, бодлого, амьдрал дахь охид, эмэгтэйчүүдийг доройд үзэх

⁴⁵ Парагуайн Бүгд Найрамдах улс, Парагуайн Бүгд Найрамдах улсын Эрүүгийн хууль болон Шинэчилэн найруулсан бусад холбогдох хуулиуд: 4 дүгээр Хэсэг, 1 дүгээр бүлэг, Иргэний статус, ёс суртахууны хэм хэмжээ болон гэр бүлийн тогтвортой байдлын эсрэг гэмт хэрэг, 223 дугаар зүйл.[www.projectionproject.org, February 2005].

⁴⁶ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

⁴⁷ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

үзэл нь доромжлолд өртөмтгий болгодог. Тэднийг үнэлэх харьцангуй үнэлэмж нь тэднийг худалдах нөхцөл байдалд хүргэдэг.

Ялгаварлан гадуурхах явдал дараахь үед тодорхой илэрдэг:⁴⁸

- Төрсөн үеэс, түүнээс ч өмнө хүйсээс хамаарч охидыг хөвгүүдээс дутуу үнэлж, халамжилдаг бол үр хөндүүлэх явдлаар
- Гэр бүлийн дотор, охид нь бага наснаасаа дорой байр суурьтай хэмээн ойлгож, охид эмэгтэйчүүдэд л тохирох үүрэг гүйцэтгэж, хөвгүүд болон эрэгтэйчүүдээс бага хоол идэж, бага эдийн засгийн нөөц эдэлж, боловсрол, ажил, зугаа цэнгэл болон бусад боломж хүртэх хүртээмжийг нь хязгаарлаж, гэр ахуйн болон хүүхэд асаргааны тэнцвэргүй ачааг үүрч, өмчлөх эрхийг тэгш эдлэхгүй, шийдвэр гаргах явцад тэгш оролцох боломжоор хангагдахгүй байх явдлаар
- Сургууль дээр, багш, хичээлийн хөтөлбөр, сурах бичиг болон заах арга нь хүйсийн ташаа ойлголт болон бэлгийн дарамт, шахалт, заналхийлэл болон ялгаварлалд өртөх, зохих хэрэгсэл, тохижуулалт байхгүй байх буюу тэдгээр нь зохимжгүй байх явдлаар
- Хамт олон, нийгэмд, охид, эмэгтэйчүүдийг доромжилсон, мөлжсөн үйлдлийг зөвшөөрч, шийтгэлгүй өнгөрөөх нөхцлөөр
- Бусад бүх газар, гэрт, нийгэм, хамт олны дунд, үндэсний болон олон улсын түвшинд охид, эмэгтэйчүүдийн амьдралын нөхцлийг тодорхойлох шийдвэр гаргах явцад тэднийг өөрсдийг нь оролцуулдаггүй байдлаар илэрдэг.

Парламентчид аливаа ажилдаа охид эмэгтэйчүүдийн эзлэх статусыг дэмжиж, буруу ташаа хандлага, зан үйлийг өөрчлөхөд оролцох шаардлагатай байна. Европын Холбооны Зохион байгуулалттай гэмт хэргийн олон салбарын бүлэг нь хүн худалдах явдлыг зогсоохыг зоригч хууль тогтоогчдын авбал зохих урьдчилсан арга хэмжээний жагсаалтыг боловсруулжээ. Хүн худалдах явдалтай үр дүнтэй тэмцэх хууль тогтоомж, бодлого нь дараахь шинжтэй байх ёстой⁴⁹:

- Эмэгтэйчүүдийн хууль зүй, нийгмийн тэгш байдал, охид эмэгтэйчүүдийн хүний эрхийг хамгаалж, баталгаажуулах.
- “Эмэгтэйчүүдийн нийгэмдээ бүрэн оролцох, хүчирхэгжих явдлыг дэмжих, нэн ялангуяа боловсролын болон эдийн засгийн амьдралд нь.”

⁴⁸ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан Equality, Development and Peace буюу Тэгш байдал, Хөгжил, Энх тайван, НҮБ-ын Хүүхдийн Сан, 2000 он.

⁴⁹ Брюссель хот, Declaration on Preventing and Combating Trafficking in Human Beings буу Хүн худалдах явдлаас урьдчилан сэргийлж, тэмцэх тухай Тунхаглал, Ерөнхий нарийн бичгийн дарга нарын газар, Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх олон салбарын бүлэг, Европын холбооны Зөвлөл, 2002 оны 11 дүгээр сарын 29% 14981/02, 3, 8.

- Ядуурлыг бууруулж, эмзэг бүлэг, нэн ялангуяа охид, эмэгтэйчүүдийг дорд үзэх явдлыг “илүү сайн засаглал, материаллаг туслалцаа, нийгмийн хамгаалал болон хөдөлмөр эрхлэх боломж, тогтвортой эдийн засгийн хөгжлөөр” таслан зогсоох.
- “Хууль ёсны, ашигтай, мөлжлөгийн бус хөдөлмөрийн шилжилт хөдөлгөөн” хийх нөөц бололцоог нэмэгдүүлэх.

Б. Хүүхдийн хөдөлмөр, бэлгийн мөлжлөгийн талаарх хандлагыг өөрчлөх нь

Хүүхэд сургуульд сурснаас гэртээ ажил хийхийг илүүд үзэх, эсхүл эрэгтэйчүүд мөнгө төлж хүүхэдтэй бэлгийн харьцаанд орохыг хүлээн зөвшөөрөх зэрэг мөлжлөгийн дэмждэг уламжлал болон хандлагатай газар доромжлол газар авсаар байх болно. Мөлжлөгийн эрэлтийг бууруулахад хууль зүйн оролцоо болоод энэхүү байдлыг хүлээн зөвшөөрдөг хандлагыг өөрчлөх шаардлагатай байна. Ийм хандлагыг өөрчлөхөд ялгаварлал болон уршигт энэ зан үйлийн эсрэг дуу хоолойгоо сонгосноор парламентчид гол үүрэг гүйцэтгэж чадна. Түүнчлэн сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр нь эдгээр зүй бус хандлагыг үгүйсгэх боломжтой.

Хүүхдийн бэлгийн мөлжлөгийг зогсооход чиглэгдсэн Их Британи ба Ирланд улсын Stop it Now буюу Үүнийг одоо Зогсоо хэмээх санаачилга нь хүүхдийн бэлгийн доромжлолыг хүмүүс өөрөөр тусган авч, тэр тухай илүү их ярилцаж, бусад насанд хүрэгчид болон хүүхдүүдийн санаа бодлыг сонсдог болгох, улмаар тэдгээр хүмүүсийн хандлагыг өөрчлөх зорилготой кампанит ажлуудыг хэрэгжүүлж эхлээд байна.⁵⁰

Болив улсад нэгэн самрын салбарт ажилласан Хүүхдийн Хөдөлмөрийг устгах Олон улсын Хөтөлбөрийн нэгэн төсөл нь хүүхдийн хөдөлмөр болон эмэгтэйчүүдийн ялгаварлан гадуурхах явдлыг хамгийн чухал сэдэвт тооцжээ. Уг төсөл нь энэхүү самрын салбарын ажилчдын наймаалцах чадварыг дээшлүүлж улмаар тэдгээрийн хөдөлмөрийн нөхцлийг сайжруулахыг зорьдог юм.⁵¹

Филиппин улсад хэрэгжиж буй нэгэн боловсролын төсөл нь биеэ үнэлэх явдалд холбогдсон хөвгүүд, залуучуудтай ажилладаг. Уг төсөл нь биеэ үнэлдэг охид, эмэгтэйчүүдийн худалдан авагч болж байгааг ухамсарлуулж, биеэ үнэлэх явдал болон хүн худалдах явдлын талаар хөвгүүд, эрэгтэйчүүдэд мэдээлэл өгч сургадаг.⁵²

Есдүгээр бүлэг

⁵⁰ Поу Марион, Нэгдсэн Вант улсын Парламентын гишүүн, Statement on Commercial Sexual exploitation and the Internet: Challenges and strategies to respond буюу Бэлгийн мөлжлөг ба Интернэтийн тухай хэлсэн үг: Тулгамдсан асуудал, даван туулах арга зам, Мехико хотод 2004 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Парламентын Холбооны Бага хурал дээр хэлсэн үгнээс.

⁵¹ Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан A Future without Child Labour буюу Хүүхдийн хөдөлмөргүй ирээдүй, ILO, 2002 он, 70 дугаар хуудас.

⁵² Эмэгтэйчүүдийг худалдах явдлын эсрэг эвсэл. Эвслийн тайлан (2003). <http://action.web.ca/home/catw/attach/catw2003report.pdf> вэб сайтаас үзэх боломжтой.

Асуудлыг хөндөж, ойлголтыг нэмэгдүүлэх нь

Хамгийн анхан шатандаа хүүхдүүд өөрсдөд нь болон бусдад хамааралтай хүүхэд хамгааллын асуудлуудын талаар үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй байх шаардлагатай. Үндэсний түвшинд энэхүү асуудалд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон иргэний нийгмийн оролцоо нь хүүхэд хамгаалалд хувь нэмрээ оруулна. Үр дүнтэй, зохион байгуулалттай хариу өгөхийн тулд бүх шатны хамтын ажиллагаа шаардагдаж байна.

А. Иргэний нийгмийн оролцоо

Хүүхэд худалдах, хүүхэд хамгааллын асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг, харилцан санал солилцлыг дэмжих нь үр дүнтэй бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхийн гол түлхүүр юм. Хүүхэд худалдах явдал нь олон хүний эрх, ашиг хөндөгддөг, олон гол тоглогчтой нарийн төвөгтэй асуудал юм. Тиймээс нийгмийн бүхий л холбогдох салбаруудаас хүүхэд худалдах явдалтай хийх тэмцэлд хамруулах нь чухал байдаг.

Иргэний нийгэмд, үүнд хувийн хэвшлийн салбарт ч хамтын ажиллагаа хэвшүүлэх нь хүн худалдах явдалтай тэмцэх дотоодын хөтөлбөрүүдийн үр нөлөөг дээшлүүлнэ. Хамт олон, нийгэмд суурилсан байгууллагууд дийлэнхдээ нийгэм дэх энэ талын ойлголтыг дэлгэрүүлэх, ухуулах болон хохирогчдод дэмжлэг туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд тохиромжтой байдаг учир энэ тал дээр тэдэнд туслалцаа үзүүлэх нь зүйтэй. Энэ хүрээнд парламентчдийн зүгээс хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөр хэрэгжүүлж буй иргэний нийгмийн гишүүдэд техникийн болон санхүүгийн тусламж үзүүлэх боломжтой юм.

Хууль тогтоогчдоос аялал жуулчлал болон хүүхдийн хөдөлмөрийг ашигладаг салбарууд багтах хувийн хэвшилд ухуулан сурталчилгаа хийх хөтөлбөрүүдийг дэмжих нь зүйтэй юм. Аялал жуулчлалын салбар нь өөрийн ажилтнууд, жуулчдад хүн худалдах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгт холбогдох дотоодын хууль тогтоомж, түүнчлэн зөрчил гарсан байх сэжигтэй нөхцөл байдлын үед хэрхэн холбогдох байгууллагад хандах зэргээр бэлтгэж хүүхэд худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх явдалд гол үүрэг гүйцэтгэж болох юм.

Аялал жуулчлал дахь Бэлгийн Мөлжлөгөөс Хүүхдийг Хамгаалах тухай Ёс зүйн Дүрэм (“Дүрэм”) нь аялал жуулчлалын салбарыг End Child Prostitution, Child Pornography and the Trafficking of Children for Sexual Purposes буюу Хүүхдийн биеэ үнэлэх явдал, Садар самуун, Бэлгийн зорилгоор хүүхэд худалдах явдлыг Зогсооё хэмээх хүүхдийн эрхийн төрийн бус байгууллага, Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага, НҮБ-ын Хүүхдийн Сан зэргийг нэгтгэсэн төсөл юм. Зорилго нь аялал жуулчлалын газруудад хүүхдийн бэлгийн мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх явдал юм.

Аялалын байгууллагууд болон тэдгээртэй холбогдох байгууллагууд, зуучлагчид, зочид буудал, авиа компаниуд зэрэг нь дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхээр амлалт өгч Дүрмийг баталдаг байна:

1. Хүүхдийн бэлгийн мөлжлөгийн эсрэг ёс зүй бүхий байгууллагын дотоодын бодлого боловсруулах.
2. Эх үүсвэрийн болон эцсийн орнууд дахь ажилтнуудаа бэлтгэх, сургах.
3. Ханган нийлүүлэгчидтэй хийх гэрээндээ хүүхдийн бэлгийн мөлжлөгийг үл тэвчих нийтлэг хүсэл зоригоо илэрхийлсэн зохицуулалт тусгах.
4. Сэтгүүл, танилцуулгууд, нислэгийн явцад үзүүлэх кино, тасалбар билетийн баримт, вэбсайт зэргээр дамжуулан мэдээллээр хангах.
5. Орон нутагт хандах “түлхүүр хүмүүс”-тэй холбогдох мэдээллээр хангах.
6. Жил бүр тайлагнах⁵³.

Австрали улсаас хүүхдийн бэлгийн мөлжлөгт суурилсан аялал жуулчлалын талаарх ойлголтыг дэлгэрүүлэн ухуулах, сургах зорилгоор аялал жуулчлалын салбарын байгууллагууд, төрийн болон орон нутгийн байгууллагуудтай хамтран ажилладаг Child Wise Tourism буюу Хүүхдэд ээлтэй аялал жуулчлал Хөтөлбөрийг санхүүжүүлжээ.⁵⁴

Франц улсын Боловсролын яам болон аялал жуулчлалын салбарын төлөөлөгчид хүүхдийн бэлгийн мөлжлөгт суурилсан аялал жуулчлалын талаар аялал жуулчлалын сургалтын хөтөлбөрт оруулах журам хамтран боловсруулжээ. Түүнчлэн төрийн өмчит Air France авиа компани нь нислэгийн явцад худалдах тоглоомны орлогын тодорхой хувийг хүүхдийн бэлгийн мөлжлөгт суурилсан аялал жуулчлалын талаар ухуулах хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зориулдаг байна. Түүнчлэн уг асуудлын талаар нислэгийн явцад үзүүлэх кино, материал боловсруулдгийг аялал жуулчлалын газрууд руу хийх нислэгийн явцад үзүүлдэг байна.⁵⁵

⁵³ End Child Prostitution, Child Pornography and Trafficking of Children for Sexual Purposes (ECPAT) International-оос гаргасан Code of Conduct for the Protection of Children from Sexual Exploitation in Travel and Tourism буюу Аялал жуулчлал дахь Бэлгийн Мөлжлөгөөс Хүүхдийг Хамгаалах Ёс зүйн Дүрэм, ECPAT Төсөл.

⁵⁴ End Child Prostitution, Child Pornography and Trafficking of Children for Sexual Purposes (ECPAT) International-оос гаргасан Good Practices in Combating Commercial Sexual Exploitation in Children буюу Хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх нь. [www.ecpat.net, February 2005]

⁵⁵ АНУ-ын Төрийн Департамент, Trafficking in Persons Report буюу Хүн худалдах гэмт хэргийн мэдээлэл, 2004 оны 6 дугаар сар.

Габон улсад нэгэн төслийн хүрээнд таксиний жолооч нар болон тэдгээрийн үйчлүүлэгчдийн дунд хүүхэд худалдах гэмт хэргийн талаар ухуулах сурталчилгаа хийн машин дээр наах наалтууд тараасан байна.⁵⁶

Б. Парламент дотор болон гадуур хийх нээлттэй хэлэлцүүлэг

Хүн худалдах явдалтай холбоотой мэдээллийг боловсруулж, уулзалт зохион байгуулж, тэр тухай үг хэлж, ярилцлага өгснөөрөө хүн худалдах явдлаас урьдчилан сэргийлэх, уг явдлыг цээрлүүлэх арга хэмжээний талаар орон нутгийн хууль сахиулах байгууллагуудтай зөвлөлдөх замаар хууль тогтоох шаардлагыг эрчимжүүлэх боломжтой.

Ард түмний төлөөлөл болохын хувьд, парламентчид нийгмийн үзэл санаанд ихээхэн хэмжээгээр нөлөөлөлх чадалтай байдаг. Парламентчид хүн худалдах явдал, хүчирхийлэл, доромжлол, мөлжлөгийн эсрэг зогсож буйгаа нийтэд үзүүлвэл эдгээр зүй бус явдалтай хийх тэмцлийн түрүү нь байж бусдад ч энэ талаар арга хэмжээ авах үлгэр жишээ болно.

В. Хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллах

Хүүхэд худалдагчдын үйлдэж буй мөлжлөг, доромжлолын талаар ухуулах гол суваг бол хэвлэл мэдээлэл юм. Хэвлэл мэдээлэл нь хот суурин төдийгүй хөдөө тосгоны хүн амд хүрч үзэл санаанд нь нөлөөлж чадна. Хэдий ийм ч, хэвлэл мэдээлэлтэй хамтран ажиллахдаа уг асуудлыг бодит байдлыг хэтрүүлж хүн худалдах явдалд өртсөн хүүхдүүдийг гутаахгүй байх нь чухал. Иймээс эдгээр хүүхдүүдийн нэр хаягийг нууц байлгах арга хэмжээг авах шаардлагатай болно.

Афганистан дахь НҮБ-ын Хүүхдийн Сан нь охидын боловсролын талаар радио реклам, зурагт хуудас, танилцуулга зэрэг ухуулах материал боловсруулж тарааж байгаа билээ. Түүнчлэн хүүхдийн эрхийн хангасан хэвлэл мэдээллийн ёс зүй, заншлыг бий болгох, хүүхэд залуучууд хамгааллалд оролцоход нь хэвлэл мэдээллийнхэнд дэмжлэг туслалцаа үзүүлж буй ажээ.⁵⁷

Сенегаль улсад 2002 оны 7 дугаар сард бэлгийн мөлжлөгийн талаар сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулагдсан байна. Уг сургалт нь хэвлэл мэдээлэл нь аливаа асуудлын бодит байдлыг тогтмол бодитой тусгах нь хааяа хөндсөнөөс илүүтэйгээр нийгмийн үзэл бодолд хүчтэй нөлөөлж чаддаг, чадах ч үүрэгтэйг онцолсон байна.⁵⁸

Аравдугаар бүлэг

⁵⁶ НҮБ-ын Хүүхдийн Сан, End Child Exploitation, Stop the traffic! буюу Мөлжлөгийг зогсоож, Хүн худалдахаа боль, НҮБ-ын Хүүхдийн Сан, 2003 он, 31 дүгээр хуудас.

⁵⁷ НҮБ-ын Хүүхдийн Сан, 2004 оны тайлан, НҮБ-ын Хүүхдийн сан, Нью Йорк хот.

⁵⁸ НҮБ-ын Хүүхдийн сан, Innocenti судалгааны төвийн хамтарсан Trafficking in Human Beings, Especially Women and Children, in Africa буюу Африк дахь Хүн худалдах гэмт хэрэг, тэр дундаа Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдах явдал хэмээх 2003 оны тайлан судалгааны 44 дугаар хуудас.

Хамт олон, өрхийн чадавхийг сайжруулах нь

Эцэг эхчүүд, эрүүл мэндийн ажилтнууд, багш нар, цагдаа, нийгмийн ажилтнууд болон хүүхэдтэй ажиллаж, хүүхдийг асран хамгаалдаг бусад хүмүүс хүүхэд хамгааллын асуудлуудыг мэдэж, түүнд хариу өгөх ур чадвар, мэдлэг, эрх мэдэл болон хүсэл эрмэлзэлтэй байх шаардлагатай. Хүүхдийн тоглоомын аюулгүй талбай, боловсролыг хангах зэрэг илүү өргөн хүрээний санаачилга бодлогууд нь аюулгүй орчны чадавхийг өргөжүүлдэг.

А. Орон нутгийн санаачилгыг дэмжиж хамтын ажиллагааг хөгжүүлэх нь

Төрийн бус байгууллагууд болон хамт олонд үндэслэсэн бүлгүүдийн үйл ажиллагааг тодотгож өгөх, улмаар үйл ажиллагааг нь дэмжих замаар хамт олны түвшинд парламентчид оролцох боломжтой юм. Эдгээр бүлгүүд нь үндэсний стратегийн хүрээнд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүндээ ч туслалцаа, дэмжлэг авах нь зүйтэй.

Польш улсын Засгийн газар нь хохирогч болж болзошгүй хүмүүст мэдээлэл, сургалтын шинж чанартай кампанит ажил зохион байгуулахдаа төрийн бус байгууллагуудад түшиглэж хамтран ажилладаг. Засгийн газраас хэсэгчлэн санхүүжүүлсэн нэгэн төрийн бус байгууллага нь хүн худалдах гэмт хэргийн хор, аюулын талаар сануулсан компьютерийн тоглоом, сорил бүхий CD-ROM бүтээж улсын дунд сургуулиудаар тараасан байна.⁵⁹

Бенин улсад анх удаа хүүхэд худалдах явдалд хамгийн их өртдөг тус улсын өмнөд хэсэгт Тосгоны Хороодын байгуулсан байна. Одоогоор 900 гаруй хороо байгуулагдаад байна. Эдгээр хороод нь бэлгийн болон бусад хэлбэрийн хүүхдийн мөлжлөг, доромжлол, тосгоноос үндэслэлгүйгээр явах болон хүн худалдах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй сэжигтэй тохиолдлуудыг мэдэгдэх замаар өөрийн тосгон дахь хүүхдүүдийн шилжилт, хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлдэг байна. Түүнчлэн, хүн худалдах явдалд өртсөн хүүхдүүдийг эргээд тосгондоо ирэхэд нь нийгэмшүүлэх ажиллагааг хянадаг байна. Тосгоноос хүүхэд явсан даруйд хороо нь алга болсон хүүхдийг хайж хамгийн ойр орших цэрэг-цагдаагийн хэсэгт буюу Хүүхэд Хамгаалах Хороонд мэдэгддэг байна. Энэхүү шуурхай ажиллагаа нь хүүхдүүдийг хөрш орнуудад хууль бусаар тээвэрлэх явдлыг олон удаа таслан зогсооход хүргэсэн байна. Тосгоны хороод нь тухайн газраа шуурхай хяналт хэрэгжүүлэх давуу талтай байдаг ба энэ нь орон нутгийн хүүхдүүдийн хянах, яаралтай шуурхай арга хэмжээ авах бололцоо, холбогдох бүх хүний ажил үүргийн тодорхой хуваарилалт зэргийг хэрэгжүүлэх боломжтой болгодог. Мөн хороод нь тухайн тосгоны бүх төрөлт, нас баралтын бүртгэлийг хөтөлдөг нь хүн амыг мэдээллээр хангах, улмаар хүүхдүүдийн өнөөгийн нөхцөл байдлын талаарх ойлголтыг

⁵⁹ АНУ-ын Төрийн Департамент, Trafficking in Persons Report буюу Хүн худалдах гэмт хэргийн мэдээлэл, 2004 оны 6 дугаар сар.

дээшлүүлж төрөлт, гэрлэлт, нас баралтын албан ёсны боловч учир дутагдалтай бүртгэлийг орлодог байна.⁶⁰

2004 онд Балба улс дахь НҮБ-ын Хүүхдийн Сан нь 203 хууль зүйн зөвөлгөө өгөх хороодод дэмжлэг туслалцаа үзүүлсэн ба үүнд дийлэнх нь эмэгтэйчүүд болох 3000 агруй гишүүд байдаг байна. Хороод байгуулагдсанаар хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдэгдэх болсон байна. Эдгээр хууль зүйн зөвөлгөө өгөх хороодод зориулагдсан сургалтын гарын авлагад хууль зүйн мэдлэг, зөвөлгөө өгөх, хэлэлцээр хийх ур чадвар болон “Эхний тохиолдлыг мэдээлэх анкет” болон “Төрсний бүртгэл”-ийг хэрхэн бөглөх зэрэг мэдээлэл тусгасан байна.⁶¹

Б. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг сургуулиудаар

Сургуулийн орчин нь хүүхдүүдэд хүн худалдах явдлын эрсдэл, аюулын талаар мэдээлж, ухуулахад нь ач холбогдолтой газар болно. Амьдрах ухаан, хүн худалдах гэмт хэргийн эсрэг мэдээллийг сургалтын хөтөлбөр оруулснаар хүүхдүүд мэдээлэл хүртэж өөрсдийгөө өөрийнхөө хэмжээнд хамгаалах боломжтой болох юм. Түүнчлэн сургууль нь хүүхдэд ашигтай хөдөлмөр эрхлэх боломж олгохуйц ач холбогдолтой ур чадвар суулгах замаар хүүхдийн хөдөлмөрөөс хамгаалах боломжтой юм. Багш нар нь хүүхдүүдэд сургуульд сурах, гадаадад ажиллахад тулгарах эрсдлийг тайлбарладаг байх ёстой. Хичээлийн дараах хөтөлбөрүүд нь хүүхэд хамгаалалд эерэг нөлөөтэй байж болох юм.

Иймээс хууль тогтоогчид нь боловсролын хүртээмжийг сайжруулах, нэмэгдүүлэхийн тулд дараахь арга хэмжээг авах нь зүйтэй.⁶²

- Боловсролыг дор хаяж хөдөлмөр эрхлэх доод нас хүртэл үнэгүй олгох.
- Хүүхдүүд, ялангуяа охидыг сургуулиасаа гарах, сургуульд хамрагдах явдлыг хянахад олон улсын засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах.
- Сургуульд суралцах нөхцлийг хүүхдэд бүрдүүлэх үүднээс шаардлагатай хэмжээгээр дүрэмт хувцас, хангамжид дэмжлэг туслалцаа үзүүлэх, үүнд хоол багадсанаас болж хүүхэд сургуулиас гарч байгаа бол сургуулийн хоолны хөтөлбөр ч хамаарч болно.
- Өвчтэй эцэг, эхээ асарч буй хүүхдүүдэд зориулж хичээлийн хуваарь, цагийг уян хатан байлгахыг дэмжих.

⁶⁰ НҮБ-ын Хүүхдийн Сангаас Innocenti судалгааны төвөөс хамтран эрхлэн гаргасан Child Trafficking in West Africa: Policy Responses 2002 буюу Өрнөд Африк дахь Хүүхэд худалдах явдал: Бодлогын арга хэмжээ 2002 хэмээн тайлангаас, 14 дугаар хуудас.

⁶¹ НҮБ-ын Хүүхдийн Сан, 2004 оны тайлан, НҮБ-ын Хүүхдийн сан, Нью Йорк хот.

⁶² Inter-Agency Standing Committee, Guidelines on HIV/AIDS interventions in emergency settings-ээс найруулан авав, 2003 он.

- Хичээлд хамрагдсан байдлаас хамаарах гэр бүлийн хүнсний хангамж, сургуулийн төлбөрийн зээл зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээг сургуультай холбох.
- Жендерт суурилсан хүчирхийлэл, хүн худалдах явдал зэрэг асуудлаар сурагч, багш нарын аль алинд нь мэдээлэл өгч, ухуулах, амьдралын ухаан зэргийг тусгасан үндэсний хичээлийн хөтөлбөр боловсруулах.
- Боловсролын байгууллагууд дахь бэлгийн мөлжлөг, доромжлолоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах механизмыг бий болгох, үүнд хүчирхийллийн дараахь зөвлөгөө, эмнэлгийн тусламж болон бусад арга хэмжээ хамаарна.
- Зэвсэглэсэн бүлгүүд болон бэлгийн хүчирхийллээс сургуулийг ангид, аюулгүй орчин байлгах.

Чехийн Бүгд Найрамдах улсын Хууль зүйн яамнаас гадаадад хөдөлмөр эрхлэхэд тулгарах эрсдэл болон хүн худалдагчид эмэгтэйчүүдийг хэрхэн олзолдог талаар Чехийн бага болон дунд сургуулиудад зааж сургаж буй төрийн бус байгууллагуудын хүчин чармайлтыг нь дэмжин хэсэгчлэн санхүүжүүлдэг байна.⁶³

Кени улсын Засгийн газар нь бага боловсролыг үнэгүй олгох хөтөлбөр боловсруулснаар сургууль завсардсан олон хүүхдийг сургуульд эргэн хамруулж чадсан байна. Энэ нь 2003 онд 1.5 сая хүүхдүүд сургуульдаа эргэн орж 2004 онд ч сургуулиасаа гаралгүй сурсан хэвээрээ байсан үр дүнд хүргэсэн юм.⁶⁴

Casa de la Esperanza нь Панам улсад гудамжны хүүхдүүдтэй ажилладаг төрийн бус байгууллага бөгөөд эцэг эх, хүүхдүүдэд зориулсан хөтөлбөр хэрэгжүүлдэг юм. Уг хөтөлбөр нь эцэг эхчүүд, өсвөр насныхны орлого олох чадавхийг нь дээшлүүлэх зорилгоор тэдэнд боловсол, техник сургалт явуулдаг байна.⁶⁵

Пакистан улсын нэгэн төслөөр нийгэмшүүлэн сэргээх үйлчилгээ болон ур чадварын сургалт явуулах замаар хүүхдүүдийг аюултай хүнд нөхцлийн хөдөлмөрөөс холдуулж чадсан байна. Мөн уг төслөөр багш нарыг сургах, оролцоог нь хангах болон бага сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсруулах замаар хүүхдийн хөдөлмөрөөс урьдчилан сэргийлсэн байна.⁶⁶

⁶³ АНУ-ын Төрийн Департамент, Trafficking in Persons Report буюу Хүн худалдах гэмт хэргийн мэдээлэл, 2004 оны 6 дугаар сар.

⁶⁴ НҮБ-ын Хүүхдийн Сан, 2004 оны тайлан, НҮБ-ын Хүүхдийн сан, Нью Йорк хот.

⁶⁵ Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага, Парламентын Холбоо, Eliminating the Worst forms of Child Labour: A practical guide to ILO Convention No.182 буюу Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах нь: Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын 182 дугаар Конвенцийн тухай, Женев хот, 2002 он, 147 дугаар хуудас.

⁶⁶ Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон улсын Хөтөлбөр. Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон улсын Хөтөлбөр хүүхдийн хөдөлмөрийн эсрэг 2002-2003: Ахиц дэвшил, ирээдүйн зорилтууд, Женев хот, 2003 оны 10 дугаар сар, 65 дугаар хуудас.

В. Хараа хяналтгүй хүүхдүүдэд дэмжлэг туслалцааг үзүүлэх чадавхийг нэмэгдүүлэх нь

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээ алдсан сая сая хүүхдүүдийн адил тэднийг асран хамгаалж буй гэр бүлүүд, институтууд ч мөн анхаарал, хамгаалал хэрэгтэй байдаг. Орлож буй байгууллага, механизмууд нь эдгээр хүүхдийг халамжлах чадвартай байх нь чухал юм.

Нэмэгдэж буй эдгээр эмзэг хүүхдүүдэд парламентчид дараахь байдлаар дэмжлэг туслалцаа үзүүлж болох юм.⁶⁷

- Эцэг эхээ алдсан хүүхдүүд нь гэр бүлийн орчинд халамжлуулах бололцоотой байх, байгууллагын хяналт халамжийг эцсийн арга хэмжээнд авч үзэх.
- Институтын халамжийг багасгаж, өөр бусад халамжийн арга барил боловсруулж нийгмийн халамжийн системийг өөрчлөх, хамт олон, нийгэмд үндэслэсэн урьдчилан сэргийлэх болон хамгаалалын үйлчилгээг бэхжүүлэх.
- Хууль тогтоомжийн цар хүрээг бэхжүүлэх, Хүүхдийн эрхийн Конвенцтэй нийцүүлж, шоронд хоригдож буй болон гэр бүлийн халамжгүй болсон хүүхдүүдийн эрхийг хангах.
- Хүүхэд, гэр бүлийн жендер, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа гарвал, ХДХВ-ын байдал зэрэг хүүхдийг нийгмийн халамжид хамрагдахад хүргэдэг ялгаварлалтай тэмцэх.
- Нийгмийн халамжийн стандарт тогтоож үр дүнтэй хяналтын журам боловсруулах.
- Урьдчилан сэргийлэх болон өөр бусад хэлбэрийн үйлчилгээг эн тэргүүнд тавих санхүүжилтыг бий болгох.

ХДХВ/ ДОХ-д өртсөн хүүхэд, гэр бүлүүдийн хувьд тусгай арга хэмжээ авч болох юм.⁶⁸

- Эдийн засаг, нийгэм-сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх замаар эцэг эхчүүдийн амьдралыг уртасгах.
- Эмзэг гэр бүлүүдэд хамт олонд үндэслэсэн богино болон урт хугацааны хариу арга хэмжээ авах, дэмжих.

⁶⁷ Стокгольмд 2003 оны 5 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд болсон Хүүхэд ба Хамгаалал сэдэвт олон улсын бага хурлаас гарсан Стокгольмын Тунхаглалаас найруулан авава.

⁶⁸ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал 2005 хэмээн тайлангаас найруулан авав, Нью Йорк хот.

- ХДХВ/ДОХ-д өртсөн бүх хүүхдүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх орчин бүрдүүлэх үүднээс бүх шатанд ухуулах, сурталчилгаа хийх.

Г. Төрөлтийн бүртгэл хөтөлж урьдчилан сэргийлэх

Бүх хүүхдийн төрмөгцөө бүртгүүлэх үндсэн эрхийг хангаснаар хүн худалдах явдлаас тэднийг хамгаалах боломжтой болдог.

Бүх нярай хүүхдийн төрөлтийн бүртгэлийг парламентчид дараахь байдлаар дэмжих боломжтой.⁶⁹

- Боллоцгоогүй байхад эцэг эхчүүдээс хүчинтэй баримт бичиг үзүүлэх, эсвэл бүртгэлийн баримт бичигт эцэг эх хоёулаа гарын үсэг зурах зэрэг хүүхдийн төрсний гэрчилгээ авахад тавьдаг хууль зүйн болон захиргааны шаардлагыг үгүй хийх, өөрчлөх.
- Төрсний гэрчилгээнд төлдөг бүх төлбөр, хураамжийг хүчингүй болгох.
- Хөдөө орон нутагт төрөлт бүртгэх явуулын баг, хэсэг ажиллуулах явдлыг дэмжих.
- Төрөхдөө бүртгүүлээгүй хүүхдүүдийг бүртгэх ажлыг дэмжих, зохион байгуулах.

Ангол улсын Засгийн газар нь төрөлтийн бүртгэлийг үнэ төлбөргүй болгосон бөгөөд бүртгэлийг төвлөрүүлэхээс зайлсхийж хялбаршуулсан хууль баталжээ. Засгийн газраас зарим сүмдэд хүүхдийг бүртгэх хууль зүйн эрх мэдэл олгосон ба зарим хэсэг нь нийгмийн оролцоо, ухуулга сурталчилгаа болон бүртгэл хийх явуулын байг бүрдүүлэх зэрэг ажилд оролцсон байна.⁷⁰

Өмнөд Африкт төрөлтийг интернетээр бүртгэх туршилтын төслийн үр дүнд сард 1000 төрөлтөөс дунджаар 650-ийг интернэтээр бүртгүүлсэн байна.⁷¹

Энэтхэгийн Ерөнхийлөгчийн санаачилсан Төрөлтийг бүртгэх кампанит ажлын дүнд 2004 онд ойролцоогоор 25 сая төрсний гэрчилгээ олгожээ. Энэхүү санаачилга нь өмнө нь бүртгэгдээгүй хоцорсон хүүхдүүдийг “гүйцээж бүртгэх” кампанит ажлын нэг хэсэг байсан юм.⁷²

Арван нэгдүгээр бүлэг

Хүүхдийн оролцоо

⁶⁹ Парламентын холбоо болон НҮБ-ын Хүүхдийн Сан, Child Protection: Handbook for Parliamentarians буюу Парламентчдад зориулсан Гарын авлага, Швецарь, 2004 он, 48 дугаар хуудас.

⁷⁰ Парламентын холбоо болон НҮБ-ын Хүүхдийн Сан, Child Protection: Handbook for Parliamentarians буюу Парламентчдад зориулсан Гарын авлага, Швецарь, 2004 он, 51 дүгээр хуудас.

⁷¹ НҮБ-ын Хүүхдийн Сан, 2004 оны тайлан, НҮБ-ын Хүүхдийн сан, Нью Йорк хот.

⁷² НҮБ-ын Хүүхдийн Сан, 2004 оны тайлан, НҮБ-ын Хүүхдийн сан, Нью Йорк хот.

Аливаа доромжлолоос ангид байх эрхтэйгээ, түүнчлэн хүн худалдах явдал зэргийн талаар хүүхдүүд мэдэхгүй байх нь тэднийг мөлжлөгөд амархан өртөх боломжтой болгодог. Хүүхдүүд өөрсдийгөө хамгаалахад шаардлагатай мэдлэг, мэдээллээр хангагдсан байх учиртай. Түүнчлэн тэд оролцооны болон өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх аюулгүй нөхцлөөр хангагдах шаардлагатай. Хүүхдийн оролцоог хангах боломж хомс байвал тэд илүү гэмт хэрэг болон бусад аюултай арга хэмжээнд оролцох хандлагатай байдаг.

Дэлхийн улс орнуудад хүүхдийн амьдралд нөлөөлөх асуудлаар бодлого боловсруулахад хүүхдүүдийн өөрсдийн нь оролцоо бараг байдаггүй. Европын Парламентын дарга асан Николь Фонтейны хэлснээр “Гол хууль тогтоомж, бодлого боловсруулалтад хүүхдүүдийн өөрсдийн нь онцлог туршлага, ойлголт байгаагүйгээс хүүхдийг ялгаварлан гадуурхдаг бодлого бий болоход хүргэж байна”.⁷³

Оролцоо гэдгийг “хүний амьдрал, амьдрах орчин, хамт олонд нөлөөлөх шийдвэрийг хамтран гаргах үйл явц”⁷⁴ хэмээн тодорхойлж болох юм. Хүүхэдтэй холбоотой асуудлаар бодлого боловсруулахдаа хүүхэд, залуучуудын мэдүүлсэн өөрсдийн нь туршлага, үзэл санаанд тулгуурлах шаардлагатай. Хүүхдүүдийн дуу хоолойг сонссоноор парламентчид хүн худалдах явдал, ямар бэрхшээл, эрсдэлд байдгийг ойлгох боломжтой болно.

“Хүүхдүүд аливаа зүйлд нөлөөлж чаддаггүй гэж бодож байвал та маш ташаа ойлголттой байна. Дэлхийн хамаг аюулыг хүүхдүүд дүрсэлж хэлэхгүй бол хэн хэлж чадах вэ? Хүүхдүүдийн дуу хоолойг сонсож, үзэл бодол, санааг нь ойлгох хэрэгтэй. Магадгүй тэгвэл дэлхийн удирдагчид өөрсдийнхөө үүсгэж буй бүх зовлонг эргэцүүлэн бодож дэлхийн хүүхдүүдэд тусламжийн гар сунгах ч юм бил үү.”

-2002 оны 3 дугаар сарын 24-ний өдөр, Словений улс, Хүүхэд залуучуудын дуу хоолой вэбсайтаас 16 настай охины үг.

Хүүхдийн санаа, бодлыг сонсоно гэдэг нь зөвхөн үзэл бодлыг нь дэмжинэ гэсэн үг биш юм. Сонсоно гэдэг нь хэлэлцүүлэгт оролцуулж, хүрээлэн буй ертөнцдөө нөлөөлөх бодитой арга зам олж мэдэх боломж олгохыг хэлнэ. Оролцоо явцад солилцдог мэдээлэл нь хүүхдийг идэвхитэй, тэвчээртэй, өсөн дэвших ардчилсан иргэд болж өсөхөд нь нөлөөлдөг.

Хүүхдүүд парламентын хороодын хуралдаанд оролцож, үг хэлж, өөрсдийн үзэл санаа, өөрсдөд нь ач холбогдолтой туршлагаа хуваалцах замаар хууль тогтоох үйл явцад идэвхитэй оролцох боломжтой юм. Хүүхдийн оролцоо нь насанд нь тохирсон, хүүхдийн эрхэмсэг оршихуйг хүндэтгэсэн байх шаардлагатай.

⁷³ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал 2003 хэмээн тайлангаас, 53 дугаар хуудас, Нью Йорк хот.

⁷⁴ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал 2005 хэмээн тайлангаас, 4 дүгээр хуудас, Нью Йорк хот.

Өмнөд Азид бэлгийн мөлжлөгийг зогсоохоор хүүхэд, залуучуудын нэгэн сүлжээ Бэлгийн мөлжлөгийн эсрэг Хүүхэд, Залуучуудын Зөвлөгөөнийг 2003 онд зохион байгуулжээ. Уг зөвлөгөөн нь бэлгийн мөлжлөгийг таслан зогсоох явдлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай алхмуудыг тодорхойлох, туршлагаа хуваалцах боломжийг олон хүүхэд, залуучуудад олгосон байна.⁷⁵

Хүүхдийн парламентууд олноор байгуулагдаж байна. Тухайлбал, Тайландад 2002 онд Үндэсний Залуучуудын Парламентыг байгуулахаар 76 мужийн бүх сургуулиудаас 200 гаруй хүүхэд залуучуудын төлөөлөгчид, үүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд ч мөн адил, хуран цуглажээ. 3 өдрийн туршид ардчилсан, оролцоог хангасан үйл явцаар хэд хэдэн асуудлыг тодорхойлж, хэлэлцсэн байна. Уг цуглааны тайлаг 1 дүгээр сарын 22-ны өдөр Засгийн газрын хуралдаанд танилцуулахад хүүхэд, залуучуудын оролцоог Засгийн газрын бодлого болгон баталсан байна.⁷⁶

Иорданы залуучуудын парламентчид өөрсдийн амьдралд нөлөөлөх асуудлаар захирагчийн түвшний 18 бага хуралд оролцсон байна. Эдгээр залуу парламентчдын 350 орчим нь хүүхдийн парламентын үйл ажиллагаан төлөвлөгөө боловсруулах үндэсний бага хуралд оролцохоор сонгогдсон байна.⁷⁷

Арван хоёрдугаар бүлэг

Хяналт хэрэгжүүлэх ба тайлагнах

Хүүхдэд аюулгүй орчин нь мөлжлөг, зөрчлүүдийн тохиолдлууд, тэдгээрийн шинж чанарыг бүртгэдэг, тэдгээр зөрчлүүдэд өгөх үндэслэлтэй хариу үйлдэл хийх боломж олгодог системтэй хяналтын тогтолцоотой байх шаардлагатай. Уг тогтолцоо нь оролцооны арга, хамт олны үйл ажиллагаанд үндэслэсэн үед үр дүнтэй байдаг. Төр засгууд хүүхдийн хүчирхийлэл, доромжлол, мөлжлөгийн талаар мэдэж байх шаардлагатай.

А. Мэдээлэл цуглуулах

Нас, хүйсийн ангиллаар хүн худалдах явдлын талаарх мэдээллийг тогтмол цуглуулахад зориулсан мэдээллийн бааз, хэрэглэхэд хялбар аргачлал боловсруулах нь хүүхэд худалдах явдлыг таслан зогсоох стратегийн нэг л хэсэг юм. Хоёрдугаар хэсэгт тайлбарласнаар хүүхэд худалдах явдлын талаар бодитой мэдээлэл цуглуулах нь хэдий хүндрэлтэй ч уг асуудлын хэмжээ хязгаарыг тодорхойлоход шаардлагатай зүйл юм.

⁷⁵ НҮБ-ын Хүүхдийн Сан, Хүүхэд, залуучуудын дуу хоолой. [www.unicef.org/voy/discussions/index.php, February 2005].

⁷⁶ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал 2003 хэмээн тайлангаас, 55 дугаар хуудас, Нью Йорк хот.

⁷⁷ НҮБ-ын Хүүхдийн Сангаас эрхлэн гаргасан State of the World's Children 2005 буюу Дэлхийн хүүхдүүдийн өнөөгийн байдал 2003 хэмээн тайлангаас, 56 дугаар хуудас, Нью Йорк хот.

Олон улсын Хөдөлмөрийн Байгууллага-Хүүхдийн Хөдөлмөрийн устгах олон улсын Хөтөлбөр, НҮБ-ын Хүүхдийн Сан хамтран хүүхдүүдээс өгсөн мэдүүлэг, бичиг судалгаанаас хүүхэд худалдах явдлыг тодорхойлдог “шуурхай үнэлгээ”-ний аргыг боловсруулсан байна. Эдгээр ярилцлагыг хийхэд ач холбогдолтой хүүхдэд ээлтэй арга хэмжээ, журмыг ашиглах нь чухал.

Б.Хянах, тайлагнах механизмууд

Тулгарч буй асуудал, гаргасан ахиц дэвшлийг мэдэж байх нь чухал юм. Нөхцөл байдлыг нарийн хянах нь бодит асуудал, хэрэгцээ шаардлагад зохих хариу арга хэмжээ авахуйц бодлого боловсруулахад ач холбогдолтой. Улс орнууд уг асуудалд ямар өөрчлөлт гарч байгааг хянах нь чухал юм. Парламентаас нөхцөл байдлыг үнэлэхийн тулд мөрдөн шалгах ажиллагаа хийж, нээлттэй хуралдаан хийж болох юм. Ингэхдээ, хүүхдийн оролцоог хангах нь чухал юм.

Өмнөд Африкийн Парламент нь хүүхэд хамгааллын асуудлаар нээлттэй хуралдаан хийжээ. Хүүхдүүд Парламентын өмнө хүүхдийн бэлгийн доромжлолын тухай мэдүүлэг өгсөн байна. Өмнөд Африкийн нэгэн парламентч болох Прегс Говендер нь хариулахдаа “Өмнөд Африк өөрчлөгдөх энэ үед амьдрал чинь ч мөн өөрчлөгдөнө хэмээн та нар итгэсэн хэвээр байна. Ирээдүйнхээ галыг та нар зүрхэндээ авч явж байна. Үнэн шударга ёсонд дандаа итгэж байгаарай. Нэг л өдөр та бүгд энэ Парламентад зогсож, нэг л өдөр Ерөнхийлөгч болно, нэг л өдөр та бүгд өөрсдийн мөрөөдлийн нийгэмдээ амьдарна. Өнөөдөр харин та бүгд бидэнд итгэл найдвар, дайчин чанар бэлэглэлээ”.⁷⁸

Олон улсын түвшинд бол Хүүхдийн эрхийн тухай Конвенцид нэгдэн орсон улс орнууд уг Конвенцийн хэрэгжилтийн талаар тайлагнах үүрэг хүлээсэн байдаг. Засгийн газрын үйл ажиллагааг хянадгийн хувьд Парламент нь тус улс Конвенцийн оролцогч улс болохын хувьд тайлагнах үүргийн биелэлтийн хангах чухал үүрэгтэй юм. Уг тайлан нь шаардлагатай бүхий л мэдээлэл агуулсан болоод цаг тухайд нь хүргэгдэж байх нь чухал.

Нэгэнт Конвенцийн Оролцогч улс болсон тохиолдолд, Парламент нь эхний болоод түүнээс хойшхи бүхий л тайлангууд нь Конвенцид заагдсан хугацаанд хүргэгдэж байгаа эсэхийг шалгах нь зүйтэй. Өөрийн холбогдох хороодоороо дамжуулж Парламент нь уг тайлан боловсруулалтад оролцож, мэдээллээр хангах буюу эсхүл агуулгыг нь мэдэж байх нь зохистой.

Түүнчлэн парламентчид тайлангийн болоод Хорооны санал, зөвлөмжийн хэрэгжилт хангагдаж байгааг болон Хорооноос гаргасан дүгнэлтийг Парламентад танилцуулж хэлэлцүүлүүлж байгаа эсэхийг хянах шаардлагатай. Ингэх нэг арга бол Конвенцийн бүрэн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай алхмуудын талаар

⁷⁸ 2002 оны 5-р сарын 30-ны өдөр Кейптаун хотонд Парламент дахь Эмэгтэйчүүдийн Амьдрал, Статусыг Сайжруулах Хамтарсан Хяналтын Хорооноос зохион байгуулсан Үдэлтийн арга хэмжээн дээр Өмнөд Африкийн Парламентч Говендер Прегсийн хэлсэн үг.

мэдээлэх, ухуулах үүднээс Хорооны дүгнэлтийн хэрэгжилийн талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж оролцох явдал юм.

Арван Гуравдугаар бүлэг

Эдгээх, нөхөн сэргээх үйлчилгээ

Хаягдсан, доромжлол, мөлжлөгт өртсөн хүүхдүүд халамж, нийгмийн суурь, цогц үйлчилгээг үл ялгаварлалгүйгээр хүртэх эрхтэй. Эрүүл мэнд, өөртөө итгэх итгэл, эрхэмсэг оршихуйг дээдэлдэг орчинд эдгээр үйлчилгээг хамгийн сайн үзүүлдэг.

Хүн худалдах явдлын хохирогчдод тусламж үзүүлэхийн ач холбогдлыг ойшоохгүй өнгөрөх нь олонтаа тохиолддог. Тиймээс парламентчид нь хохирогчдод тусламж үзүүлэх явдлын эн тэргүүний чиглэл болгох нь зүйтэй. Тодорхой үйлчилгээгээр хүүхдүүдийг бүрэн эдгээж, нөхөн сэргээж, цаашид дахин хүн худалдах гэмт хэрэгт өртөх эрсдлээс хамгаалж нийгэмших үйл явцыг нь дэмждэг байх шаардлагатай байна. Дараахь санал зөвлөмжүүд нь хүүхэд худалдах явдлын хохирогчдод тусламж үзүүлэхэд шаардлагатай арга хэмжээг тусгасан болно⁷⁹:

А. Хүн худалдах явдлын хохирогч хүүхдүүдэд тусламж үзүүлэх үйл явц

- Урьдчилж шуурхай тогтоох

Хүн худалдах гэмт хэрэгт өртсөн хүүхдүүдийг шуурхай тогтоох зохих журмуудыг боловсруулах хэрэгтэй байна. Үүнд хууль сахиулах байгууллага, хил шалганы албад, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа шаардлагатай бөгөөд эдгээр бүх байгууллагууд нь уг гэмт хэрэгт өртсөн хүүхдийг нэн даруй таньдаг байх шаардлагатай. Хүүхдүүд шаардлагатай тусламжаа нэн даруй авдаг байх нөхцлийг хангах үүднээс парламентчид шаардлагатай туслалцаа өгөх газарт нь мэдэгдэх, хүргэх зохих журмуудыг боловсруулахад түлхэц өгч болох юм.

Доромжлол, мөлжлөгт өртсөн хүүхдүүдийн холбогдож болох тусламжийн утас байх нь нэн хэрэгцээтэй байдаг. Тусгай визээр эцсийн улс оронд ирж буй бүх хүүхдэд утасны дугаарыг өгөх нь зүйтэй.

Энэтхэг улсад доромжлолд өртөж буй хүүхдүүдийн холбогдож болох Child Helplines буюу Хүүхдийн Тусламжийн Шугам 50 гаруй хотод ажилладаг байна. Энэ нь

⁷⁹ Хүн худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд авах арга хэмжээний дэлгэрэнгүй жагсаалтыг НҮБ-ын Хүүхдийн Сангийн Guidelines for Protection of the Rights of the Children Victims Trafficking in Southeastern Europe буюу Зүүн өмнөд Европ дахь хүн худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдүүдийн эрхийн хамгаалах нь хэмээх 2003 оны 5 дугаар сарын хэвлэлээс үзнэ үү. Энэ хэсгийг уг эх сурвалжаас найруулан авсан болно.

хэрэглэгчдэд үнэгүй үйчилдэг бөгөөд анх 1996 онд байгуулагдсанаасаа хойш 3 сая гаруй дуудлага хүлээн авсан байна.⁸⁰

- Нас тогтоох

Хүн худалдах гэмт хэргийн хохирогчид нь илрэх үедээ баримт бичиггүй буюу хуурамч баримт бичигтэй байдаг бөгөөд энэ байдал нь тэдний насыг тогтооход ихээхэн хүндрэл учруулдаг байна. Уг хохирогчийг насанд хүрээгүй хүүхэд гэж үзэх үндэслэл байх тохиолдолд насыг нь тогтоох боломжгүй ч хүүхэд гэж тооцох нь зүйтэй байдаг. Ийм тохиолдолд, хүн худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үзүүлэх тусгай хамгааллыг уг хохирогчид үзүүлэх хэрэгтэй.

- Аврах ажиллагаа

Биеэ үнэлэх газар зэрэг хүүхдийн мөлжлөг явагддаг газруудаас хүүхдийг “аврах” ажиллагаа үе үед явагддаг. Анх тэр газарт нь аваачсан нөхцөл байдлаас шалтгаалан аврагдсан хүүхдүүд өөр сонголтгүйгээсээ болоод сексийн үйлчилгээний салбарт эргэн ордог. Зарим хүүхдүүдийн хувьд биеэ үнэлэх газраас гадуур нийгмийн амьдралд дасан зохицоход нь тодорхой хэмжээний хугацаа, дэмжлэг хэрэгтэй болдог. Хүүхдийг аврах нь нэг талаас тухайн хүүхдийн бүрэн бүтэн байдлыг хангах арга барилтай байх ёстой боловч нөгөө талаар түүнийг гэр бүл, хамт олонд нь эргүүлэн нийгэмшүүлэх явдлыг хангах явдал байдаг. Түүнчлэн, аврах ажиллагаа нь хүүхдийн хэрэгцээнд мэдрэмжтэй хандах ёстой. Тухайлбал, зөвхөн эрэгтэй цагдаа нараас бүрдсэн баг охин хүүхдэд туслалцаа үзүүлэх, эсхүл биеэ үнэлэгч худалддаг этгээдийн өмнө хүүхдийг байцаах нь нэн хүндрэлтэй байдаг.

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох

Хохирогч хүүхдийг олж тогтоосон даруйд хүүхдэд хууль ёсны төлөөлөгч томилох нь зүйтэй. Хууль ёсны төлөөлөгч нь гэр орон, эрүүл мэнд, боловсрол, нийгэм-сэтгэл зүйн болон хэлний дэмжлэг зэрэг хүүхдийн халамжийн асуудлыг хариуцаж үйлчилгээ үзүүлэгч этгээдүүдтэй хүүхдийн нэрийн өмнөөс хамтран ажиллах нь зохистой. Хууль ёсны төлөөлөгч нь хүүхдийн эрх, хохирогч этгээдийн хэрэгцээ шаардлагын талаар болон хүүхэд худалдах гэмт хэргийн орчин тойрны хууль зүйн асуудлын талаар гүн гүнзгий ойлголттой байх ёстой.

Б. Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээ

- Нийтийн үйлчилгээ

Хүүхэд худалдах гэмт хэргийн хохирогчдод нийтийн үйлчилгээ үзүүлэх шаардлагатай. Хохирогч хүүхдүүдэд иустай, аюулгүй орчинд байрлуулах, эмнэлгийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэх сургалт, боловсрол, нийгэм-сэтгэл зүйн

⁸⁰ Парламентын холбоо болон НҮБ-ын Хүүхдийн Сан, Child Protection: Handbook for Parliamentarians буюу Парламентчдад зориулсан Гарын авлага, Швецарь, 2004 он, 48 дугаар хуудас. Энэ хэсгийг энэ эх сурвалжаас найруулан авсан болно:

нөхөн сэргээлт болон нийгэмшүүлэх туслалцаа зэрэг анхаарал халамж, хамгаалал шаардлагатай гэдгийг харгалзан эдгээр үйлчилгээ нь хүртээмжтэй байх явдлыг хууль тогтоогчид хангах нь зүйтэй юм.

Молдовт Шилжих хөдөлгөөний Олон улсын Байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн Сан нь хамтран Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдын Нөхөн Сэргээх Төвд хүүхдэд-ээлтэй тасаг нээсэн байна. Уг тасаг нь хохирогч хүүхдүүдэд эмнэлгийн, сэтгэл зүйн, нийгмийн болон хууль зүйн туслалцаа үзүүлдэг байна.⁸¹

2003 онд Гэмт хэргийн хохирогчдын АНУ дахь Алба нь хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод тусламж үзүүлэх тэтгэлэг өгсөн байна. Найман тэтгэлгийг тодорхой муж, бүс нутагт хохирогчдод бүх төрлийн үйлчилгээ үзүүлэхэд зориулан олгосон байна. Үүнээс гурав нь олон муж хамарсан бүс нутаг дахь хохирогчдод үзүүлэх нарийвчилсан үйлчилгээнд олгогдсон ба эдгээр үйлчилгээнд эмнэлгийн яаралтай тусламж, хоол хүнс, орон байр, мэргэжлийн болон англи хэлний сургалт, сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө болон хууль зүйн туслалцаа багтдаг байна.⁸²

- Тусгай хэрэгцээ, шаардлага

Хохирогч хүүхдэд зохих үйлчилгээг сонгохдоо хүүхдийн соёл, угсаа гарал, хүйс, нас, болон хөгжлийн бэрхшээл, нийгэм-сэтгэл зүйн хямрал, өвчин, жирэмслэлт зэрэг тусгай хэрэгцээг харгалзах нь маш чухал юм. Бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдүүдэд тусгай анхаарал, халамж шаардлагатай байдаг.

Кипр улсын 2000 онд баталсан Хүн худалдах гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн мөлжлөгтэй тэмцэх тухай хуулийн дагуу хүн худалдах гэмт хэргийн хохирогчид нь түр хугацааны орон байр, эмнэлгийн үйлчилгээ, сэтгэл зүйн туслалцаа хүлээн авах эрхтэй байна.⁸³

Итали улсын 1998 оны Цагаачлалын Хуулиар нь хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод мэргэжлийн сургалт, хэлний хичээл зэрэг нийгэмшүүлэх хөтөлбөрүүдийг бий болгосон байдаг.⁸⁴

Гаити улс даь Foyer Maurice Sixto төв нь тус арлын restaveks буюу хөдөө орон нутгаас хот суурин газар руу худалдагдсан гэрийн үйлчлэгч хүүхдүүдэд өдөрт 2 цагийн турш суурь боловсрол болон сэтгэл зүйн зөвлөгөө олгодог байна.⁸⁵

В. Нутаг руу нь буцаах буюу Нийгэмшүүлэх

⁸¹ Парламентын холбоо болон НҮБ-ын Хүүхдийн Сан, Child Protection: Handbook for Parliamentarians буюу Парламентчдад зориулсан Гарын авлага, Швецарь, 2004 он, 106 дугаар хуудас.

⁸² НҮБ-ын Хүүхдийн Сан, At A Glance: Republic of Moldova буюу Молдовын Бүгд Найрамдах Улс Товчоор [http://www.unicef.org/infobycountry/moldova_24121.html, February 2005].

⁸³ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

⁸⁴ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

⁸⁵ НҮБ-ын Хүүхдийн Сан, End Child Exploitation, Stop the traffic! буюу Мөлжлөгийг зогсоож, Хүн худалдахаа боль, НҮБ-ын Хүүхдийн Сан, 2003 он, 30 дүгээр хуудас.

- Хүүхдийн эрх ашгийг эн тэргүүнд тавих

Хүүхдийг нутаг буцаах уу эсвэл тухайн оронд нь үлдээх үү гэдэг асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн эрх ашгийг үндэслэн хэрэгтэй. Асуудлыг шийдэх хүртэл хугацаанд прокурор, нийгмийн халамж, үйлчилгээний болон төрийн бус байгууллагуудад хүүхдийн өмнөөс хүмүүнлэгийн виз хүсэх эрхийг олгох нь зүйтэй.

- Хохирогч хүүхдүүдэд зориулсан урт хугацааны шийдэл

Хүүхдийн сайн сайхан, эрх ашигт нийцэхээс бусад тохиолдолд өөрийнх нь нутаг руу буцаах хэрэггүй. Нутаг буцаахаас өмнө уг хүүхдийг асран халамжилж, хариуцахаа зөвшөөрсөн зохих этгээдийг олж тогтоох хэрэгтэй. Асран халамжлах хүн нь эцэг, эх, төрөл садны хүн, өөр насанд хүрсэн хүн, эсвэл өөрийнх нь нутгийн төрийн буюу хүүхэд халамжлах байгууллага байж болно.

Нутаг буцаах нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд хүүхдийн буцах аялалыг зохицуулах, баримт бичиг олгох шаардлагатай болох бөгөөд түүнийг хариуцах түр асран халамжлагч хэрэгтэй болно. Хохирогч хүүхдүүд нутаг буцсанаасаа хойш урт хугацааны халамж, хамгаалал хүртэхээ мэдэж байх нь зүйтэй. Үүнд аюулгүй байдал, хоол хүнс, хүүхдэд ээлтэй аюулгүй орчин дахь орон байр, эмнэлгийн үйлчилгээ, нийгэм-сэтгэл зүйн дэмжлэг туслалцаа, хууль зүйн туслалцаа, нийгмийн халамжийн үйлчилгээ болон нийгэмшүүлэхэд чиглэсэн боловсрол олгох явдал хамаарна.

Нийгмийн халамжийн байгууллагууд нь хүүхдийн ашиг сонирхолд нийцэж буй тохиолдолд холбогдох яамдтай шаардлагатай үед хамтран хүүхдийн гэр бүлийн гишүүдийг олж тогтоох, тэдгээртэй эргэж уулзуулах нь зүйтэй.

Зохих шүүхийн албад болон яамд нь хүүхдийг нутаг буцаах нь хүүхдэд аюулгүй, ээлтэй эсэхийг тогтоож, ингэхдээ аюултай, хүндэтгэлтэй байдлаар гүйцэтгэхийг хариуцах ёстой. Хүүхдийг доромжлохгүй, хорихгүй, шийтгэлийн арга хэмжээ авахгүй гэдэгт Парламентын гишүүд итгэлтэй байх ёстой.

Яамд болон бусад холбогдох төрийн байгууллагуудын боловсруулсан хамтран ажиллах гэрээ, хэлэлцээр, журамд хохирогч хүүхдийн хувийн болон гэр бүлийн байдлыг нарийн судлах зохицуулалт тусгасан байх шаардлагатай. Үүнээс хүүхдэд ашигтай алхмыг тодорхойлох боломжтой болно.

Эцсийн болон эх оронд нийгэмшүүлэх туслалцаа үзүүлдэг байгууллагуудыг Парламентын зүгээс дэмжих нь чухал юм. Үүний нэг жишээ бол “тусламжийн төвүүд” буюу хохирогч хүүхдүүдэд үзүүлэх туслалцааг зохион байгуулж, холбогдох байгууллагуудад ханддаг байгууллагууд юм.

Эцсийн болон үндсэн орнуудын Парламентын гишүүд хохирогч хүүхдийг нутаг буцаахад зориулж хөрөнгө, мөнгө төсөвлөж болох юм.

Хэрээ хүүхдийн эрх ашгийн үүднээс хүүхдийг нутаг буцаалгүй тухайн оронд үлдээх нь зүйтэй гэж үзвэл парламентчдын зүгээс хохирогч хүүхдүүд нь урт хугацааны халамж, хамгаалал, үүнд эмнэлгийн халамж, нийгэм-сэтгэл зүйн туслалцаа, нийгмийн халамж болон боловсрол зэргийг хүртэх баталгааг хангах боломжтой юм. Хүүхдийн гэр бүлийн орчин халамжлуулах урт хугацааны зохицуулалтыг хийх нь илүү ач холбогдолтой юм.

Энэтхэг дэх НҮБ-ын Хүүхдийн Сан нь алга болсон, олдсон хүүхдүүдийг жагсаалт гаргах вэбсайт бий болгохоор өөрийн түншүүдтэй хамтран ажиллаж байна. Уг вэбсайт нь олдсон хүүхдүүдийг нутаг буцаах хүртэл нь хянаж бүртгэдэг байна.⁸⁶

Нидерланд улсад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үндсэн дээр хүн худалдах гэмт хэргийн хохирогчид оршин суух зөвшөөрлийг олгож болдог байна. Уг зөвшөөрлийг олгохдоо тухайн хохирогч, түүний гэр бүлийн эсрэг гарч болох муу үр дагавар, биеэ үнэлэх явдалтай холбоотой зөрчлийг яллах, шийтгэх магадлал болон эх нутагтаа эргээд нийгэмших магадлал зэрэг хүмүүнлэгийн үндэслэлүүдийг харгалздаг байна.⁸⁷

Г. Хүн худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хамаарах хууль зүйн процедур

Хүн худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдэд иргэний болон эрүүгийн шүүх ажиллагаанд оролцох эрхийг баталгаажуулсан хууль тогтоомжийг парламентчид батлах хэрэгтэй байна. Мэдээж, хүүхдийн эрх ашгийг үндэслэн нь зүйтэй. Тиймээс Хүний эрхийн Дээд Комиссарын Албаны Хүний эрх, Хүн худалдах гэмт хэргийн удирдамж, санал зөвлөмжийн дагуу “туслалцаа үзүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх нь хохирогчид эрүүгийн шүүх ажиллагаанд мэдүүлэг өгөх эсэхээс хамаарахгүй” юм.⁸⁸ Хүүхдийн эрх ашигт нийцсэн гэж үзсэн үед аливаа эрүүгийн шүүх ажиллагаа нь гэр бүлийн гишүүдийг уулзуулах буюу хүүхдийг эх нутагт нь авчрахад саад учруулах, хойшлуулах арга хэмжээ авч болохгүй юм.

- Тусгай зохицуулалт

Хуулийн зохицуулалт нь хүүхдийн “нөхөн сэргэх хугацаа”, “эргэцүүлэн бодох хугацаа”-тай байх эрхийг харгалзан өөрийг нь худалдсан этгээдийг шүүлгэх эсэхээ шийдэх хүртэл оршин суух зөвшөөрөл олгодог байх ёстой. Энэ хугацаанд иргэний шүүх ажиллагаа хүсэх хохирогч хүүхдүүдийг тус оронд хууль ёсоор оршин суухаар зохион байгуулах ёстой.

Өөрөө нэхэмжлэл, шаардлага гаргах боломжгүй хүүхдүүдийн эрхийг хангах үүднээс гуравдагч этгээд иргэний журмаар нэхэмжлэх боломжтой байх ёстой.

⁸⁶ НҮБ-ын Хүүхдийн Сан, 2004 оны тайлан, НҮБ-ын Хүүхдийн сан, Нью Йорк хот.

⁸⁷ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

⁸⁸ Хүний эрхийн Дээд Комиссарын Албаны Хүний эрх, Хүн худалдах гэмт хэргийн удирдамж, санал зөвлөмж, Удирдамж 6.

Германд хүн худалддаг этгээдүүдийг шүүх ажиллагаанд хохирогч хүүхдүүд мэдүүлэг өгөх эсэхээ шийддэг “эргэцүүллийн” дөрвөн долоо хоногийн хугацаа олгодог ба ийм олон хамгааллын арга хэмжээг хүүхдүүдэд зориулж авдаг байна.⁸⁹

Австрийн Дотоод хэргийн яам болон Нийгмийн асуудлын яамтай хамтран хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод оршин суух зөвшөөрөл олгоход туслалцаа үзүүлэх тусламжийн төв байгуулсан байна.⁹⁰

- Эрүүгийн шүүх ажиллагаанд хүүхдийг хамгаалах нь

Хүн худалддаг этгээдүүдийн эсрэг эрүүгийн шүүх ажиллагаанд хүүхдүүд оролцож буй тохиолдолд тэднийг цаашдын эрдслээс хамгаалах арга хэмжээ авах шаардлагатай. Хохирогч хүүхдүүдийг хүндэтгэлтэйгээр, тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн байдлаар хандах баталгаа болох арга хэмжээ, журмыг парламентчид гаргах нь зүйтэй. Үүнд хүүхдэд зохих хууль зүйн төлөөллийг томилох, хүүхэд болон гэмт этгээд хоёрын хоорондоо харьцах боломжийг багасгах явдал хамаарна. Үүнийг хэрэгжүүлэх нэг арга бол шүүхэд мэдүүлэг өгөх өөр бусад боломжоор хангах, тухайлбал, тусгай аудио буюу видео бичлэгээр гэрчийн мэдүүлэг өгөх.

Тайландын Эрүүгийн Байцаан Шийтгэх Хуульд Нэмэлт Өөрчлөлт оруулах тухай 1999 оны хуулиар хүүхдийг цаашид бий болох эрсдэлээс хамгаалах үүднээс тусгай орчинд мэдүүлэг өгөх эрхтэй болгосон байна.⁹¹

Израильд бэлгийн мөлжлөгийн хохирогч хүүхэд нь шүүхээс гадуур залуучуудын тусгай мэргэжилтэнд мэдүүлэг өгөх эрхтэй байдаг байна.⁹²

Японы Яллах ажиллагааны тухай 2000 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар гэмт хэргийн хохирогч хүүхдүүдийг хамгаалах арга хэмжээ тусгажээ. Байцаалтын явцад хүүхэдтэй хамт насанд хүрсэн хүн байлцаж, яллагдагч болон бусад ажиглагчдаас хүүхдийг тусгаарлаж, видео холбоосоор холбогдож болдог байна.⁹³

- Иргэний хэргийн шүүх ажиллагаа

Парламентчид хүүхэд өөрийн бие сэтгэлийн гэм хороо нөхөн төлөхийг шаардах эрхтэй байхаар хууль тогтоомжийг батлах нь зүйтэй. Энэ нь хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан эсэх, хохирогчийн цагаачлалын статус зэргээс хамаарах ёсгүй. Цаашилбал, төрийн байгууллагын ажилтан ч бай хүнийг мөлжсөн хэн бүхний эсрэг иргэний нэхэмжлэл гаргах боломжийг хуулиар олгох ёстой.

⁸⁹ АНУ-ын Төрийн департамент, Trafficking in Persons Report /Хүн худалдах явдлын талаарх судалгааны тайлан/, 2004 оны 6 дугаар сар.

⁹⁰ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

⁹¹ [www.humantrafficking.org, February 2005.]

⁹² The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

⁹³ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

Учирсан гэм хорын схем нь шүүхэд хохирогчийн нөхцөл байдлыг харгалзан үзэхэд ач холбогдолтой бөгөөд ерөнхий, шийтгэлийн болон тусгай хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой болгоно (жишээ нь мөлжлөгөөс учирсан гэм хор, зардал, нутаг буцаах зардал г.м.)

- Олсон орлогыг хураах

Иргэний гэм хорыг нэхэмжлэх эрхээс гадна хууль тогтоогчдийн зүгээс хүн худалдах гэмт хэргээс олсон орлогыг төр хураах зохицуулалт бүхий хууль тогтоомж батлах нь зүйтэй. Хураасан орлогыг иргэний нэхэмжлэлийг хангахад болон хохирогчдод зориулсан нийгмийн халамжийн үйлчилгээнд зарцуулж болох юм. Хүүхэд худалдах гэмт хэргээс олсон орлогыг төрөөс тухайн хүүхдэд байгуулах хөрөнгө итгэмжлэх санд хадгалах бололцоотой юм.

Нигерийн Хүн худалдах, түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох тухай хуулиар хохирогчийн цагаачлалын статусаас үл хамааран эдийн засаг, бие махбодийн болон сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх эрхийг олгосон байна. Нэхэмжлэгчийг мөлжсөн, доромжилсон аливаа этгээд, төрийн байгууллагын ажилтны эсрэг уг эрхээ хэрэгжүүлж болох байна.⁹⁴

Филиппиний 2003 оны Хүн худалдах Гэмт хэргийн эсрэг хуулиар нь хураагдсан хөрөнгөөр хөрөнгө итгэмжлэлийн сан байгуулахаар заасан байна. Мөн хүн худалдах явдлын эсрэг Байгууллага-хоорондын зөвлөл байгуулахаар заажээ.⁹⁵

Киприйн Хүн худалдах гэмт хэрэг, Хүүхдийн Бэлгийн мөлжлөгтэй тэмцэх тухай 2000 оны хуулиар мөлжлөгт өртсөн хохирогчид нь гэмт этгээдүүдээс үндсэн болон нэмэгдэл хохирол нэхэмжлэх эрхтэй байна. Үндсэн хохирлыг шүүхээс тооцохдоо мөлжлөгийн хэр хэмжээ, түүнээс олсон ашиг, орлого, хохирогчийн хэтийн төлөв, түүнд мөлжлөг хэрхэн сөргөөр нөлөөлсөн зэргийг харгалзан үздэг байна. Түүнчлэн шийтгэлийн шинж чанартай гэм хорыг ч нөхөн төлүүлдэг байна. Үүнд мөлжлөгийн хэр хэмжээ, гэмт этгээд, хохирогчийн хоорондын холбоо зэрэг хүчин зүйлийг харгалзан үздэг байна.⁹⁶

- Гэрч, хохирогчийн аюулгүй байдал, хамгаалал

Эрүүгийн шүүх ажиллагаанд мэдүүлэг өгөх эсэхээ шийдэхээс өмнө хохирогч хүүхэд нь аюулгүй байдал, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны талаар бүрэн мэдээллээр хангуулах эрхтэй байна.

Эх орон, дамжин өнгөрөх болон эцсийн улс орнуудад хүүхдүүд, тэдгээрийн гэр бүлүүдийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээ авагдсан байх ёстой. Парламентчид нь Засгийн газартаа улсын хил дамнан мэдүүлэг өгөхөөр ирсэн

⁹⁴ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

⁹⁵ Филиппиний Бүгд Найрамдах Улс, Хүн худалдах гэмт хэргийн эсрэг 2003 оны хууль, 15 болон 20 дахь хэсгүүд, Бүгд найрамдах улсын 9208 дугаар хууль, Филиппиний Бүгд Найрамдах Улсын 12 дугаар Конгресс.

⁹⁶ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

гэрчүүдийг хамгаалах зохицуулалттай хоёр болон олон талт гэрээнд нэгдэн орохыг дэмжих хэрэгтэй байна. Хүүхэд худалдах гэмт хэргийн хохирогчид нь цагаачлалын статусаасаа үл хамааран өөрийг нь худалдсан этгээдүүдээс хамгаалуулах шийдвэр гаргуулах эрхтэй байх ёстой.

Түүнчлэн, хохирогч хүүхдүүдийг олон нийтээс хамгаалах нь зүйтэй. Иймээс эрүүгийн болон иргэний шүүх ажиллагааг хаалттай явуулах шаардлагатай бөгөөд шүүхээс гэрчийн нэрийг нууцлах арга хэмжээ авах ёстой.

Шведийн Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлгийн 10 дугаар хэсгийн дагуу гэрчийг хүчирхийлэх, хүчирхийлэхээр заналхийлэх явдлыг шүүн таслан ажиллагааны эсрэг гэмт хэрэг хэмээн үзэх бөгөөд торгох буюу 2 жил хүртэлх хугацаагаар хорих ялгаар шийтгэхээр байна.⁹⁷

Эстони, Латви, Литви зэрэг орнууд нь 2000 оны 5-р сард эрүүгийн гэмт хэргийн хохирогчдын аюулгүй байдлыг хангах үүднээс өөр орон руу шилжүүлэх хууль зүйн үндэслэлийн бий болгосон гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.⁹⁸

Гуравдугаар Хэсэг

Үндсэн зөвлөмжүүд болон шаардлагатай зохицуулалтын загвар

Арван дөрөвдүгээр бүлэг

Үндсэн зөвлөмжүүд

Дараахь нь гарын авлага дахь гол санал, зөвлөмжүүд юм. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг гарын авлагын холбогдох хэсгүүдээс үзнэ үү.

Парламентчдыг дараахь арга хэмжээ авахыг уриалж байна:

Аливаа хязгаарлалгүйгээр хүүхэд худалдах явдлыг хориглосон бүхий л олон улсын гэрээ, конвенциудад гарын үсэг зурж, батлах. Холбогдох хамгийн чухал олон улсын гэрээ, конвенцид дараахь хамаарна:

- Хүүхдийн эрхийн тухай Конвенци
- Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн Хүүхэд худалдах, биеийг нь үнэлүүлэх болон садар самуунд оролцох талаархи Нэмэлт Протокол
- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх НҮБ-ын Конвенцийн нэмэлт Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай Протокол (Палермогийн Протокол) болон Цагаачдыг газар, ус, агаараар хууль бусаар тээвэрлэх тухай Протокол

⁹⁷ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

⁹⁸ The Protection Project –ийн Улс орны тайлан [www.protectionproject.org, February 2005].

- Хүүхдийн хөдөлмөрийн хүнд хэлбэрийг хориглох, арга хэмжээ авах тухай Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын Конвенци 182
- Улс хоорондын Үрчлэлттэй холбоотой хүүхэд хамгаалал, хамтран ажиллах тухай Гаагийн Конвенци

Хүүхдийн эрхийн тухай Конвенциэр хүлээсэн олон улсад тайлагнах үүргээ дараахь байдлаар гүйцэтгэх:

- Анхны болоод тогтмол хүргэх тайланг Конвенцийн дагуу хүргүүлэх
- Тайланг боловсруулахад парламентаас мэдээллээр хангах буюу агуулгатай танилцаж оролцох
- Парламентын үйл ажиллагааг тайланд тусгасан эсэхийг хянах
- Хороодоос гаргасан дүгнэлтийг парламентад танилцуулж, хэлэлцүүлэх.

Хамгаалуулах эрхийг хангах хүчин чармайлт дараахь байдлаар гаргах:

- Ядуурлыг бууруулах явдлыг эн тэргүүнд тавьж ядууралтай тэмцэх явдлыг хүүхдийн өнцгөөс авч үзэх
- Бүх нийтэд боловсролыг хүртээмжтэй болгох, нэн ялангуяа охидод
- Хүүхэд худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон хохирогчдыг хамгаалах талаар, Харилцан ойлголцлын санамж бичиг, бүс нутгийн хэмжээний гэрээ, хэлэлцээр байгуулж үйлдэж, улс орон хоорондын хамтын ажиллагаа бий болгох
- Хүүхэд худалдах гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн үндэсний алба, парламентын хороо байгуулж үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж, эдгээр төлөвлөгөөт ажлуудын явцыг хянах
- Хүн худалдах явдалтай тэмцэх хөтөлбөрүүдэд хангалттай хөрөнгө, мөнгө төсөвлөх, хүүхдийн эрсдлийг бууруулах нийгмийн хөтөлбөрт хөрөнгө оруулах.

Олон улсын хууль зүйн хэм хэмжээний дагуу хүүхэд худалдах явдлыг зогсооход чиглэгдсэн үндэсний хууль тогтоомж, түүний хэрэгжилтийг сайжруулах:

- Уг гэмт хэрэг болон хүн худалдах явдалтай холбоотой бүх оролцогчдод ногдуулах ял шийтгэлийг тодорхойлох, хуулийг чанд хэрэгжүүлэх
- Хуулийн үйлчлэлийг нутаг дэвсгэрээс гадуурх тохиолдолд ч хамаарахаар өөрчлөх

- Цагаалчлал, хөдөлмөр, үрчлэлт зэрэг бүх холбогдох хууль, бодлогыг хүүхэд худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг баримжаагаар бэхжүүлэх
- Хохирогчид эрүүгийн санкци буюу хариуцлага хүлээлгэхгүй байх

Хүүхэд хамгааллын асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг бий болгох:

- Аялал жуулчлал дахь бэлгийн мөлжлөгөөс хүүхдийг хамгаалах ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрөх явдлыг дэмжих зэргээр хувийн салбарын байгууллагууд, ялангуяа аялал жуулчлалын салбарт ухуулга, сурталчилгаа хийх.
- Бусад парламентын гишүүдэд хүүхэд худалдах явдлын талаар мэдээлэл өгөх үүднээс тусгай чуулган, хуралдаан зохион байгуулах, үг хэлэх ба уг асуудлаар парламент тогтмол хэлэлцдэг байх
- Хүүхэд худалдах гэмт хэргийн талаар мэдээллийг түгээх талаар хэвлэл мэдээллийнхэнтэй хамтран ажиллах

Уг асуудлаас урьдчилан сэргийлэх, үр дүнтэй шийдвэрлэх үүднээс орон нутгийн хамт олны чадавхийг дээшлүүлэх:

- Хүүхэд худалдах явдалтай тэмцдэг байгууллага, бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжих
- Эрсдлийг бууруулах үүднээс хараа хяналтгүй хүүхдүүдэд тусламж үзүүлэх
- Бүх хүүхэд төрмөгцөө бүртгүүлэх баталгааг хангах

Амьдралд нь нөлөөлөх бодлого, шийдвэр гаргахад хүүхдүүдийн оролцоог хангах:

- Залуучуудын парламентыг дэмжиж тэдгээрийн санал зөвлөмжийг харгалзах
- Амьдралд нь нөлөөлөх бодлого, шийдвэр гаргахад хүүхдүүдийг оролцуулах

Хүүхэд худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд тусламж үзүүлэх бодлого хэрэгжүүлэх:

- Хохирогч хүүхдэд түр асран хамгаалагч, харгалзан дэмжигч шуурхай томилох механизм бүрдүүлэх
- Эмнэлгийн тусламж, зөвлөгөө, аюулгүй орон байр болон шаардлагатай хууль зүйн туслалцаа зэрэг нийгмийн үйлчилгээг хохирогч хүүхдүүд хүртэх баталгаагаар хангах
- Урт хугацааны шийдэл олох хүртэлх хугацаанд хохирогч хүүхдүүдэд хүмүүнлэгийн түр виз олгох

- Хүүхдэд-ээлтэй шүүх ажиллагаанд оролцох эрхтэй болгох
- Шүүх ажиллагааны бүхий л үед хүүхдийн аюулгүй байдлыг хангах.

Арван тавдугаар бүлэг

Шаардлагатай зохицуулалтын загвар

А. Хүмүүнлэгийн визийн тухай хуулийн зохицуулалт

Италийн 1998 оны Цагаачлах ба Гадаадын иргэдийн тухай 286/98 хууль зүйн актын Түр оршин суух зөвшөөрөл олгох талаарх 18 дугаар зүйлд үндэслэв

Нэгдүгээр зүйл. Цагдаагийн үйл ажиллагаа, мөрдөн байцаалт, шүүх ажиллагаанаас гадаадын иргэнийг доромжилсон, ноцтой мөлжсөн нь илэрсэн, түүнчлэн гэмт бүлэглэлийн тавьсан шаардлагаас зугтаах оролдлогоос болж уг гадаадын иргэний аюулгүй байдалд алдагдсан тохиолдолд цагдаагийн дарга гэмт бүлэглэлийн үйлдсэн доромжлол, мөлжлөг, нөхцөл байдлаас зугтаах боломж олгож тухайн гадаадын иргэнд оршин суух тусгай зөвшөөрөл олгож нийгмийн халамж, нийгэмшүүлэх хөтөлбөрт хамрагдах бололцоог олгоно.

Хоёрдугаар зүйл. Энэхүү зүйлийн дагуу олгогдсон оршин суух зөвшөөрөл нь 6 сарын хугацаатай байх ба шүүх ажиллагааны зорилгоор 1 буюу түүнээс дээш хугацаагаар сунгаж болно.

Гуравдугаар зүйл. Энэхүү зүйлд заасан оршин суух зөвшөөрлөөр нь хамгийн доод түвшний шаардлагыг хангасан тохиолдолд нийгмийн халамж үйлчилгээ болон боловсролын байгууллага, хөдөлмөрийн биржид хандах, хөдөлмөр эрхлэх зэргийг зөвшөөрнө. Оршин суух зөвшөөрөл эзэмшигч нь зөвшөөрлийн хугацаа дуусах огноонд ажилд орвол уг зөвшөөрлийг хөдөлмөрийн гэрээний хугацаагаар сунгана. Хугацаагүй хөдөлмөрийн гэрээ байх тохиолдолд уг нөхцөлд оршин суух зөвшөөрөл олгох журам үйлчилнэ. Зөвшөөрөл эзэмшигч нь албан ёсны боловсролын институтэд элссэн тохиолдолд уг зөвшөөрлийг боловсрол эзэмших зорилгоор оршин суух зөвшөөрөл болгон өөрчилж болно.

Б. Хохирогчдыг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Өрнө болон Төв Африкийн Бүсийн 2004 онд боловсруулсан Хил дамнасан хүн худалдах гэмт хэргээс Хүүхдүүдийг хамгаалах талаар хамтран ажиллах, харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх хоёр талт Гэрээний загварт үндэслэв.

Нэгдүгээр зүйл. Хүн худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдүүд бие махбодийн, нийгэм-сэтгэл зүйн болон нийгмийн нөхөн сэргээлтийг хангах арга хэмжээг талууд авах ба үүнд шаардлагатай тохиолдолд төрийн бус байгууллагууд болон бусад шаардлагатай байгууллагууд, иргэний нийгмийн оролцогчидтой дараахийг хангахад хамтран ажиллана:

А) Зохих орон байр, хоол хүнс

Б) Зөвөлгөө, мэдээллээр хангах, ялангуяа тухайн хохирогч хүүхдийн ойлгох хэлээр хууль ёсны эрхийн талаар

В) Эмнэлгийн, сэтгэл зүйн болон материаллаг туслалцаа болон

Г) Хөдөлмөр, боловсрол болон сургалтын боломжууд.

Хоёрдугаар зүйл. Талууд хохирогч хүүхдүүдийг нас, хүйс, тусгай хэрэгцээ, шаардлагыг нь харгалзан нийгэмшүүлэх, орон байр, хоол хүнс, боловсрол, халамжаар хангах үүрэг хүлээнэ.

Гуравдугаар зүйл. Оролцогч улс бүр хохирогч хүүхдийг өөрийн нутаг дэвсгэр дээр байх үед бие махбодийн хувьд аюулгүй байлгах баталгаа гаргана.

Дөрөвдүгээр зүйл. Хүүхдийг түүний нийгэм-сэтгэл зүйн болон бие махбодийн нөхөн сэргээлтэд тохирсон орчинд байруулсны дараа, талууд нь уг орчин нь тухайн хүүхдийн эрх ашигт нийцсэн болохыг баталгаажуулах үүднээс тогтмол шалгалт хийнэ.

В. Гэр бүлийн гишүүдийг уулзуулах, хохирогчдыг нутаг руу нь буцаах

НҮБ-ын Хүүхдийн Сангийн Өрнө болон Төв Африкийн Бүсийн 2004 онд боловсруулсан Хил дамнансан хүн худалдах гэмт хэргээс Хүүхдүүдийг хамгаалах талаар хамтран ажиллах, харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх хоёр талт Гэрээний загварт үндэслэв.

Арван нэгдүгээр зүйл-Гэр бүлийн гишүүдийг уулзуулах

Нэг. Талууд нь уг төрөл, садангийн хүн нь хүлээн авагч улс, эх нутаг буюу гуравдагч оронд байгаа эсэхээс үл хамаарч хохирогч хүүхдэд өөрийн гэр бүлийнхэн, асрамжлагчидтайгаа эргэн уулзуулах бүхий л арга хэмжээг авна.

Хоёр. Гэр бүлтэй уулзуулах буюу эх нутаг руу буцаах болон хүүхдэд ашигтай шийдвэр гаргах тохиолдолд хүүхдийн өөрийнх нь үзэл бодлыг харгалзан үзнэ.

Гурав. Хохирогч хүүхдийг гэр бүлтэй нь уулзуулах боломжгүй байгаа тохиолдолд тухайн хүүхдийн гэр бүл, өмнөх халамжлагчдыг тогтоож хүүхэдтэй холбоо барих стратеги боловсруулна. Төрөл, садангийн хүн, өмнөх халамжлагчид болон хүүхдийн хооронд шууд холбоо тогтоох боломжгүй тохиолдолд эргэн уулзаж нийлэх хүртэлх хугацаанд хүүхдийн байдлын талаар тогтмол гэр бүлд нь мэдээлнэ.

Арван хоёрдугаар зүйл-Хохирогчдыг нутаг буцаах

Нэг. Хүн худалдах гэмт хэргийн хохирогч хүүхдийг нутаг руу буцаах нь тухайн хүүхдийн эрх ашигт бүрнээ нийцэнэ гэдгийг бэлтгэгдсэн мэргэжилтнүүд тогтоосон

тохиолдолд эх нутаг нь хүүхдийн аюулгүй байдлыг ханган, шаардлагагүй саадгүйгээр хүүхдийг хүлээн авна.

Хоёр. Хүлээн авагч орны хүсэлтээр хүсэлт хүлээн авсан улс нь шаардлагагүй саадгүйгээр тухайн хохирогчийн эх нутаг мөн эсэхийг шалгана.

Гурав. Зохих баримт бичиггүй хохирогч хүүхдийг нутаг руу нь буцаахын тулд хүүхдийн эх нутаг болох орон нь хүлээн авагч улсын хүсэлтээр тухайн хүүхдийг эх нутаг руугаа зорчиж, нэвтрэх боломж олгох баримт бичгийг олгоно.

Дөрөв. Хүүхдийг нутаг руу нь буцаамагц эх нутаг нь хүүхдэд бие махбодийн болон сэтгэл зүйн нөхөн сэргээлт явуулах ба нийгэмшүүлэх, боловсролын болон дахин өртөх эрсдлээс хамгаалах арга хэмжээ авна.

Тав. Энэ зүйл нь хүлээн авагч улсын дотоодын хууль тогтоомжоор хохирогч хүүхдэд олгосон аливаа эрхэд нөлөөлөхгүй.

Г. Секст суурилсан аялал жуулчлалын хориглох зохицуулалт

Гамби улсын 2003 онд баталсан Секст суурилсан аялал жуулчлалын тухай хуулиас найруулан авав.

Нэгдүгээр зүйл. Дараахь зорилго, үйлдлээр хүүхэд авсан жуулчин буюу аливаа этгээд нь 10 жил хүртэлх хугацаагаар хорих ял эдэлнэ:

а/ ямар ч хүнтэй бэлгийн харьцаанд оруулахаар

б/ хүүхэд өмнө нь биеэ үнэлж байсан эсэхээс үл хамаарч биеийг нь үнэлүүлэхээр

в/ биеэ үнэлэх газрын гишүүн байсан эсэхээс үл хамааран биеэ үнэлэх газрын гишүүн болгохоор.

Хоёрдугаар зүйл. Жуулчин буюу хүүхдийн илтгэлийг олсон, хүүхдийг тэтгэдэг этгээд бэлгийн зорилгоор дараахь үйлдлийг хийсэн бол 5 жилээс доошгүй хугацаагаар хорих ял эдэлнэ.

а/ хүүхдийн биеийн аль нэг хэсэгт аливаа зүйлээр буюу шууд болон шууд бусаар хүрсэн, эсхүл

б/ өөрийн болон ямар ч хүний биеийн аль нэг хэсгийг, аливаа зүйлээр буюу шууд болон шууд бусаар хүрэхийг зөвлөх, санал болгосон

Гавай муж улсын Бие үнэлэх явдлын тухай 2004 оны хуулиас найруулан авав

Нэгдүгээр зүйл. ямар ч аялал жуулчлалын зуучлал, аялал зохион байгуулагч компани Дараахь зорилготой аялалын худалдаа, сурталчилгаанд оролцохгүй, оролцох, зохион байгуулахаар санал болгохгүй:

а/ бэлгийн харьцаанд орох аялал

б/ жуулчдыг татах үүднээс сексийн үйлчилгээ, сексийн үйлчилгээ бүхий багц үйлчилгээ бүхий аялал

в/ сексийн үйлчлэгч, үйлчилгээгээр хангах буюу зохион байгуулдаг аялал

Австралийн /Хүүхдийн секст суурилсан аялал жуулчлал/ Эрүүгийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн тухай 1994 оны хуулийн 2 дугаар хэсгийн №105-т заасан Гадаад хүүхдүүдийн бэлгийн зөрчлийн тухай хэсгээс

Нэгдүгээр зүйл. Австралиас өөр улсад байгаа 16 нас хүрээгүй хүнийг гуравдагч этгээдтэй бэлгийн харьцаанд оруулахаар тулган шаардаж болохгүй. Энэ улсын иргэн нь Австралиас өөр улсад байхдаа 16-аас доош насны хүнтэй бэлгийн харьцаанд орохыг хориглоно. Энэхүү гэмт хэргийг үйлдсэн, үйлдэхэд оролцсон иргэд, оршин суугчид, компани, корпорациудад 17 жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулан шийтгэнэ.

Хавсралт

Хавсралт А

Хоёр талт гэрээний загвар

Малийн Бүгд Найрамдах Улс, Зааны ясан эргийн Бүгд Найрамдах улсуудын хооронд байгуулсан Хил дамнасан хүүхэд худалдах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хамтын ажиллагааны гэрээ /2001 он/

Хэсэглчэн авав /франц хэлнээс/

2 дугаар хэсэг: Талуудын хүлээх үүрэг

Нэгдүгээр бүлэг: Хамтран хүлээх үүрэг

Дөрөвдүгээр зүйл: Талууд тус тусын орондоо дараахь арга хэмжээг авахаар ажиллана

- Хүүхэд худалдах гэмт явдлын тухай орон нутаг, хамт олны удирдагч, сургалтын байгууллагуудад чиглэсэн мэдээлэл, ухуулгын кампанит ажил явуулах.
- Тус тус улс орнуудаас гадуурх хүүхдүүдийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой журам боловсруулж батлах.
- Хүн худалдах гэмт хэргийн хохирогчдод тавих анхаарал, халамжийг сайжруулах.
- Тавих хяналт, авах хариу арга хэмжээ, хүлээн авагч байгууллагууд болон хамт олонд суурилсан хяналтын хороодыг байгуулах, тэдгээрийн хүний нөөц болон материаллаг нөөц бололцоог нэмэгдүүлэх.

- Хүүхэд худалдах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хөтөлбөр боловсруулах.
- Хил дамнасан хүүхэд худалдах гэмт хэргийн хохирогчдыг нутаг буцаах зохистой арга хэмжээ авах.
- Төрийн бус болон олон улсын байгууллагуудын оролцоог дэмжих буюу зохион байгуулах.
- Хил дамнасан хүүхэд худалдах гэмт хэргийг хориглосон тусгай хууль тогтоомж батлах.
- Хүүхэд худалдах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх шаардлагатай арга хэмжээг авах.

Тавдугаар зүйл: Талууд дараахийг харилцан тохиролцов:

- Энэхүү гэрээний үр дүнд хянах байнгын Комисс байгуулах.
- Нутаг буцаах ажиллагааны санхүүжилтын талаар түншшдтэйгээ хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр хийх.
- Хохирогч хүүхдүүд, гэмт этгээдүүд, тэдгээрийн байршил болон нутаг буцаах ажиллагаан үйл явц талаарх мэдээллийг хуваалцах.

Хоёрдугаар бүлэг: Тусгай үүрэг

Зургаадугаар зүйл: Эх нутаг болох улс орон нутаг нь дараахь үүргийг хүлээхээр зөвшөөрөв:

- Эх үүсвэр болсон бүс нутаг, сүлжээ болон мэргэжлийн буюу тогтмол хүүхэд худалдах наймаа эрхлэгчдийг тогтоох.
- Хүүхдийг өөрийн гэр бүл, бүс нутагт нь буцаах, нийгэмшүүлэх үйл явцыг хянах механизм байгуулах.
- Хохирогч хүүхдийг нутаг буцаахад шаардагдах зардалд хувь нэмэр оруулах.
- Хүүхдийг эх нутаг, гэр бүлд нь буцаах, нийгэмшүүлэх зардлыг хүлээх.
- Хүүхэд худалдах гэмт хэргийн эх үүсвэр болох бүс нутгуудад авах урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх.

Долоодугаар зүйл: Хүлээн авагч улс нь дараахь үүргийг хүлээхээр зөвшөөрөв:

- Хүн худалдах гэмт хэргийн сүлжээ, маршрут, байршуулдаг бүсүүдийг тогтоох.
- Өөрийн нутаг дэвсгэр дээрх хохирогч хүүхдүүдийг эх нутаг руу буцаах үйл ажиллагааг уг үйл явцад холбогдох түншүүдтэйгээ хамтран зохион байгуулах.

- Хүлээн авагч оронд болон мөлжлөгийн газар олдсон хүүхдүүдэд тусламж үзүүлэх.
- Хохирогч хүүхдүүдэд сэтгэл зүй, эмнэлгийн тусламж үзүүлж, хоол хүнс, орон байраар хангах.
- Хүчин төгөлдөр үйлчилж буй хуультай нийцүүлэн хүүхэдтэй холбоотой эд хөрөнгө, цалин болон нөхөн олговор буюу бусад бүх нөхөн төлөлт олгох үйл явцыг зохион байгуулж эрчимжүүлэх.

Гуравдугаар хэсэг: Эцсийн заалтууд

Наймдугаар зүйл: Тавдугаар зүйлд заасан Хяналтын байнгын комисс нь аль нэг оронд сар бүр хуралдах ба Талуудад санал зөвлөмж, зөвлөгөө өгөх үүрэг хүлээнэ.

- Комисс нь 16 гишүүнээс бүрдэх бөгөөд Талуудаас тэнцүү тоогоор томилогдоно.

Есдүгээр зүйл: Энэхүү гэрээ нь 3 жилийн хугацаатай ба аль нэг Тал нөгөөдөө бичгээр цуцлахаас 3 сарын өмнө уг хүсэл зоригоо илэрхийлээгүй бол автоматаар сунгагдана.

Аравдугаар зүйл: Гэрээлэгч Талууд нь энэхүү Гэрээнд зааснаас илүү чанга арга хэмжээ авах эрхтэй.

- Хүүхэд худалдах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа явуулах хувийн салбар дахь мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагууд, сан, судалгааны инстит байгуулах явдлыг дэмжинэ.

Хавсралт Б

Харилцан ойлголцлын Санамж бичгийн загвар

Их Меконг бичиг дүүрэг дэх Хүн худалдах явдлын эсрэг Харилцан ойлголцлын Санамж бичиг

2004 оны 10 дугаар сарын 29-ны өдөр

/Эх текстээс нь найруулан авав/

Камбоджийн Вант улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Лоасын Ардчилсан Бүгд Найрамдах Улс, Мянмарын Холбоо, Тайландын Вант улс болон Социалист Бүгд Найрамдах Вьетнам улсуудын Засгийн газруудын төлөөлөгчид бид:

Дараахь арга хэмжээнд бүхий л хүчин чадлаа дайчилна:

- I. Бодлого болон Хамтын Ажиллагааны салбарт /үндэсний болон олон улсын түвшинд/

1. Protocol to Prevent, Suppress and Punish Trafficking in persons, Especially Women and Children supplementing the United Nations Convention on Transnational Organised Crime Протоколд заасан хүн худалдах гэмт хэргийн тодорхойлолтын хэрэглээг дэмжих.
 2. Хүн худалдах гэмт хэргийн бүхий л хэлбэртэй тэмцэх үндэсний үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах.
 3. Үндэсний Үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад тэмцлийн арга хэрэгслийн хэрэгжилтийг зохицуулах эрх бүхий, олон салбараас бүрдсэн, хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний хороог байгуулах, бэхжүүлэх талаар арга хэмжээ авах.
 4. Бүс нутгийн хэмжээний хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог бэхжүүлэх механизм бий болгож, хүн худалдах явдалтай тэмцэх үндэсний төвлөрсөн цэг байгуулах.
 5. Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулах, ялангуяа хоёр талт болон олон талт гэрээ байгуулах замаар.
 6. Хүн худалдах гэмт хэрэгтэй хийх тэмцэлд Засгийн газар, олон улсын байгууллагууд болон төрийн бус байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.
- II. Хууль зүйн орчин, хууль сахиулах болон шударга ёсны хүрээнд:
7. Хүн худалдах гэмт хэргийн эсрэг зохих хууль тогтоомжийг аль болох богино хугацаанд хэрэгжүүлэх.
 8. Хүн худалдах гэмт хэрэгт өртсөн этгээдүүдийг шуурхай тогтоох, мөрдөн байцаалт, яллах болох шүүхийн шатны үйл явцыг сайжруулах боломж олгохуйц зохих журмыг баталж, холбогдох албан тушаалтнуудыг сургах.
 9. Хүн худалдах гэмт хэрэг үйлдэгдсдийг үндэсний хууль тогтоомжийн дагуу мөрдөн байцаах, баривчлах, яллан шийтгэх.
 10. Хохирогчдод хууль зүйн туслалцаа болон мэдээллийг ойлгох хэлээр нь үзүүлэх.
 11. Гэмт этгээдүүдийг шийтгэдэггүй явдлыг арилгаж хохирогчдын шударга эрхийг хамгаалах үүднээс эрүүгийн эрх зүйн тогтолцоонд бодитой, үр дүнтэй хамтын ажиллагааг бий болгох.
 12. Уг зургаан улс хоорондын хил дамнасан хууль сахиулах хамтын ажиллагааг бэхжүүлэх.

13. Үндэсний хууль сахиулах байгууллагуудын хүн худалдах гэмт явдалтай тэмцэх чадавхийг дээшлүүлэх үүднээс шаардлагатай хүний нөөц болон санхүүгийн туслалцаа үзүүлэх

14. Уг зургаан улсууд өөр хоорондоо шүүхийн ажиллагаанд харилцан туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн хоёр талт болон олон талт гэрээг дэмжих.

III. Хамгаалал, нөхөн сэргээлт болон нийгэмшүүлэх чиглэлээр:

15. Хохирогчидтой ажиллахдаа хүйсийн болон хүүхдийн хэрэгцээ, шаардлагад мэдрэмжтэй хандах явдлыг дэмжих.

16. Хохирогчдыг хууль сахиулах байгууллагууд хорих, саатуулахгүй байх баталгаа өгөх.

17. Бүх хохирогчдод орон байр, зохих бие махбодийн, нийгэм-сэтгэл зүйн, хууль зүйн, боловсролын болон эрүүл мэндийн туслалцаагаар хангах.

18. Хохирогчдыг хамгаалах, дэмжих бодлого, механизм бий болгох.

19. Элчин сайдын яамд болон консулын газруудын хохирогчдод тусламж үзүүлэх чадавхийг нь дээшлүүлэх.

20. Хохирогчдын нутагт нь эсэн мэнд буцаан авчрахад чиглэсэн хил дамнасан хамтын ажиллагааг сайжруулах.

21. Хүн худалдах гэмт хэргийн хохирогчид дахин өртөхөөс урьдчилан сэргийлж нөхөн сэтгээлт, нийгэмшүүлэх явцыг үр дүнтэй болгохын тулд хамтран ажиллах.

IV. Урьчилан сэргийлэх чиглэлээр:

22. Эсрдлийг багасгах арга хэмжээ авах, үүнд: ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдийг дэмжих, эдийн засгийн боломжуудыг нэмэгдүүлэх, чанартай боловсрол, мэргэжлийн сургалт хүртэх боломжийг нэмэгдүүлэх, төрсний гэх зэрэг шаардлагатай хууль ёсны баримт бичгээр хангах.

23. Эрсдэлд байгаа хүмүүсийг шуурхай тогтоох, нөлөөлөхөд чиглэсэн хамт олны хамгаалал, хяналтыг дэмжих.

24. Хүн худалдах гэмт хэргийн аюул, сөрөг нөлөө болоод хохирогчдод үзүүлэх туслалцааны талаар нийтэд мэдэлээ, ухуулах кампанит ажил зохиох.

25. Үл ялгаварлах буюу тэгш байдлын зарчимд үндэслэн бүх ажилчдын эрхийг хамгаалах үүднээс хөдөлмөртэй холбогдох үндэсний бүх хуулиудыг хэрэгжүүлэх.

26. Их Меконгийн дүүргээс гаднах буюу эцсийн улс орнуудыг худалдагдсан хүмүүсээр хөдөлмөр эрхлүүлэх эрэлтийг нэмэгдүүлж байдаг хүн мөлжих

явдлыг хүлээн зөвшөөрөх явдлыг багасгах үүднээс үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэх болон хамтын ажиллагааны үндсэн дээр эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдах гэмт хэргийг таслан зогсоох.

27. Хувийн хэвшил, ялангуяа аялал жуулчлал, цэнгээний салбарынхантай хамтран ажиллаж хүн худалдах явдалтай идэвхитэй тэмцэх.

V. Энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийн Хэрэгжилт, Хяналт болон Үнэлгээний чиглэлээр:

28. Хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэх Дүүргийн Үйл ажиллагааны 2005-2007 оны хөтөлбөрийг боловсруулж, үүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авах.

29. Хүн худалдсан тохиолдлуудын талаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх журам боловсруулж, хүн худалдах гэмт явдалтай тэмцэх стратегиудыг бодитой, орчин үеийн туршлага, дүгнэлтэнд үндэслэн боловсруулах.

30. Дор хаяж жил тутмын дээд албан тушаалтнуудыг уулзалт зэрэг энэхүү Харилцан ойлголцлын Санамж бичигт тусгасан үүргийн хэрэгжилтийг ахиц дэвшлийг улс тус бүрээр нь үнэлэх үүднээс Үйл ажиллагааны Хөтөлбөрийг хэрэгжилтийг хянах хяналтын тогтолцоо бий болгох.

31. 2007 оны сүүлээр Үйл ажиллагааны Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, эдгээр зургаан орнуудын сайд нарын уулзалтаар дүүргийн шинэ Үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах.

32. СОММИТ-ийн нарийн бичгийн дарга нарын газар /Их Меконг дүүрэг дэх Хүн худалдах гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Байгууллага хоорондын Төсөл/ болон бусад түншүүдтэй хамтран ажиллах үндэсний ажлын хэсэг байгуулах.

33. Эдгээр 6 улсуудад энэхүү Харилцан ойлголцлын санамж бичгийг болон цаашид батлах Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргээр хүн худалдах гэмт хэрэгтэй тэмцэхэд нь санхүүгийн, материаллаг болон техникийн туслалцаа үзүүлэхэд Засгийн газрын санхүүгийн байгууллагууд болон НҮБ болон бусад Засгийн газар хоорондын болон төрийн бусад байгууллагууд, хувийн хэвшлийг уриалах.

34. Энэхүү Харилцан Ойлголцлын Санамж бичигт нэмэлт өөрчлөлт хийх шаардлага гарч болзошгүйг анхаарч Засгийн газрууд нь энэхүү Санамж бичигт нэмэлт өөрчлөлт хийх дараахь журмыг баталж байна: /1/ Гарын үсэр зурсан зургаан улс орны дөрөв нь уг Санамж бичгийг өөрчлөх шаардлагатай гэж үзвэл Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр хандаж, Нарийн бичгийн дарга нарын газраас зөвлөлдөх журмыг боловсруулна. /2/ уг журмын зохицуулах зүйл нь Санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулах явдал байна. /3/ Санамж бичигт хийх аливаа өөрчлөлтийг бүх зургаан орнууд

дэмжсэн байх ба Засгийн газар тус бүрийн дэмжлэгийг Нарийн бичгийн дарга нарын газарт бичгээр хүргүүлнэ.